



ӨМГӨӨЛЛИЙН ЗАЯА ЭНД ЗОЛОО ХХК

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ЗАХИАЛГААР ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ЭЦСИЙН ТАЙЛАН

2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр

СУДАЛГААНЫ ЗАХИАЛАГЧ:

Цахим хөгжил, харилцаа холбооны яам

СУДАЛГААНЫ УДИРДАГЧ:

Э.Золжаргал (Хуульч, Хууль зүйн ухааны магистр, Судлаач)

СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Э.Золжаргал (Хуульч, Хууль зүйн ухааны магистр, Судлаач)

Н.Болорхүү (Техникийн ухааны магистр, Судлаач)

А.Удвал (Эрх зүйч, Хууль зүйн ухааны бакалавр, Судлаач)

А.Доржсүрэн (Эрх зүйч, Хууль зүйн ухааны бакалавр, Судлаач)

ТӨЛӨВЛӨГӨӨ

АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1. 1 Үнэлгээ хийх шалтгаан
1. 2 Үнэлгээ хийх хүрээ
1. 3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт
1. 4 Үнэлгээний харьцуулах хэлбэр
1. 5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох
1. 6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3. 1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
3. 2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5. 1 Дүгнэлт
5. 2 Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХХЗХ	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
МЦХ	Монголын Цахилгаан Холбоо
ОСДҮЭ	Олон Сувгийн Дамжуулах Үйлчилгээ Эрхлэгчид
РТҮС УТҮГ	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ Улсын Төсөвт Үйлдвэрийн Газар
МХС	Мэдээлэл Холбооны Сүлжээ
ТӨК	Төрийн Өмчит Компани
ХК	Хувьцаат компани
КАТВ	Кабелийн телевиз
IP	Internet Protocol
DVB-C	Digital Video Broadcasting – Cable
DVB-T	Digital Video Broadcasting – Terrestrial
SDI	Serial Digital Interface
AIMS	Alliance for IP Media Solution
ITU	International Telecommunication Union
SMPTE	Society of Motion Picture and Television Engineer
DA	Distribution Amplifier
FTA	Free to Air
EMMC	Electronic Media Monitoring Center
NTRO	National Technical Research Organization, India
CMS	Central Monitoring Service
MPEG4	Moving Picture Experts Group 4
STB	Set Top Box
HD	High Definition
SD	Standard Definition
OECD	Organization for Economic Co-operation and Development
OTT	Over The Top
Оператор	Олон Сувгийн Дамжуулах Үйлчилгээ Эрхлэгчид гэж ойлгоно
CAS	Conditional Access System
MTX	Монголын телевизүүдийн холбоо

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Өргөн нэвтрүүлгийн тухай хууль /цаашид “ӨНТХ” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын /цаашид “Аргачлал” гэх/ дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн ба “төлөвлөх” шатанд дараах ажил хийгдэв.

Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

Гэхдээ үнэлгээ хийх асуудлын онцлогоос хамааран эдгээр алхмуудыг бүгдийг гүйцэтгэх буюу дээр дурдсан дарааллыг ягштал баримтлах шаардлагагүй байж болно.

1.1 Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын Их хурлаас өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2019 онд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баталсан байдаг.

Уг хууль нь өргөн нэвтрүүлгийн салбарын харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх болон уг хуулийн нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд эхлээд үнэлгээ хийх шаардлагатай. Ингэхдээ Засгийн газраас батласан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.2-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд үнэлгээ хийж, болно. Өөрөөр хэлбэл энд заасан нөхцөл байдал үүсээгүй тохиолдолд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагагүй гэсэн үг юм.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр сонгосон Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хувьд: 2020 оны 07 дугаар сараас эхлэн хэрэгжиж эхэлснээс хойш нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан байдаг. Өөрөөр хэлбэл Монголын арилжааны телевизүүдийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн холбоо зэрэг байгууллагаас уг хуулийн хэрэгжилтийн байдлын талаар санал гаргаж байсан тул уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай болсон.

Монголын телевизүүдийн холбоо, Арилжааны телевизүүдийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн холбоо зэрэг байгууллагад төвлөрч буй хураамж, түүний зарцуулалтын байдал үүнээс улбаалан хэрэглэгчдэд чанартай контент хүрч чадахгүй байгаа талаар маргаан гарч байгаа учир Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу уг хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлага тулгарсан гэж үзэж энэхүү судалгааг хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээ тодорхойлох ажиллагаа нь тухайн хуулийн хэрэгжилтэд хамгийн их нөлөөлөл /ерэг болон сөрөг/ үзүүлж буй хэм хэмжээг тусгаарлан сонгох ажиллагаа бөгөөд эдгээрийг хэр оновчтой сонгохоос судалгааны чанар ихээхэн хамаардаг.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийх нь үр дүнгийн хувьд төдийлөн ач холбогдолтой биш байдаг учир тодорхой зохицуулалтыг сонгож авах нь оновчтой юм.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан учир ӨНТХ-ын зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий заалтуудаар үнэлгээний хүрээг тогтоох шаардлагатай байна.

Иймд ӨНТХ-ийн хэрэгжилтийн явцад гарч буй тулгамдсан асуудлыг тодорхойлж, хуулийн зорилтыг хангахад чухал нөлөөтэй, хэрэгжилтийн хувьд маргаан дагуулж буй заалтуудыг сонгон авсан. Тухайлбал ӨНТХ-ын 20.6, 20.5.1, 26.7, 20.1 дэх заалт /цаашид “үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалт гэх”/ болон хамааралтай зарим нэг заалтыг үнэлгээний хүрээнд хамруулахаар тодорхойлсон.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин: Аргачлалын 3.4.1-д заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.
2. Практикт нийцэж байгаа байдал: Аргачлалын 3.4.5-д заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс 3.5.3.1. “байх ёстой болон одоо байгаа байдал” мөн 3.5.3.4. “гохиолдол судлах” хэлбэрүүдийг сонголоо. Учир нь одоо байгаа нөхцөл байдлыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлагатай харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохын тулд “байх ёстой болон одоо байгаа” харьцуулах хэлбэрийг хэрэглэхээр заасан байна.

Мөн Шалгуур үзүүлэлтийн хувьд зорилгод хүрсэн түвшин гэсэн үзүүлэлтийн сонгосон учраас байх ёстой болон одоо байгаа хэлбэрийг сонгож, бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлах үүднээс тохиолдол судлах хэлбэрийг сонгон судаллаа.

1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, заалт тус бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд товч тодорхой томъёолох зарчим баримталж ажиллана.

№	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн холбогдох заалт	Ажиллах хүрээ	Асуулт
	<p>ӨНТХ-ын 20 дугаар зүйл 20.6.Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь энэ хуулийн 20.5.3-т заасан хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна. ӨНТХ-ын 20.7, 20.8,</p> <ul style="list-style-type: none"> ➤ Монголын улсад үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдийн холбооны эрх зүйн байдал, орлого хувиарлалт. ➤ ОСДҮЭ-ийн үйлчилгээний үндсэн багцын ӨНТ-ийн үйлчилгээний орлогын дээд хязгаарыг тогтоох. ➤ Монголын телевизүүдийн холбооны санхүүжилт, түүний хувиарлалтын ил тод байдал. ➤ Орон нутгийн телевизүүд Монголын телевизиудийн холбоонд гишүүнчлэлээр элсэх боломжтой эсэх. ➤ 20.8.Энэ хуулийн 20.5.3-т заасан хөлс нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлогоос хасагдана. 	<p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй телевизүүдийн холбоо түүний эрх зүйн байдлын талаар судлах, Холбоодууд тусдаа байх шаардлагатай эсэх, орлого хувиарлалтын байдал, санхүүжилтийн ил тод байдал зэрэг асуудлыг судлах.</p>	<p>Уг заалтын хэрэгжилтийн түвшин ямар байгаа эсэх.</p>

2	ӨНТХ-ын 20 дугаар зүйл 20.5.1 “техник холболтын зааглах цэг, нөхцөлийг тогтооход Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4-т заасан журмыг баримтлах”, 20.5.4.бусад арилжааны радио, телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан тохиролцох.	Энэ чиглэлийн тодорхой тооны гэрээн дээр судалгаа хийж ажиллах, Техник холболтын гэрээн дээр ажиллах явцад олсон мэдээллүүдийг судлах, Техник холболтын зааглах цэгийг хэрхэн тодорхойлох талаар олон улсын жишиг судлах,	Техник холболтын гэрээ, зардлын хэмжээ өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нарын эрх ашигт нийцэж буй эсэх.
3	Орон нутгийн телевизүүдийн төрийн бодлогоор дэмжих эсэх.	Орон нутгийн телевизүүдтэй холбогдож судлах, бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах.	Орон нутгийн телевизүүд иргэдэд хүртээмжтэй, чанартай мэдээлэл хүргэж буй эсэх.
4	ӨНТХ-ын 26 дугаар зүйл 26.7 Үндэсний олон нийтийн телевиз болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгууд нь олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын эхэнд байна. Олон суваг дамжуулах багцын зохицуулалтын журмын 2.4 сувгийн дараалал.	Сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох боломж, шийдэл байгаа эсэхийг судлах /must curry/.	Уг зохицуулалтын зорилго биелсэн эсэх, оновчтой зохицуулалт мөн эсэх.
5	ӨНТХ-ын 14 дүгээр зүйл 14.1.3.оюуны өмчийн эрхийг удаа дараа зөрчсөн нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тусгай зөвшөөрлийг 90 хоногоор түдгэлзүүлнэ.	Эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан судлах,	Оюуны өмчийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх боломжийн талаар судлах.
6	Зар сурталчилгааны хэтрэлт, шийдэл.	Зар сурталчилгааны хэтрэлт, түүнд авч хэрэгжүүлж буй арг хэмжээг судлах	Бусад улс орны эрх зүйн зохицуулалтыг судлах.
7	ӨНТХ-ын 20 дугаар зүйл 20.1, 20.7 дахь заалт Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын эрх зүйн зохицуулалт.	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч телевизүүдээс судалгаа авах, эрх зүйн зохицуулалт	Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх санг байгуулахад тулгарч буй асуудлыг судлах.

		судлах, бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалт судлах.	
--	--	---	--

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

Энэ үе шатанд ӨНТХ-ын зүйл заалтын зорилгодоо хүрсэн түвшин, түүний практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны ажил уншиж, харьцуулалт хийх, мэргэжлийн холбоод болон хэрэглэгч нартай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх бөгөөд мэдээлэл цуглуулах дараахь аргыг ашигласан болно.

1. Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах: ӨНТХ-д холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, бусад эрх зүйн баримт бичиг, ном сурах бичиг, нэг сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийсэн;
2. Аргачлалын 3.7.3.2-т заасны дагуу Холбогдох субъектээс судалгаа авах: ӨНТХ-ын үйлчлэлд хамаарах байгууллага аж ахуйн нэгжүүд, мэргэжлийн холбоодоос санал авах, фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авах;

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх аргачлалын хүрээнд дараах материалыг цуглуулж үнэлгээг хийсэн болно.

Үүнд:

Хууль, эрх зүйн акт:

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль,
3. Харилцаа холбооны тухай хууль,
4. Олон нийтийн радио телевизийн тухай хууль,
5. Өрсөлдөөний тухай хууль,
6. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал,
7. Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм,
8. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага,
9. ХХЗХ 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 73 тоот тогтоолын хавсралт Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам,
10. ХХЗХ-ны 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага,
11. Өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударгаар өрсөлдөх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам,
12. Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журам,

13. Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам,
14. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны 07 дугаар тогтоолын хавсралт, Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага,
15. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан бусад дүрэм, журам,

Тайлан мэдээ, мониторинг:

1. Хэвлэлийн хүрээлэн, Мэдээлэл судалгааны алба, Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа УБ., 2015 он.
2. Глоб интернешнл, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан., УБ., 2021 он.
3. Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан., УБ., 2021 он.
4. НҮБ-ын хүний эрхийн зөвлөлийн 36 дахь удаагийн тайлан., УБ., 2020 он.
5. Иргэдийн оролцоо төсөл., судлаач Л.Галбаатар нар., Монгол улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь /судалгааны хураангуй тайлан/., УБ., 2021 он.
6. Харилцаа холбооны зохицуулах хороо, Өргөн нэвтрүүлгийн газар., Телевизийн салбарын мониторинг, УБ., 2021 он
7. Максима медиа ХХК., Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан., УБ., 2019, 2020 он.
8. Харилцаа холбооны зохицуулах хороо, Орон нутгийн телевизүүдийн 2022 оны 1 дүгээр улирлын нэгдсэн мониторингийн нэгдсэн дүн.
9. Харилцаа холбооны зохицуулах хороо, Улаанбаатар хотын телевизүүдийн 2022 оны 1 дүгээр улирлын нэгдсэн мониторингийн нэгдсэн дүн.

Судалгааны аргаар мэдээлэл цуглуулсан байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэргэжлийн оролцогчдоос буюу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүд, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид, уг хуулийг хэрэгжүүлж буй эрх бүхий байгуулагуудаас анкетийн болон ярилцлагын судалгаа хийсэн.

Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх явцад Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч зэрэг оролцогчдоос мөн адил аргаар судалгаа авсан болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд үнэлгээ хийх ажлыг эцэслэн, тайлан бичих, үнэлгээний үр дүнг нэгтгэн зөвлөмж боловсруулах ажил хийгдэх ба сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиас сонгож авсан зохицуулалтуудад дараахь байдлаар үнэлгээ хийлээ.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЪЁОЛОЛ НЭГ. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 20 ДУГААР ЗҮЙЛИЙН 20.6 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

3.1.1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс Төрийн эрхийн тухай олон улсын пактад мэдээллийг өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрхтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан байдаг. Үндсэн хуулиар хамгаалагдсан энэхүү эрхийн үндсэн логик бол мэдээллийг нийтэд түгээх явдлыг баталгаажуулах¹ явдал юм.

Ардчилал өндөр хөгжсөн улс орнуудад мэдээлэл ил тод, нээлттэй байх асуудалтай холбоотойгоор олон нийтийн мэдэх эрхийг нилээд ярих болсон. Учир нь мэдэх эрх бол ардчиллын үнэт зүйл бөгөөд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд энэ талаар тусгагдсан² байна.

Монгол Улсын гавъяат хуульч, Хууль зүйн ухааны доктор, профессор Г.Совд “Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь заалтаар баталгаажуулсан иргэдийн мэдэх эрх бол зөвхөн тодорхой хувь хүний эрхийн асуудал төдийгүй нийт хүн амын мэдээлэл хүлээн авах оюуны эрхийг хангахад зориулагдсан нийтлэг ач холбогдолтой³” гэсэн байдаг.

Уг эрхийг баталгаажуулах эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлсэн хууль бол Өргөн нэвтрүүлгийн тухай хууль юм.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн үндсэн зорилтыг “өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон байх бөгөөд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү хуулийн зорилтыг хангаж байх ёстой.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар., УБ., 2000 он., 124 дэх тал.

² Харилцаа холбооны зохицуулах хороо., 2022 он., Зөвлөмж., Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дотоодын болон нийгмийн аюулгүй байдлыг хангах үндэс гэдэгт хүний эрх, эрх чөлөөг хангах, үндэсний эв нэгдлийг сахин дээдлэх, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжих, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн эзэмшил, харьяаллыг ил тод байлгах, үйл ажиллагааны бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байдлыг бий болгох, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах чиглэлийг баримтлахаар тусгажээ.

³ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар., УБ., 2000 он., 123 дахь тал

ӨНТХ-ын 20.6-д “Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна” гэсэн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх буюу байх ёстой болон одоо байгаа байдлын талаар энэ хэсэгт авч үзье.

Монгол Улсын Их хурлаас 2019 онд баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалт нь нийт иргэдийн Монгол Улсын Үндсэн хууьд заасан Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдэх эрхийг⁴ хангах цаашилбал өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудыг санхүүгийн хувьд хараат бус байлгах үндсэн нөхцөлийг бүрдүүлэх зорилготой зохицуулалт юм.

Өөрөөр хэлбэл өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг иргэн бүрт тэгш хүртээмжтэй байлгах⁵ үүднээс санхүүжилтийн байдлыг шийдвэрлэсэн заалт гэж ойлгож болох юм.

Энэ хүрээнд Монголын телевизүүдийн холбоо НҮТББ 2005 оны 05 дугаар сарын 25-ны өдөр “Монголын телевизүүдийн ажлын улдаа холбоог бэхжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, шинэ технологи нэвтрүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, телевизүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилгоор” үүсгэн байгуулагдаж, 2019 онд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдсанаар эрх зүйн байдлын хувьд нийтийн эрх зүйн хуулийн этгээд болж шинэчлэн зохион байгуулагдсан.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь иргэний эрх зүйн чадварын хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу байгуулагдаж, татан буугдсанаар дуусгавар болдог бөгөөд ихэнхи тохиолдолд эрх зүйн тусгай чадвартай байдаг⁶.

Монголын телевизүүдийн холбооны хувьд олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр авсан өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсийг өөртөө төвлөрүүлж хувиарлах үүрэг бүхий субъект билээ.

Монголын телевизүүдийн холбоо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан хэдий боловч тус холбоодод бүртгэлтэй гишүүдэд үзэлтийн судалгааг үндэслэн шударга хувиарлаж чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй юм. Учир нь үзэлтийн судалгаа үүнтэй шууд хамааралтай бөгөөд тус судалгааг хараат бусаар гаргаж чадаж байгаа эсэх нь нөлөөлөх юм.

Мөн тус холбоонд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 18⁷ телевизээс гадна орон нутагт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 62⁸ телевиз харьяалагдаж, Монголын телевизүүдийн холбоонд төвлөрсөн үйлчилгээний хөлснөөс авах ёстой боловч өнөөдрийн байдлаар Монголын телевизүүдийн холбоо, Орон

⁴ МУҮХ-ын 16 дугаар зүйл 17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

⁵ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

⁶ Ё.Кают нар., Монгол Улсын Иргэний хуулийн Шинжлэх ухааны тайлбар., УБ., 2015 он., 49 дэх тал.

⁷ <https://crc.gov.mn/articles/slug56/en>

⁸ <https://crc.gov.mn/articles/slug56/en>

нутгийн телевизүүдийн холбоо гэх байдлаар тус тусдаа бие даасан холбоод байгуулагдаж, орон нутгийн телевизүүд Монголын Телевизүүдийн холбоонд төвлөрсөн үйлчилгээний хөлснөөс авч чадахгүй нөхцөл байдалд байна.

Эндээс үзвэл Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасан “Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна” гэсэн зохицуулалт нь зорилгодоо хүрээгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Иймд уг зохицуулалтын хэрэгжилтийн байдлын талаар практик судалгааг дараагийн хэсэгт авч үзье.

3.1.2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Тулгамдаж буй асуудал 1. ӨНТХ-ын 20.6-д “Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна” гэсэн зохицуулалт практик хэрэгжилтийг авч үзье.

Монголын телевизүүдийн холбоо бол өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч бүх телевизүүдийг өөртөө нэгтгэж орлого хувиарлах эрхтэй байгууллага билээ.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдсанаас хойш Монголын телевизүүдийн холбоо орон нутгийн нийт 52 телевизүүдийг өөртөө нэгтгэсэн боловч үйлчилгээний хөлснөөс орон нутгийн телевизүүдэд хувиарлахгүй байгаа нь гол асуудал болж байна.

Энэ талаар судлаачдын зүгээс мэргэжлийн холбоодоос түүврийн судалгааны аргаар ярилцлага хийж, уг зохицуулалтын практик хэрэгжилтийн талаар судалсан.

Шигтгээ:

... Орон нутгийн телевизүүд төрөөс ямар ч дэмжлэг авахгүй байгаа. Төрөөс дэмжлэг авах асуудлаар Харилцаа холбооны зохицуулах хороонд маш олон удаа хандсан байдаг. Орон нутгийн телевизүүдийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлагаар Орон нутгийн телевизүүдийн холбоо байгуулсан. Монголын телевизүүдийн холбоонд гишүүнчлэлээр орохоор тохиролцсон боловч орлогоо хэрхэн хувиарлах талаар шийдэлд хүрээгүй байна. *(Орон нутгийн телевизүүдийн холбооны тэргүүн Ч.Баярсайхан)*

Монголийн телевизүүдийн холбоо өөрийн дүрэм журамдаа орлого хувиарлах талаар зохицуулсан боловч Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд уг “... үзэлтийн судалгааг үндэслэн хувиарлана” гэж заасныг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

Монголын телевизүүдийн холбоо үзэлтийн судалгааг гаргуулж чадахгүй байгаа учраас орлого хувиарилж чадахгүй нөхцөл үүссэн төдийгүй, орлого шударгаар хувиарлагдаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл үзэлтийн судалгаа гарахгүй байгаа тул Өргөн нэвтрүүлгийн 18 телевиз Монголын телевизүүдийн холбоонд цугларсан үйлчилгээний хөлсийг тэнцүү хуваах байдлаар явж байна.

Орон нутгийн 52 телевизээс Сайхан Монгол ТВ, Төв ТВ, Өндөрхаан ТВ, Хас ТВ зэрэг 10 телевизийг түүвэрлэж сонгон судалгаа явуулахад 10 оролцогч бүгд **Монголын телевизүүдийн холбооноос ямар нэг орлого авдаггүй**, санхүүгийн дэмжлэг авах шаардлагатай байгаа гэсэн хариулт өгсөн байна.

Харин Монголын телевизүүдийн холбооноос одоогийн байдлаар санхүүжилт авч байгаа 18 телевизүүдээс судалгаа авахаар хүргүүлснээс нэр бүхий 2 телевиз судалгаа ирүүлсэн.

Шигтгээ:

Телевизийн үзэлтийн судалгааны хувьд шударгаар гарч чадахгүй байгаа, одоо бол бүр үзэлтийн судалгааг хийж ч чадахгүй байгаа. Максима медиа ХХК хийдэг байсан ч одоо хийхээ больсон. Монголын телевизүүдийн холбоо одоогийн байдлаар өөрт төвлөрсөн үйлчилгээний хөлсийг зөвхөн Өргөний 18 телевиз л тэнцүү хувааж авч байгаа орон нутгийн телевизүүдэд хувиарлах боломжгүй байна.

*Монголын телевизүүдийн холбооны
гүйцэтгэх захирал А.Баярбат*

Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогоос санхүүжиж байгаа бөгөөд хуульд заасны дагуу үзэлтийн судалгааг үндэслэн рейтингээрээ хувиарладаг болох шаардлагатай байна. Судалгаа хийдэг байгууллага одоогоор байхгүй байна.

UBS TB

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний орлогоос санхүүжиж байгаа одоогийн хувиарлалт болж байгаа.

Хорин тав ТВ

Мөн Арилжааны телевизүүдээс судалгаа авахад одоогийн байдлаар 2 телевиз судалгааг бөглөн ирүүлсэн байна.

Телевизийн салбарыг хөгжүүлэх гол тулгуур үзэгчдээсээ татан төвлөрүүлж байгаа бол үзэгчдийнхээ байр суурийг үндэслэн харилцан ялгаатай хувиарлах нь шударга гэж үзэж байна.

Channel 11 TB

Өргөн нэвтрүүлгийн телевиз, Арилжааны телевиз гэж ялгалгүй тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж байгаа бүх телевизүүдээ ижил тэгш хувиарлах нь зөв шийдэл юм.

NTN TB

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид дараах саналыг ирүүлсэн байна.

Шинэ Сансар ХХК	Скаймедиа ХХК	MNBC KATB
------------------------	----------------------	------------------

<p>Одоогоор манай техникийн шийдэлд ийм боломж байхгүй. Ер нь DVB-C DVB-T технологиуд дээр ийм боломж бий. Нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай. Толгой өрөөнд нэмэлт серверүүд, програм хангамжууд суурилуулснаар энэ судалгааг хийдэг технологи байдаг.</p>	<p>Нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай. Манай одоогийн “Middleware” дээр аналитик түүлүүд нэмж авч суулгана гэсэн үг. 1 STB дээрх мэдээлэл дээр анализ хийж болно гэсэн үг. Тодорхой тооны хэрэглэгчүүд дээр лиценз авч</p> <ul style="list-style-type: none"> -сувгийн үзэлт -нэвтрүүлгийн үзэлтүүд дээр үзэлтийн судалгаа хийж болно <p>Тодорхой тооны STB-ууд дээр нийтлэг судалгаа хийж болно.</p> <p>Энэ үед телевизүүд хөтөлбөрийн цагаа баримтлах хэрэгтэй болно.</p>	<p>Манай DVB-T2 үйлчилгээнд бол тийм боломж байхгүй. Харин манай интернэт, Телевиз хосолсон үйлчилгээ болох OTT технологийн “HomeMedia” үйлчилгээнд ийм боломж байдаг.</p>
---	---	--

Эндээс дүгнэн үзвэл Өргөн нэвтрүүлгийн телевизүүд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс авч буй үйлчилгээний хөлсийг Монголын телевизүүдийн холбоонд төвлөрүүлэн телевиз үзэлтийн судалгааг үндэслэн хувиарлаж авахаар зохицуулсан боловч уг заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Телевиз үзэлтийн судалгааг гаргаж чадахгүй байгаа нь үүний гол шалтгаан юм.

Үзэлтийн судалгааны хэрэгцээ шаардлага, харьцуулсан судалгаа: Сүүлийн 10 жилд медиа технологийн хөгжил эрчимжиж, телевиз болон нэвтрүүлгийн тоо нэмэгдэн үзэгч олон сонголтын өмнө очсоноор үзэгчийн хуваагдал ихсэх үзэгдэл явагдаж байгаа нь дэлхийн медиа салбарын зохицуулалтыг улам төвөгтэй болгож байна. Ийм нөхцөлд телевизийн зах зээлийн салбар телевиз үзэлтийн судалгааны ач холбогдол ихсэж байгааг харуулж байна.

Олон улсын медиа салбарт “Audience Research Methods Group” гэсэн байгууллага бий болсон байна. Тус байгууллага 90-ээд оны эхнээс телевиз үзэлтийн судалгаа хийдэг компаниудыг нэгдсэн аргачлалд чиглүүлж, гарч байгаа үр дүн нь харьцуулагдахаар болгосон байдаг⁹.

Дэлхий дээр Телевиз үзэлтийн судалгаа хийдэг хэд хэдэн компани байдгаас Кантар Медиа, Нейлсон хоёр үйл ажиллагааны цар хүрээгээр хамгийн том нь юм. Дэлхийн шилдэг,

⁹ Радио, телевизийн салбарын зах зээлийн нөхцөл байдлын талаарх судалгааны нэгдсэн тайлан УБ., 2017 он.

Телевиз үзэлтийн судалгаа хийдэг TNS компани 2008 онд Кантар Группийн бүрэлдэхүүн хэсэгт орж Кантар Медиа нэртэй болсон бөгөөд өнөөг хүртэл 60 гаруй улс оронд үйл ажиллагаагаа явуулж байна.

Телевиз үзэлтийн судалгааны үндсэн зарчим¹⁰.

- Ил тод, шударга, бүх оролцогчдод нээлттэй. Үүнийг салбар дундын холбоогоор (JIC- Joint Industry Committee) дамжуулж хангаж байна.

- Нэг зах зээл дээр нэг л байна (currency). Хэмжигч субъектууд өөрчлөгдөж болно. Үүнийг тендерээр зохицуулдаг.

- Олон улсын технологи, стандартын дагуу. Энэ хэмжилтийг хийдэг Нэйлсон, Кантар гэх мэт цөөн хэдэн олон улсын байгууллага байдаг.

Тухайн улсын Телевиз үзэлтийн судалгаанд төрийн зохицуулагч байгууллагуудын оролцоо, Joint Industry Committee буюу салбар дундын холбоо байгаа эсэх, түүний үүрэг, тухайн улсад телевиз үзэлтийн судалгааг хэн хийж байна, түүврийн хэмжээ, тархалт зэрэг шалгуураар авч үзвэл Телевиз үзэлтийн хэмжилтэнд төрийн зохицуулагч байгууллагуудын оролцоогоор нь улс орнуудыг гурав бүлэгт ангилж болно.

Нэг: Телевиз үзэлтийн судалгаанд төрийн оролцоо хүчтэй орнууд.

Телевиз үзэлтийн судалгааг төр өөрийн зохицуулагч байгууллага эсвэл төрийн болон ОНТВ-ээр дамжуулан өөрөө санаачлан эхлүүлдэг, гардан хэрэгжүүлдэг туршлага байна. Жишээ нь: Хятадын CSM буюу CCTB болон Английн Кантар Медиа компаниудын хамтран хийж буй хэмжилт, Англид BBC-ын санаачлагатайгаар хийж эхэлсэн хэмжилт, Израйлын Эдийн засгийн яамнаас санаачлан хэрэгжүүлсэн хэмжилт зэрэг жишээг энд дурдаж болно.

Хоёр: Төрийн оролцоо дунд зэрэг орнууд.

Эдгээр улсууд хувийн байгууллагаас гарсан судалгааны үр дүнг Телевиз үзэлтийн судалгааны хэрэглээг зарим нь хуульчилдаг, мөн дэмждэг, үр дүнг нь медиа зохицуулалт, салбарын засаглалын хэрэгжүүлэлт, шийдвэр гаргалтанд ашигладаг. Салбарын зохицуулалттай холбоотой шийдвэрт өрсөлдөөний зохицуулалт, нийгмийн цөөнх, хүүхдүүд гэх мэтийн хувьд медиа контент хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх гэх зэргийг дурдаж болно. Ийм улс орнуудад Joint Industry Committee буюу Салбар дундын холбоонууд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Армен, Украин гэх мэт.

Гурав: Төрийн оролцоо сул.

Телевиз үзэлтийн хэмжилтийг нэвтрүүлэхэд төрийн оролцоог хамгийн бага түвшинд барьж ирсэн маш цөөн орны нэг нь АНУ. Энэ улсад хувийн компани дангаараа Телевиз үзэлтийн судалгааг хийж ирсэн. Өмнөх хоёр хэлбэрээс ялгаатай нь энд Телевиз үзэлтийн судалгааг хуульчилсан, баримт бичигт тусгасан зүйлс байдаггүй. Телевиз үзэлтийн судалгааны мэдээллийг цэвэр арилжааны шинжтэй гэж үзээд хувийн компанид даатгадаг. АНУ-д энэ судалгааг 50 гаруй жилийн туршид Нейлсон хийж байгаа бөгөөд энэ судалгааг

¹⁰ WFA Media Committee, 2001, p. 9

ард олны санаа бодлыг илэрхийлэх томоохон хэмжигдэхүүн гэж үзэн 2005 онд Fair Rating гэсэн хуулийн төсөл боловсруулан хуульчлах санал хүртэл гарч байжээ.

Олон улсуудын жишээн дээр эхлээд төрийн оролцоо нэлээд хүчтэй байснаа дараа нь Телевиз үзэлтийн хэмжилтийг олон нийтийн байгууллага, холбоод руу шилжүүлэх байдлаар явсан түүх харагдаж байгаа юм.

Телевиз медиа салбарын өөрийн зохицуулалтын байгууллагууд

Салбарын өөрийн зохицуултын байгууллага (СӨЗБ) гэдэгт зар сурталчилгаа нийлүүлэгчдийн холбоо, рекламны агентлагуудын ассоциаци, үзэгчдийн холбоо, телевизүүдийн холбоо болон Салбар дундын холбоо (Joint Industry Committee) гэх мэт холбоо ассоциациуд багтдаг бөгөөд эдгээр байгууллагууд олон нийтийн статустай байдаг.

Салбар Дундын Холбоо (Joint Industry Committee): Бүх оролцогч талууд буюу зар сурталчилгаа нийлүүлэгчид, телевиз, агентлагуудыг төлөөлсөн хороо бөгөөд энэ хороо нь үзэгч хэмжилтийн мэдээллийг өмчилж, үүнтэй холбогдолтой шийдвэрүүдийг гаргадаг.

Холбоо байгуулахын гол давуу тал нь GRP (Gross Rating Point)-д суурилсан арилжааны нэгдсэн системтэй байх, зардал хуваах, бүх талын оролцоог хангах, аудитад нээлттэй, хамгийн сайн хэмжилт **судалгааны байгууллагыг тендерээр сонгох боломжтой** гэх мэт маш олон давуу талтай үйл ажиллагаа явуулдаг. (WFA Media Committee, 2001, p. 7)

Салбар дундын холбоодоос тухайлбал Арменд Рекламны зөвлөл, Украйнд Салбар дундын холбоо, Беларусууд Зар сурталчилгаа нийлүүлэгчдийн холбоо (Association of communication and marketing agencies of Belarus)¹¹, Румынд Үзэгч хэмжилтийн Румыны холбоо, Англид¹² телевизүүд болон зар сурталчилгаа нийлүүлэгчдийн холбоог нэгтгэсэн Үзэгч хэмжих өргөн нэвтрүүлэгчдийн холбоо (BARB) зэрэг¹³ байгууллагуудыг нэрлэж болно.

Эдгээр байгууллагуудын гол зорилго нь ТВ медиа салбарын тоглоомны дүрмийг бүрдүүлэх, салбарын оролцогч бүрийн мэргэжлийн сонирхлыг дэмжих, салбарын субъектууд тоглогчдын хоорондын харилцааг зохицуулж, төртэй холбогдох гүүр болдгоос гадна реклам зар сурталчилгааны норм стандартад хяналт тавьж, үзэгчдийн эрх ашгийг хамгаалдаг байна. Тухайн улс орны медиа салбарын хөгжлийн түвшингээс эдгээр байгууллагууд ямар түвшинд хөгжиж, ажилладаг нь хамаардаг.

¹¹ <https://association.by/en>

¹² <https://www.legislation.gov.uk/>

¹³ <https://www.barb.co.uk/news/>

САНАЛ

Үзэлтийн судалгаа хоёр үндсэн зорилгоор хийгдэж байна. Нэг нь ивээн тэтгэгч, зар сурталчилгаа өгдөг газруудын болон Телевизүүдийн дотоод үйл ажиллагаагаа сайжруулах зорилготой маркетингийн чиглэлийн сувгуудын үзэлт, тухайлсан нэвтрүүлгийн үзэлтийн судалгаанд чиглэгдэж байна. Дараагийнх нь хяналт, мониторингийн чиглэлийн хууль, журмын хэрэгжилтийг хангах зориулалттай судалгаа байна. Эхний төрлийн үзэлтийн судалгааг IPTV болон OTT үйлчилгээ эрхлэгч нарын платформ дээр илүү хийх боломжтой юм.

Үзэлтийн судалгааг зөв байгууллага дээр, зөв аргачлалаар яаралтай хийж Телевизүүд болон нэвтрүүлгийн рейтингийг тогтоож явах нь салбарт тулгамдаж байгаа олон асуудлуудыг шийдвэрлэх гарц болох нөгөө талаар Өргөн нэвтрүүлгийн салбарын хөжлийг дэмжих чухал алхам болох нь харагдаж байлаа.

Харин “private” болон “public” сүлжээнд ажилладаг OTT технологийн үйлчилгээнүүд энэ судалгаануудыг хийх бүрэн боломжтой боловч хэрэглэгчдийн ихэнх хувь нь IPTV, DVB үйлчилгээнийх байгаа тул энэ судалгааг авч хэрэглэх талаар зөв эсэхийг нарийвчлан судлах нь зүйтэй юм.

Судалгааны ажлын хүрээнд мэргэжлийн оролцогчдоос ярилцлагын судалгаа хийхэд дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

➤ Монголын телевизүүдийн холбооны санал:

Манай холбоонд өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, орон нутгийн 52 телевизүүд манай гишүүнчлэлтэй байгаа манай байгууллага дүрэмдээ ч оруулсан байгаа.

Үзэлтийн судалгааг үндэслэн мөнгө хувиарлах системийг хамгийн их үзэлттэй бол их мөнгө авна, бага үзэлттэй бол бага мөнгө авна гэж ойлгож байгаа. Хуулиар үзэлтийн судалгааг үндэслэн гэж заасан байгаа учраас хэрэгжүүлэх нь чухал байна. Үзэлтийн судалгаа гаргадаг байгууллага Монголд байхгүй. Орон нутгийн телевизүүдийн хувьд тухайн орон нутгийн нийт иргэдийн хэдэн хувь нь үзэж байгаа гэдгийг гаргаад тэр хувиараа л мөнгөө авах ёстой. Үүнийг гаргах боломжгүй байгаа учраас орон нутгийн телевизүүдэд өгөх боломжгүй байгаа.

Үзэлтийн судалгааг авах талаар олон суваг дамжуулагч нартай холбогдож албан бичиг өгсөн боловч хариу өгөөгүй. Зарим нь техникийн боломжгүй гэдэг, зарим нь хөрөнгө оруулалт хийсний үндсэн дээр гаргах боломжтой гэсэн хариу өгсөн.

*Монголын телевизүүдийн холбооны Гүйцэтгэх захирал
А.Баярбаттай 2023.08.15-ны өдөр хийсэн уулзалтын тэмдэглэлээс ...*

➤ Орон нутгийн телевизүүдийн гал хөгжил холбооны санал:

Монголын телевизүүдийн холбоонд гишүүнчлэлээр орохоор тохиролцсон боловч орлогоо хэрхэн хувиарлах талаар шийдэлд хүрээгүй байна. Монголын олон суваг дамжуулагч нараас үзэлтийн судалгааг аваад эхний ээлжинд тэр судалгаанд үндэслэх боломжтой байгаа гэхдээ олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нилээд хөрөнгө оруулалт хийсний дараа энэ боломжтой болно. Яамны дэргэд хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг судалгааны төв байгуулж бас болно.

Орон нутгийн телевизүүдийн холбооны тэргүүн ...

➤ **Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн санал:**

Дамжуулж буй технологийн онцлогоос хамаарч олон суваг дамжуулах зарим үйлчилгээ эрхлэгчийн зүгээс телевиз үзэлтийн судалгааг гаргах боломжтой, зарим үйлчилгээ эрхлэгчдийн хувьд одоогоор боломжгүй бөгөөд нэмэлт хөрөнгө оруулалт хийсний үндсэн дээр судалгааг гаргах боломжтой.

*Монголын олон суваг дамжуулах
үйлчилгээ эрхлэгчдийн холбоо ...*

➤ **Судалгааны компанийн санал:**

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс судалгааны мэдээллийг авбал энэ нь судалгааны дата болж чаддаггүй. Дэлхийн хэмжээнд телевиз үзэлтийн судалгаа хийдэг 2 томоохон компани байдаг. Манай улсын хувьд ОУ-ын сонгон шалгаруулалт зарлаад олон улсын байгууллагаар судалгааг хийлгэх боломжтой.

Тулгамдаж буй асуудал 2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3-д “... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” заалтын хэрэгжилтийг Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид 2,500 төгрөгийг хэрэглэгчдээс үндсэн багцын төлбөр дээр нэмж авч буй асуудлын хүрээнд авч үзье:

“Зорилгодоо хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3-д “... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” гэсэн заалтын зорилгодоо хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлье.

Энэ хүрээнд Монголын телевизүүдийн холбоо болон Монголын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс судалгаа авахад уг орлогыг Монголын телевизүүдийн холбоонд төвлөрүүлэн хувиарлаж байна.

Шигтгээ:

Телевизийн үзэлтийн судалгааны хувьд шударгаар гарч чадахгүй байгаа, одоо бол бүр үзэлтийн судалгааг хийж ч чадахгүй байгаа. Максима медиа ХХК хийдэг байсан ч одоо хийхээ больсон. Монголын телевизүүдийн холбоо одоогийн байдлаар өөрт төвлөрсөн үйлчилгээний хөлсийг зөвхөн Өргөний 18 телевиз л тэнцүү хувааж авч байгаа орон нутгийн телевизүүдэд хувиарлах боломжгүй байна.

Монголын телевизүүдийн холбоо

Монголын телевизүүдийн холбоонд үндсэн багцын үйлчилгээний үнийн дүнгийн 15 хувийн орлого төвлөрч, түүнийг Өргөн нэвтрүүлгийн телевизүүд хуваан авч байна. /Энэ талаар өмнөх бүлэгт дэлгэрэнгүй судласан/. Үүнээс үзэхэд уг заалт зорилгодоо хүрсэн байна гэж дүгнэж болохоор байна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3-д “... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” гэж заасан байх бөгөөд хэрэгжилтийн хувьд Монголын өргөн нэвтрүүлгийн хэд хэдэн телевизүүд, Монголын орон нутгийн телевизүүдийн холбоо, Арилжааны хэд хэдэн телевизүүдээс судалгаа авсан.

Дээрхи судалгаанаас үзэхэд уг заалтыг өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэх тохиолдол гарч байна. Тухайлбал:

Шигтгээ:

Мөн ӨНТХ-ын 20.5.3-д “... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” гэж заасан байгаа гэтэл олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид үйлчилгээний хөлс дээрээ нэмээд 2,500 төгрөгийг шууд аваад байгаа нь ойлголтын зөрүүтэй байдалд хүргээд байна. Угтаа бол үндсэн багцын үнэд уг мөнгө орох ёстой.

Орон нутгийн телевизүүдийн холбооны тэргүүн Ч.Баярсайхан

Шигтгээ:

ӨНТХ-ын 20.5.3-д “... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” гэж заалтын хувьд ***өргөн сувгийн үйлчилгээ эрхлэгчид чанартай контент хүргэхийн тулд санхүүжилт шаардлагатай болсон. Тийм учраас Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд контентоо олон суваг дамжуулагчдад өгөөд тодорхой хэмжээний төлбөр авах байдлаар буюу энэ хувь хэмжээг нь зааж өгөх байдлаар зохицуулагдсан.*** Ингээд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд бизнесийн хувьд зардал нэмэгдсэн учраас иргэдэд очих контентын төлбөрийн хэмжээ нэмэгдэнэ. Үүнийг тусад нь 2,500 Монголын телевизүүдийн холбоо гээд баримт дээр хэвлээд өгөхөөр иргэд буруу ойлгоод байгаа. Үндсэн багцын үнэд уг мөнгө багтсан байх ёстой.

Монголын телевизүүдийн холбооны гүйцэтгэх захирал А.Баярбат

Шигтгээ:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид үндсэн багцын үнэ дээр нэмж 2,500 төгрөг авч байгаа нь буруу, үндсэн багцын үнэд Монголын телевизүүдийн холбоонд төвлөрүүлэх үйлчилгээний хураамж багтах ёстой.

Хорин тав ТВ асуулгын судалгааны хэсгээс ...

Шигтгээ:

Өргөн нэвтрүүлгийн телевизүүд нь олон суваг дамжуулах үйлчилгээний өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын 15 хувиас доошгүй орлогыг авах нь эцсийн

хэрэглэгчээс авах үйлчилгээний дүн нь нэмэгдэж байгаа бөгөөд Монголын телевизүүдийн холбооноос Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн үйлчилгээний хөлсийг 15 хувиас дээш 100 хувь хүртэл дуртай хувиараа нэмэгдүүлж болох зохицуулалттайг ашиглан нэмэгдүүлэх талаар албан бичиг ирүүлдэг. Манай байгууллагын зүгээс хэрэглэгчдээ төлбөрийн ачаалал нэмэгдүүлэхгүй байх тал дээр анхаарч ирсэн.

*Монголын олон суваг дамжуулах
үйлчилгээ эрхлэгчдийн холбоо*

Эндээс олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс авч буй хураамжийн дээд хязгаарыг тогтоож өгөх шаардлагатайг харж болох юм. Өөрөөр хэлбэл хэрэглэгчийн эрх ашгийн талаасаа хэрэглэгчид улам илүү хохиролтой байж болох юм. Энэ талаар иргэд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт хандаж, Шударга өрсөлдөөнийг хязгаарласан хэрэглэгчид хохиролтой зохицуулалт гэдэг талаар зөвлөмж гарсан байдаг.

Мөн уг заалтын үндсэн агуулгаас үзэхэд Өргөн нэвтрүүлгийн телевизүүд өөрсдийн контентийн төлбөрийг олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс авч байгаа төлбөр гэж ойлгож болох юм. Тийм ч учраас үндсэн багцын үйлчилгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тогтоогдсон байна. Гэтэл шууд хэрэглэгчээс авч байгаа нь уг зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэж байгаатай шууд холбоотой юм.

Уг заалтыг нэг мөр тодорхой болгож аутентик тайлбар хийх, эсвэл хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Тухайлбал: ӨНТгХ-"Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн үндсэн багцын үнэ тариф, нийт төлбөрт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс багтсан байна" гэж шинээр оруулах, эсвэл аутентик тайлбар гаргах, шаардлагатай байна.

Мөн Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3 "... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах" гэсэн заалтын "... 15 хувиас доошгүй ..." гэсэн хэсгийг өөрчлөн дээд хэмжээг тогтоож өгөх санал гаргасан байна.

Эндээс дүгнэн үзэхэд хэдий үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр Монголын телевизүүдийн холбоо авах ч уг мөнгө нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс бус хэрэглэгчдээс гарч байгаа тул уг хувь хэмжээний дээд хязгаарыг тогтоож өгөх нь хэрэглэгчийн эрх ашгийн үүднээс чухал зохицуулалт болох юм.

Тулгамдаж буй асуудал 3. Монголын телевизүүдийн холбооны үйл ажиллагаа болон санхүүгийн ил тод байдлын зохицуулалт, түүний хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ.

“Практикт нийцэж буй байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасан “Холбоо нь энэ хуулийн 20.5.3-д заасан хөлсийг гишүүддээ хувиарлах журам батлаж, орлогын хувиарлалтанд жил бүр аудит хийлгэнэ” гэсэн зохицуулалтын хэрэгжилтийн талаар Монголын телевизүүдийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн холбоо, Өргөн

нэвтрүүлгийн телевизүүд зэрэг байгууллагаас ярилцлага болон анкетын аргаар судалгаа авсан.

Шигтгээ:

<p>ӨНТХ-ийн 20.6-д “Холбоо нь энэ хуулийн 20.5.3-д заасан хөлсийг гишүүддээ хувиарлах журам батлаж, орлогын хувиарлалтанд жил бүр аудит хийлгэнэ” гэсэн заалт нь одоог хүртэл хэрэгжихгүй байна.</p> <p style="text-align: right;"><i>Монголын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбоо</i></p>
--

Шигтгээ:

Монголын телевизүүдийн холбоо	25 ТВ	UBS ТВ
Манай холбоо журмаа баталсан байгаа, энэхүү журмын дагуу мөнгийг хувиарлаад явж байгаа аудит хийлгэдэг.	Орлогын хувиарлалтанд жил бүр аудит хийлгэх нь зөв. Аудитын тайлангийн талаар мэдээлэл тогтмол авч чаддаг.	Энэ талаар нээлттэй мэдээлэл авч чаддаг. Аудит тогтмол хийлгэх нь зөв.

Шигтгээ:

<p>Монголын телевизүүдийн холбоонд удаа дараа шаардлага хүргүүлсний үр дүнд аудитын тайлангаа ирүүлсэн, Монголын телевизүүдийн холбооны тайлангийн ил тод байдлын тухайд хариуцлагын асуудлыг тодорхой болгох шаардлагатай байна.</p> <p style="text-align: right;"><i>Харилцаа холбооны зохицуулах хороотой хийсэн ярилцлагын судалгааны хэсгээс ...</i></p>

Энэ талаар Өргөн нэвтрүүлгийн телевизүүд болон Орон нутгийн телевизүүдээс анкетын аргаар судалгаа явуулахад Өргөн нэвтрүүлгийн 2 телевизээс судалгааг бөглөн ирүүлсэн байна. Уг 2 телевизийн хувьд аудит хийлгэж байгаа энэ талаар мэдээлэл авдаг гэсэн хариултыг өгсөн байна. Харин нийтэд ил тод нээлттэй байх зарчмын хүрээнд Монголын телевизүүдийн холбоо өөрийн сайтад энэ мэдээллийг нийтлээгүй¹⁴ байна.

Эндээс үзвэл Монголын телевизүүдийн холбоо аудитын тайланг хийлгэдэг боловч нийтэд нээлттэй хүргэдэггүй байна.

Өөрөөр хэлбэл Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 62 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмын 4 дүгээр зүйлийн 4.5-д “Монголын телевизүүдийн холбоо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасан аудитын тайланг гарснаас хойш 10 хоногийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлнэ” гэж заасны дагуу аудитын тайланг нээлттэй мэдээлэх үүргээ биелүүлэхгүй байна.

Хууль зүйн хувьд уг заалтын хэрэгжилтийг хангуулах, зөрчигдсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай. Ингэснээр

¹⁴ <https://mtx.mn/>

Монголын телевизүүдийн холбоо орлогын хувиарлалтын аудитын тайланг нийтэд хүргэж уг заалт хэрэгжих юм.

Тулгамдаж буй асуудал 4. ӨНТХ-ийн 20.8.Энэ хуулийн 20.5.3-т заасан хөлс нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлогоос хасагдана гэсэн заалтын

“Зорилгодоо хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-д “Энэ хуулийн 20.5.3-т заасан хөлс нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлогоос хасагдана” гэсэн заалттай холбоотойгоор Татварын харилцааг зохицуулсан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ёстой боловч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд энэ талаар заалт тусгагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд “Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлөх”-өөр заасан байна. Үүнд:

- Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д заасан ногдол ашиг;
- Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого, сангийн хөрөнгө оруулалтын орлого;
- газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого;
- зээлийн батлан даалтын байгууллагын хуульд заасан үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого;
- хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлого;
- төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс Засгийн газарт хуваарилсан ногдол ашиг;
- энэ хуулийн 21.1.4-т заасан орлого олсон албан татвар төлөгч өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас гадаадад шилжүүлэх орлого;
- Боловсролын тухай хуулийн 12.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1-д заасан байгууллагын үйл ажиллагааны орлого;
- ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой олсон аж ахуйн үйл ажиллагааны орлого;
- холбооны гишүүдээс цуглуулсан Сууц өмчлөгчдийн холбооны дүрэмд заасан үйлчилгээний хөлсний орлого болон Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 6.1.7-д заасан санд төвлөрүүлсэн хөрөнгө;
- гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучилсны үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого.
- оюуны өмчийн эрхийн зуучлалаас олсон орлого;
- оюуны өмчийн эрхийг барьцаалсан зээлийн хүүгийн орлого.
- Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого.

Эндээс үзвэл “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.3-т заасан хөлс буюу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлого”-ыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар албан татвараас чөлөөлөх талаар зохицуулаагүй байна.

Хууль зүйн хувьд татвараас чөлөөлөгдөхгүй байгаа учир шалтгааныг тодруулбал:

Татварын Ерөнхий хуулийн 3.2-т “Энэ хуулиар зохицуулаагүй, эсхүл энэ хуульд зааснаас өөрөөр татварын бусад хуульд заасан бол **тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан татварын хуулийн зүйл, хэсэг, заалт давуу үйлчилнэ**” гэж заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг баримтлах бөгөөд тус хуульд Монголын телевизүүдийн холбоонд төвлөрч буй үндсэн багцын үйлчилгээний төлбөрийг татвараас чөлөөлөхөөр заагаагүй тул уг орлого татвараас чөлөөлөгдөх боломжгүй байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-д “Энэ хуулийн 20.5.3-т заасан хөлс нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлогоос хасагдана” гэсэн заалт өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй. Учир нь холбогдох татварын хуульд өөрчлөлт ороогүйгээс олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид татварыг нь төлж байна.

*Монголын олон суваг дамжуулах
үйлчилгээ эрхлэгчдийн холбоо*

Татварын Ерөнхий хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд холбогдох зохицуулалт ороогүй учраас бид уг орлогыг татвараас чөлөөлөх боломжгүй байна.

Татварын Ерөнхий газар

Үүнээс үүдэн уг зохицуулалт зорилгодоо хүрээгүй байна гэж дүгнэж байна. Аливаа эрх зүйн асуудлыг тодорхой бие даасан хуулиар зохицуулж байгаа тохиолдолд холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах нь эрх зүйн системчлэлийн хувьд зайлшгүй чухал зүйл байдаг.

Иймд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.3-т заасан хөлс буюу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлого” гэж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалт буюу тохиолдол судлах.

Америкийн нэгдсэн Улс

АНУ нь холбооны болон муж улсын түвшинд олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад шууд төсөв төсөвлөдөг ба гол төлөв хэвлэлийн байгууллагуудыг холбооны болон муж улсын түвшинд тодорхой татвараас чөлөөлөн дэмжлэг үзүүлдэг.

Гол төлөв хэвлэлийн байгууллагуудыг холбооны болон Муж улсын түвшинд тодорхой татвараас чөлөөлдөг. Жишээлбэл, Орлогын албан татвар, зар сурталчилгааны орлого гэх мэт¹⁵.

Швед болон Норвеги

Швед болон Норвеги улсуудын хувьд татаас нь шууд болон шууд бус хэлбэртэй байх бөгөөд шууд бус татаасын хүрээнд НӨАТ-аас тодорхой хэмжээгээр хөнгөлдөг байна. Мөн түүнчлэн үндэсний хэл, соёл, цөөнхийн эрх ашгийг хамгаалах, техник технологийн хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулан шууд зорилтод татаасыг хэвлэл мэдээллийн байгууллагадаа олгодог байна.

Дээрхи улс орнуудын хувьд ихэвчлэн сонин болон сэтгүүлийн захиалга нь албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд орж байна.

¹⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн., Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төслийн судалгаа.

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЬЁОЛОЛ ХОЁР.
ТЕХНИК ХОЛБОЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ**

Техник холболтын цэг.

Техник холболтын цэгтэй холбоотой зохицуулалтын хувьд Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд дараах байдлаар зохицуулсан байна.

Үүнд: 20,5,1 “техник холболтын зааглах цэг, нөхцлийг тогтооход Харилцаа холбооны тухай хуулийн 9,1,4-д заасан журмыг баримтлах”,

20,5,4 бусад арилжааны радио, телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан тохиролцох

Энэ чиглэлээр нийт ОСДҮЭ Шинэ Сансар ХХК, Скаймедиа ХХК, MNBC Кабелийн Телевиз нартай, ӨН-ийн болон Арилжааны Блумберг, LIVE, UBS, SBN, Mongol ТВ, Гал хөгжил холбоо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Телевизүүдийн удирдлагууд техник хариуцсан захирлуудтай уулзалт хийсэн бөгөөд дээрх байгууллагууд дараах байр суурьтай байна.

Шинэ сансар ХХК	Скаймедиа ХХК	MNBC КАТВ
Бид дундын холболтын цэгээ баримталдаг. Энэ асуудал дээр Телевизүүдтэй маргаан гардаг. ОСДҮЭ-ид бид сүлжээний ашиглалт үйлчилгээ хариуцдаг субъект биш юм. Бид бол Б зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч. Бид А зөвшөөрөлтэй компаниар дамжуулж телевизүүдтэй үйлчилгээ үзүүлдэг. Телевизүүд манай компанитай холбогдохдоо дунд нь А зөвшөөрөлтэй дамжуулалтын компани байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй байдаг. Танайх үүнийгээ хариуцах ёстой гэж шаардлага тавьдаг. Манайх бол Б зөвшөөрөлтэй	Бид телевизүүдтэй хоёр төрлөөр холболтын гэрээ хийж байгаа. Нэг. Телевизүүд бидэнтэй өөр гуравдагч дамжуулалтын компаниар дамжуулж холбогдож байгаа. Жишээ нь МХС, Скайнетворк, Мобиком гэх мэт. Хоёр. Манайтай шууд гэрээгээр ажиллавал бид ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллана гэсэн үг. Энэ үед Скайнетворк болон А зөвшөөрөлтэй Скайстрим гэдэг компаниудаар холболтоо хийдэг. Энэ үед Телевизүүдтэй хийдэг гэрээ нэг л байдаг. Өөр асуудал байдаггүй.	Аль нэг Телевиз манайтай холбогдоход шилэн кабелиар дамжуулах бол сүлжээний бизнес эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй компаниар хийлгүүлдэг ба зардлыг нь Телевиз хариуцна. Ашиглалтыг тэр компани хариуцна. Энэ тохиолдолд зааглах цэг манай оролт дээр байна гэсэн үг. Мөн бид өөрийн бизнесийн хүрээнд шилэн кабель өөрсдөө татсан тохиолдлууд бий. Бид сүлжээ компаний сувагчлалыг ашиглаж тэдэнд түрээсээ төлөн ашиглалтаа бид хариуцан ажиллана.

учир Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх эрхгүй юм.	Дундын холболтын цэгтэй болно гэж дээр үед ярьж байсан боловч хэн хийх нь тодорхойгүй байснаас орхигдсон байх.	
---	--	--

Телевизүүдийн байр суурь.

Блумберг ТВ	LIVE TV	UBS TV
<p>Холболтын гэрээ, зааглах цэгийг тодорхой болгох талаар ХХЗХ дээр олон удаагийн уулзалтууд хийж байгаа. Ийм боловч үр дүнд хүрэхгүй байна. Оператор компаниуд Телевизээс оператор компани хүртэлх зардлаа өөрсдөө даа гэдэг. Оператор компаниуд Телевизээс оператор компани хүртэлх зардлаа өөрсдөө даа гэдэг. ХХЗХ-оос журамдаа зааглах цэг гаргачихаад тэр нь тодорхойгүй байдаг. Тодорхойлохдоо илүү операторуудад илүү боломж гаргаж өгдөг. Яагаад гэвэл зааглах цэгээ операторууд өөрсдөө тодорхойлдог учир тэд өөрсөдөө ашигтай нөхцөл гаргадаг.</p>	<p>ӨН-ийн хууль гарахаас өмнө техник холболтын гэрээгээ оператор компаниуд бидэнд тулгадаг байсан. Үүнээс хоойш журам гараад зааглах цэгийг тодорхойлж өгсөн. Манай контентыг үнэгүй авдаг мөн хэрэглэгчээс төлбөр авдаг ийм дэлхийд байхгүй жишиг тогтсон байна. ӨН-ийн тухай хуульд телевиз нь ОСДҮЭ-дийн сүлжээнд холбогдох, хөтөлбөр дамжуулахад дараах зарчмыг баримтална гэсэн байгаа.</p> <p>20.5.4.бусад арилжааны радио, телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан тохиролцох.</p> <p>Үүнээс харахад ӨН-ийн Телевизүүдээс төлбөр авахгүй харин Арилжааны Телевизүүдтэй харилцан тохиролцоно гээд орхисон байгаа нь өнгөрсөн 2-3 жилүүдийн маргаан үүсэх нөхцөл болж ирсэн.</p>	<p>Анх оператор компаниуд өрсдөө бидэн дээр ирж холболтын бүх асуудлыг хариуцаж гарсан зардлуудыг өөрсдөө даадаг байсан. Хууль гарч ӨН-ийн Телевизүүд нь үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авдаг болсноос хойш Телевизүүдээс төлбөр янз бүрээр нэхэж авдаг болсон. Мөн энэ төлбөр нь Телевизээс оператор хүртэлх зардлыг хамардаг болсон.</p> <p>UBS телевиз РТҮСГ-ийн 16 телевизүүдийн цацалтад хамрагдахгүй байгаа. Анх төлбөрийн үнэ ихтэй байсан тул тэндээс гарсан одоог хүрч байна. РТҮСГ одоо ӨН-ийн Телевизүүдийн тоо нэмэгдсэн учир ӨН-ийн агаарын цацалтын сувгийн тоогоо нэмэх ёстой.</p>

		Техник холболтын хувьд ХХЗХ-ны журамд заасан зааглах цэг, дундын холболтын цэг дээр асуудалгүй бид операторуудтай харилцан тохиролцоод явдаг.
<p>Төлбөрийн талаар: Шударга өрсөлдөөний газраас ӨН-ийн хууль нь өрсөлдөөнийг хязгаарласан хууль гэж дүгнэлт гарсан. Иймд ХХЗХ-оос ТВ ОСДҮЭ нарт гэрээг үргэлжлүүлэн хийхийг түдгэлзүүлсэн байгаа. Иймд бүх арилжааны Телевизүүд гэрээ байгуулахгүй байгаа. Монсат эхлээд төлбөр нэхэж байсан. Дараа нь танайхыг төлбөргүйгээр MOTV үйлчилгээндээ авъя гэж гуйсан байгаа. Сансар операторын хувьд манайх танайтай STBS гэдэг дамжуулалтын компаниар дайруулж холбогдоно гэсэн. Энэ тохиолдолд сарын 200 мянга орчим төгрөгийн төлбөр гарна гэсэн. Мөн Юнивижн Ддиш хоёр нэг зааглах цэгтэй мөртөө төлбөрийг давхардуулан авах гэдэг.</p>	<p>Төлбөрийн талаар: Манайхаас Юнивижн сарын 1 сая 600 мянга, жилийн 20 сая төгрөг авдаг. Операторууд бидэнд зааглах цэг хүртэлх болон өөрсөд дээрээ ирэх дамжуулалтын үнээ хэт өндрөөр тооцдог. Маш их зардлыг бидэнд тохдог. Жишээ нь Монсат HD дохиогоор дамжуулахад 750 мянга, SD дохиогоор дамжуулахад 350 мянган төгрөг нэхсэн.</p> <p>Зарим хувийн компаниуд энэ үйлчилгээг чинь авъя гээд зардлын тооцоо гаргахад (Медиапро, Сансар кабель) 150 мянга орчим төгрөгийн зардал гаргасан. Харин Юнивижн бүгдийг нь хариуцъя гэсэн боловч 350 мянга орчим үнэ өгсөн нь ашиг их нэмсэн үнэ болж таарч байна. Зааглах цэг дээр тавьж байгаа үнэ ашиг шингэсэн үнэ байгаа гэж үзэж байна. Бид Юнивижнд жилийн 20 сая, Ддиш-д жилийн 33 сая төгрөгийн төлбөр төлдөг. Сансар</p>	<p>Төлбөрийн талаар: Манай UBS, Глобал, Өлзий Телевизүүд бүгд дараахь операторуудад төлбөр өгч холболтоо хийж байгаа. Юнивижн, Ддиш, Скаймедиа, MNBC, Сансар, National, Монсат. ӨН-ийн UBS Телевиз манай арилжааны Өлзий, Глобал телевизүүд операторуудтай ойролцоо төлбөр төлж байгаа.</p>

	кабель бол гайгүй. Сарын 128 мянган төгрөг өгдөг.	
--	---	--

SBN TV	МОНГОЛ ТВ	Гал Хөгжил Холбоо
<p>Юнивижн Ддиш гэсэн хоёр оператор компанид сар бүр өндөр төлбөр тус бүр төлж холбогдож байгаа. Үүнийгээ засвар үйлчилгээний зардал гэж хэлээд гэрээ байгуулж байгаа. Төлбөрийн задаргаагаа өгнө үү гэхэд тийм шаардлагагүй гэдэг.</p> <p>Бусад операторууд болох Сансар, Монсат, National, MNBC нарт төлбөр өгөхгүй гаргаж байгаа. Эдгээр компаниуд шилэн кабелийн холболтын зардлуудаа өөрсдөө дааж байгаа байх.</p> <p>ХХЗХ хоорондоо зохиц гэсэн байдалтай байна.</p> <p>Бид өөрсдөө Телевизүүдийн холбоон дээрээ өөрсдийн зааглах цэгтэй болох гэж ярьсан боловч бүтэхгүй байгаа. Бусад операторууд төлбөр авахгүй гаргаж байгаа.</p>	<p>Зааглах цэгийн хувьд бид бол контент үйлдвэрлэгчид, хүргэлтийг ОСДҮЭ хийх ёстой. Бүх гэрээнүүд дээр манай ТВ дээр зааглах цэгүүд байгаа гэж заагдсан.</p> <p>ТВ Холбоо өөрсдийн 18 сувгийн нэгдсэн цэг нээе, өөрсдийн нэг ёсны ОСДҮЭ үйлчилгээ хийе гэсэн. Ингээд ЗХ энэ ажил руу орж ирсэн.</p>	<p>ОН-ийн ТВ-үүд жишээ нь Юнивижн, Ддиш операторуудтай гэрээ хийхгүй удаж байна. Учир нь зааглах цэгийн асуудал байгаа юм. Орон нутгийн КАТВ-үүд, РТСГ, Юнивижн, Ддиш, Дархан, Эрдэнэт хотод бол Скаймедиа эдгээр бүх операторуудад тус тусдаа холбогдоход зардал ихээр гардаг. Орон нутагт төвлөрсөн нэг зааглах цэгтэй болгож өгөөч гэсэн саналуудыг бид тавьж байгаа.</p> <p>Мөн ОН-ийн ТВ-ээс тухайн аймаг сумын зааглах цэг хүртэл бид холболтын зардлаа хариуцаж төлдөг байтал үүнээс цааших зардлуудыг бас бидэнд үүрүүлэх гэдэг.</p>
<p>Төлбөрийн талаар: Юнивижн, Ддиш гэсэн хоёр оператор компанид сар бүр 900 мянга орчим төлбөр тус бүр төлж байгаа. Бусдад нь төлөхгүй байгаа.</p>	<p>Бид арилжааны ТВ-үүдтэй. Эдгээр нь ОСДҮЭ-дэд төлбөр төлдөг. Үндсэн суваг бол төлдөггүй. Хуулинд ӨН-ийнхэн төлбөр төлөхгүй гэсэн заалт бий.</p>	<p>Юнивижн, Ддиш гэхэд нэг компани мөртлөө тус тусдаа 1 сая төгрөг авна гэдэг. Голдуу Юнивижн, Ддиш операторууд дээр өндөр төлбөрийн гол асуудлууд байдаг.</p>

		<p>ОСДҮЭ болгон энэ төлбөрийг авах гэдэг. Үзэгчдээс мөнгө МТХ мөнгө авдаг болсны дараа ОСДҮЭ-ид гэрээнд заасан төлбөрийг огцом нэмсэн. Жишээ нь 400 мянга байсан төлбөр нэг сая болтлоо нэмэгдсэн. Гадны контент сувгуудийг бол мөнгө төлж худалдаж аваад дамжуулдаг. Биднийг болохоор өндөр төлбөр төлүүлж холбодог жишиг байна.</p>
--	--	---

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ГЭРЭЭНҮҮДИЙН БАЙДАЛТАЙ ТАНИЛЦСАН

Дараах линкэнд ХХЗХ-ны вэбсайт дээрх Радио Телевизийн ОСДҮЭ нарын гэрээний баталгаажуулалт болон гэрээний жагсаалтуудыг харуулсан¹⁶ байна.

Одоогийн байдлаар нийт 11 ОСДҮЭ байгаагаас гэрээний баталгаажилт (РАО) хийгдсэн 9 байна. Үүнд Скаймедиа ХХК, Монголсат нэтворкс ХХК, Эн Би Си ХХК (MNBC), Сансар дижитал ХХК, Шинэ сансар кабель ХХК, Оптимум нэтворкс, ХХК, Талст эрчим ХХК, Мобинэт ХХК, Монголын цахилгаан холбоо ХКомпаниуд орж байна. Харин Юнивишн ХХК, ДДэшТВ ХХКомпаниуд одоогоор баталгаажилт нь хийгдээгүй байна.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ГЭРЭЭНҮҮДИЙН БАЙДАЛТАЙ ТАНИЛЦСАН

ОСДҮЭ-ийн нэрс	Зааглах цэгийг тодорхойлсон байдал	Сүлжээнд холбогдох анхны холболтын хураамж	Телевизийн суваг дамжуулах сарын хураамж	Тайлбар
Скаймедиа ХХК	Зааглах цэгийг 1. Дамжуулагчийн өөрийн шилэн кабель ашигласан тохиолдолд Тв-ийн байранд, 2. ТВ-ийн шилэн кабелийг ашигласан тохиолдолд дамжуулагчийн байранд гэж гэрээнд заажээ.	33 сая төгрөг.	Зааглах цэгийг 1. Дамжуулагчийн байранд бол 500 мянган, 2. Тв-ийн байранд бол 300 мянган төгрөг гэж заасан.	Төлбөрийн задаргааг нарийвчлан тусгасан байна.
Монголсат нэтворкс ХХК	Байршил 1. ТВ-ийн байр, Байршил 2. Дамжуулагчийн	SDI оптик кабелийн трансмиттер 2.2 сая, холболт	Кабелийн А/Ү-ний төлбөр 700 мянга, ТВ суваг өөрөдөө хариуцаж бгаа бол	Төлбөрийн задаргааг нарийвчлан

¹⁶ <https://www.crc.gov.mn/list/harilcan-holbolt/mn?show=225>

	байр, 3. Орон нутгийн ТВ-ийн холболт гэж тус тус заасан.	300 мянга, HD дамжуулалт лиценз 9,5 сая төгрөг.	энэ нь 300 мянга, HD дамжуулалт лиценз 1 539 000 төгрөг.	тусгасан байна.
Эн Би Си ХХК (MNBC)	Зааглах цэгийг 1. Дамжуулагчийн өөрийн шилэн кабель ашигласан тохиолдолд Тв-ийн байранд, 2. ТВ өөрөө дамжуулагчийн байранд холбогдох үед дамжуулагчийн байранд, 3. Дундын холболтын цэгээр дайрах үед дундын холболтын төвийн гаралтан дээр гэж заажээ.	16,5 сая төгрөг.	1 ба 3- нөхцөлд 725 мянган төгрөг, 2-р нөхцөлд 400 мянган төгрөг.	
Сансар дижитал ХХК	Зааглах цэгийн байршлыг зөвхөн Сансар кабель ХХК байр, "Эс Ти Би Эс" ХХК-ийн Optic receiver. Optic transmitter гэж заасан.	Талууд зааглах цэгээс 2 тийш өөрсдийн сүлжээ, ашиглалт үйлчилгээг хариуцах ба харилцан төлбөр төлөхгүй болно.	Талууд зааглах цэгээс 2 тийш өөрсдийн сүлжээ, ашиглалт үйлчилгээг хариуцах ба харилцан төлбөр төлөхгүй болно.	
Шинэ сансар кабель ХХК	Зааглах цэгийн байршлыг зөвхөн Сансар кабель ХХК байр, "Эс Ти Би Эс" ХХК-ийн	Нийлүүлэгч нь энэхүү гэрээний хүрээнд суваг дамжуулалтын төлбөр	Нийлүүлэгч нь энэхүү гэрээний хүрээнд суваг дамжуулалтын төлбөр төлөхгүй	

	Optic receiver. Optic transmitter гэж заасан.	төлөхгүй гэсэн заалттай байна.	гэсэн заалттай байна.	
Оптимум нэтворкс ХХК	МҮОНРТ дотор байрлах Радио Телевизийн Үндэсний сүлжээний байр буюу УКВ гэж заасан.	Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студиес зааглах цэг хүртэлх сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэргийг хариуцсан тохиолдолд дамжуулагч тал төлбөр авахгүй болно.		Төлбөр тооцооны талаар өөр мэдээлэл байхгүй.
Талст эрчим ХХК	ОТТ Нэтворк ХХК-ны байр, Сансар КаТВ-ын байр	ТВ нь өөрийн студиес зааглах цэг хүртэлх сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэргийг хариуцсан тохиолдолд манай компани телбер авахгүй болно.		Төлбөр тооцооны талаар өөр мэдээлэл байхгүй.
Мобинэт ХХК	“Талуудын холболтын зураглал, ачаалал дамжуулах замууд нь Хавсралт 2-т			Төлбөр тооцооны талаар өөр мэдээлэл байхгүй.

	заасны дагуу байх ба ..." гэж заасан боловч хавсралтад байхгүй байсан.			
Монголын цахилгаан холбоо ХК	ТВ-ийн студи дээр байрлах HD-SDI 2 төхөөрөмж гэж заасан. Зураглалтай.		Худгийн урт: 2300. Эхний 1 км 100,000+Дараагийн метр тутамд 30 төгрөг, Худгийн тоо: 46 нэгж үнэ: 1000 төгрөг гэх мэтээр заасан.	

ОСДҮЭ-ид болон Телевизүүд хоорондоо холболт хийхдээ “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын дагуу хийгдэж байна. Журамд шаардлагатай мэдээллүүд орсон, мөрдөж ажиллавал заалтууд нь тодорхой заагдсан байна.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооноос Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд зориулж, сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO) боловсруулах зөвлөмжийг гаргасан бөгөөд ЗХ-ны вэбсайт дээр тавигдсан байна.

Үүнд:

Нэг. Харилцан холболтын журмыг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс.

Хоёр. сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл (RAO) боловсруулахад анхаарах зүйлс.

Гурав. ОСДҮЭ болон Телевизийн холболт, дамжууллын гэрээний загвар зэргийг тусгажээ. Энэ хэсэгт зааглах цэгийн байршил, холболтын зураг зэргийг заавал тусгахыг заажээ.

Үүний дагуу тус вэбсайт дээр ОСДҮЭ нарын ирүүлсэн гэрээг баталгаажуулж бүртгэж авсан байна. Одоогийн байдлаар нийт 11 ОСДҮЭ байгаагаас гэрээний баталгаажилт (RAO) хийгдсэн 9 байна. Юнивижн ХХК, ДДэшТВ ХХК нарын гэрээ баталгаажуулж байна.

Журмын хавсралт 1-ийн 4 дэх заалтыг товч энгийн байдлаар хийсэн бол Телевизийн удирдлагууд ойлгоход дөхөм байжээ. Заалтад холболтууд 4 хэлбэрээр хийгдэхээр заагдсан боловч практик дээр ихэнхдээ 2 хэлбэрээр нь хийгдэж байна.



Зураг 1. Журмын хавсралт 1-ийн 4 дэх заалтад тусгаснаар



Зураг 2. Практик дээр холболт хийгдэж байгаа байдал

Зураг 2-ын хоёр дахь холболтын үед Гэрээний загварын 2.2 дахь, Зааглах цэг: 2.2.1 дэх “Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна” гэсэн заалтыг амьдрал дээр Операторууд мөрдөх боломжгүй байна. Учир нь 3-дагч компаниар холболт хийгдсэн үед зааглах цэгийг дамжуулагч тал хариуцах боломжгүй байгаа нь харагдаж байна.

Дөрөв дэх заалт болон зургийг доор үзүүлэв.

Дөрөв. Олон суваг дамжуулах болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгчийн сүлжээнд холбогдох зааглах цэг


4.1. Радио, телевизийн үйлчлэгч болон олон сувагийн дамжуулах үйлчлэгч хооронд эсхүл радио, телевизийн үйлчлэгч болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгч хоорондын холболтын зааглах цэг нь холболтын төрлөөс хамааран дараах байршлуудын аль нэг дээр байна. Үүнд:

4.1.1. Телевизийн үйлчлэгчийн гаралтын дохиог дамжуулах төхөөрөмж;

4.1.2. Олон суваг дамжуулах болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгчийн хүлээн авах төхөөрөмж;

4.1.3. Олон суваг дамжуулах болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгчийн хүлээн авах талын хувиргах төхөөрөмж (encoder);

4.1.4. Дундын холболтын цэг (Гуравдагч этгээдийн сүлжээгээр дамжин холбогдох тохиолдолд);



Операторууд тарифаа тогтоохдоо гол зардал болох шилэн кабелийн түрээс учир км тутамд тооцдог аргачлал зүгээр байна. Ингэхдээ инфляцаас шалтгаалж тоног төхөөрөмжийн болон кабель бусад зардлууд өсөх магадлалтай тул үүнийг тооцож журманд оруулахыг анхаарах нь зүйтэй.

Зарим ОСДҮЭ-ид Телевизүүд болон ОСДҮЭ нарын холболтыг “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн ангилалд”заасан тусгай зөвшөөрөлтэй компаниуд хийх ёстой учир бид үүнийг баримталж үйл ажиллагаагаа явуулж байгаа гэж тайлбарлаж байна. ЗХ-ноос тодруулахад ийм заалт байхгүй байгаа нь тодорхой болсон.

Иймд урьдчилсан тайланд тусгасан энэ хэсгийн хавсралтыг хассан болно.

ХХЗХ энэ жил ОСДҮЭ-ид болон Телевизүүдийн холболтын асуудал, зааглах цэг, үнэ тарифыг шийдвэрлэж ажлын хэсэг гарган ажиллуулж байгаа ба одоогоор ажлын хугацааг нь сунгасан байдалтай байна. Дараахь асуудлаар тэдний дунд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг авч ажлыг явуулж байна.

“Олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээнд холбогдох зааглах цэгийг 4 байришлд, ОСДҮЭ-ийнбуюу сүлжээ эрхлэгчийн талд тогтоох.

ОСДҮ-ний зааглах цэгээс 2 тийш тус тусын зардлыг хариуцах.

Зааглах цэг дэх болон зааглах цэгээс хэрэглэгч хүртэлх өртөг, зардлыг ОСДҮЭ хариуцах.

Техник холболтын гэрээнд шилэн кабелийн түрээсийн зардлыг оруулахгүйгээр, гэрээлэгч талууд тохиролцож тусдаа гэрээгээр зохицуулах”.

Төлбөрийн талаар:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.2-т л зөвхөн Олон нийтийн радио, телевизийн үндсэн суваг болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан төлбөр төлөхгүй зарчмаар холбогдох гэж заасан байгаа болохоос биш ӨН-ийн Телевизүүд төлбөр төлөхгүй гэсэн заалт байхгүй байгааг зарим ОСДҮЭ нар болон Арилжааны Телевизүүд мэдээгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа нь харагдаж байлаа. Зарим ОСДҮЭ-д мөн бид ӨН-ийн Телевизүүдээс хуулиараа төлбөр авдаггүй гэсэн ойлголттой байсан. Гэхдээ ихэнх ОСДҮЭ-ид нийтээр нь төлбөр авч байгаа.

Ялангуяа Арилжааны Телевизийнхэн ӨН-ийн Телевизүүдээс төлбөр авдаггүй манайхаас болохоор авдаг гэсэн маргаан гаргадаг байна.

Мөн төлбөрийн талаар гардаг маргаануудын шалтгаан нь операторууд хэт өндөр төлбөр тавьдаг, үйлчилгээний өртөгт нь ашиг ихээр нэмсэн байдаг гэсэн асуудлууд байна.

Дээр дурдсан ХХЗХ-ны вэбсайтад баталгаажсан гэрээнүүдийн харьцуулалтаас харахад шилэн кабелийн түрээсийн зардлыг түүний уртаар жишээ нь эхний км-ийн үнэ, дараагийн км бүрт тогтоосон үнийг баримталбал нийт гэрээ байгуулагчдад жигд үнийн төлбөр тогтоох боломжтой байна. Үүнээс гадна 3-дагч компаниар холболтыг хийлгэсэн тохиолдолд Телевиз үүнийгээ тусдаа гэрээгээр зохицуулж болох ба гэрээ хийх зөвлөмжид тусгаж өгөх нь зүйтэй саналтай байна. Энэ компани ихэвчлэн энэ төрлийн үйлчилгээг үзүүлдэг компани байх учир дээрх км-ээр тооцсон тарифаас хол зөрөхгүй юм.

Харин Орон нутагт Телевизийн үйлчилгээ эрхлэгчийн санхүүгийн боломжийг харгалзан тухайн хот, аймаг, сумын төвд нэгдсэн нэг холболтын цэгт тулгуурлан холболтоо хийдэг байх нь зохимжтой байна. Шалтгаан нь Телевизүүд цөөхөн, мөн цөөн тооны ОСДҮЭ-дтэй холбогдоно, газар нутгийн хувьд зай бага учир холболтын зардал бага гарна, мөн төрийн өмчийн мэдээлэл холбооны салбаруудыг түшиглэн энэ ажлыг зохион байгуулахад хүндрэл бага гарах юм. Ингэснээр орон нутгийн Телевизүүдэд оногдох холболтын зардлууд эрс буурах юм.

ДҮГНЭЛТ

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид болон Телевизүүд хоорондоо холболт хийхдээ “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг баримталж байна. Журамд шаардлагатай мэдээллүүд орсон, мөрдөж ажиллавал зохих заалтууд нь тодорхой заагдсан байна.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооноос Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд зориулж, сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO) боловсруулах зөвлөмжийг гаргасан бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны вэбсайт дээр тавигдсан байна. Харилцан холболтын журмыг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлсийг тайланд оруулсан.

Үүнд: “Харилцаа холбооны зохицуулах хорооны вэбсайтад баталгаажсан гэрээнүүдийн харьцуулалтаас харахад шилэн кабелийн түрээсийн зардлыг түүний уртаар жишээ нь эхний км-ийн үнэ, дараагийн км бүрт тогтоосон үнийг баримталбал нийт гэрээ байгуулагчдад жигд үнийн төлбөр тогтоох боломжтой байна. Үүнээс гадна гуравдагч компаниар холболтыг хийлгэсэн тохиолдолд Телевиз үүнийгээ тусдаа гэрээгээр зохицуулагдаж болох ба гэрээ хийх зөвлөмжид тусгаж өгөх нь зүйтэй саналтай байна. Энэ компани ихэвчлэн энэ төрлийн үйлчилгээг үзүүлдэг компани байх учир дээрх км-ээр тооцсон тарифаас хол зөрөхгүй юм” гэсэн саналыг оруулж байна.

ХХЗХ-ны ажлын хэсгийн дүгнэлт зааглах цэгийн цэгийн зохистой байрлал, үнэ тарифын нэгдсэн бодлогод шийдвэрлэх хариуг гарах ба үүнийг судалгаандаа авч оруулах нь зүйтэй байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль дахь үндсэн заалтууд ялангуяа техникийн зөвлөхийн ажлын хүрээнд авч үзсэн техник холболтын гэрээ, түүний төлбөртэй холбоотой тус хуулийн 20.5 дахь заалтууд нь ОСДҮЭ болон Өргөн нэвтрүүлгийн телевиз, Арилжааны телевизүүдийн маргааны зарим шалтгаан болж байна. Иймээс холболтын журмыг талуудад таниулах, шаардлагатай бол зарим заалтуудыг өөрчлөх ажлуудыг хийх нь зүйтэй юм.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЬЁОЛОЛ ГУРАВ. ОРОН НУТГИЙН ТЕЛЕВИЗҮҮДЭД ТӨРИЙН ДЭМЖЛЭГ ШААРДЛАГАТАЙ ЭСЭХ

3.3.1 Орон нутгийн телевизүүдийн байх ёстой болон одоо байгаа байдал.

Орон нутгийн телевизүүдийн байх ёстой байдал.

Монгол Улсын Үндсэн хуульд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хуульчилсан байдаг нь уг эрхийн үнэ цэнийг илтгэнэ. Тийм ч учраас улс орнууд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсаар ирсэн.

НҮБ-аас өөрийн гишүүн улсуудад өгсөн удирдамжийн дагуу улс орнууд өөрийн дотоод хууль тогтоомжийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байдлыг хангах, хариуцлагатай мэргэшсэн үйл ажиллагааг дэмжих, олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй бодит мэдээ, мэдээллийг олж авах иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангах зохицуулалтыг тусгайлан оруулж өгөхийг зөвлөсөн¹⁷ байдаг.

Манай улсын хувьд иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн батлан хэрэгжүүлж байгаа нь сайн хэрэг боловч уг хуульд орон нутгийн телевизүүдийн эрх зүйн байдалтай холбоотой зарим нэг тулгамдсан асуудлууд үүсч байна.

Орон нутгийн телевизийн гол зорилго бол тухайн бүс нутаг буюу тухайн орон нутгийн иргэдийг тэнцвэртэй, үнэн бодит мэдээллээр хангах явдал бөгөөд үүний тулд санхүүгийн хувьд хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулах боломжтой байх ёстой юм. Өөрөөр хэлбэл стандартын шаардлага хангасан, чанартай сайн нэвтрүүлэг хийж, нийтэд хүртээмжтэй хүргэх, хөтөлбөрийн агуулгыг хууль тогтоомжийн дагуу үзэгч, олон нийтэд хүргэх, өргөн нэвтрүүлгийн салбарт үр ашигтай өрсөлдөөний зохистой орчныг бүрдүүлэхийн¹⁸ тулд санхүүжилтийн нөхцөл чухал юм.

Орон нутгийн телевизүүдийн байгаа байдал.

Орон нутгийн телевиз нь хүн ам, газарзүйн онцлогоос хамааран хязгаарлагдмал зах зээлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа субъект бөгөөд тусад нь бие даасан байдлаар зохицуулаагүй байна. Харин санхүүжилтийн хувьд Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасны дагуу Монголын Телевизүүдийн холбоонд төвлөрсөн орлогоос өөрт ногдох хэсгийг авах эрхтэй боловч уг телевиз үзэлтийн судалгааг гаргах боломжгүй тул уг орлогоос авах боломжгүй байгаа нь санхүүжилтийн хувьд хүндрэлтэй нөхцөл байдалд хүргэж байна. Харилцаа холбооны зохицуулах хороо Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5-д “өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч хоорондын орлого хуваах зарчмыг тодорхойлох” гэж заасны дагуу орлого хувиарлах зарчмыг тодорхойлоогүй байна.

Шигтгээ:

Манай орон нутгийн телевизүүд буураад нийтдээ 52 орчим телевиз байна. Орон нутгийн төр захиргааны байгууллагатай байгуулсан гэрээ болон зарим нэг төлбөртэй контентоороо л санхүүжиж байна. Төрөөс ямар нэгэн дэмжлэг авч чадахгүй байгаа.
--

¹⁷ Зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсгэхээс сэргийлэх журмын тайлбар.,

¹⁸ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

Телевизүүдийн холбоонд төвлөрсөн орлогоос авч чадахгүй нөхцөл байдалд байгаа нэгдүгээрт тус холбоонд гишүүнчлэлгүй, хоёрдугаарт үзэлтийн судалгаа шударгаар гарахгүй байна. Одоо судалгаа гаргадаг байгууллага байхгүй болсон.

Монголын телевизүүдийн холбоотой орлого хувиарлах талаар тохиролцсон боловч хэрхэн яаж хувиарлах талаар тохиролцоонд хүрээгүй байна.

Орон нутгийн телевизүүдийн эрэлт хэрэгцээ өндөр байна. Нэгдүгээрт: орон нутгийн иргэд өөрсдийгөө үзэх дуртай байдаг өөрөөр хэлбэл тухайн амьдарч буй бүс нутгийнхаа амьдрал, соёл гэдэг юмнуудаа л үзэх сонирхол өндөр, Хоёрдугаарт: Тухайн орон нутгийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх шаардлагатай байдаг.

Мөн өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хөтөлбөрийн тодорхой хувь нь орон нутгийн контент байх үүрэгтэй боловч энэ хүрээнд өргөний телевизүүд зөвхөн орон нутгийн телевизүүдтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

/Орон нутгийн телевизүүдийн холбооны тэргүүн Ч.Баярсайхан/

Манай телевиз Монголын телевизийн холбооноос олгох өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогоос авдаггүй, төрөөс ямар нэгэн дэмжлэг авдаггүй. Зөвхөн өөрсдийн бүтээл болон реклам, мэдээллээс орлого олж авдаг. Төрөөс дэмжлэг шаардлагатай байгаа.

Дархан аймгийн ТВ

Телевизүүдийн үйлчилгээний орлого нь хаан төвлөрөөд ямар журмаар олгогддог талаар мэдэхгүй, тэр орлогоос авдаггүй.

Ховд аймгийн ТВ

Орон нутгийн телевизүүдийн хувьд реклам, зар сурталчилгаагаараа л санхүүждэг. Тодорхой хэмжээнд төрийн дэмжлэг бол зайлшгүй шаардлагатай байгаа бид Монголын телевизүүдийн холбоонд төвлөрсөн үйлчилгээний хөлснөөс авч чаддаггүй.

Хэнтий аймгийн ТВ

Монгол Улсын хэмжээнд нийтдээ 52 телевиз орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрээс 8 телевизыг сонгож, орон нутгийн телевизүүдэд төрийн дэмжлэг шаардлагатай эсэх талаар асуулга явуулахад төрийн дэмжлэг татаас зохих ёсоор байх ёстой талаар бүгд санал нэг байна.

3.3.2 Бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалт буюу тохиолдол судлах.

Судалгааны ажлын энэ хэсэгт Орон нутгийн буюу бүс нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага тэр дундаа телевизүүдэд төрөөс дэмжлэг үзүүлдэг эсэх талаар судаллаа.

Их Британи улс

Дотоод Нэвтрүүлэг ба түүний дэлхий дэхь арилжааны вйл ажиллагааг багтаасан Дотоод Нэвтрүүлгийн Групп болон Гадаад Нэвтрүүлгийн санхүүжилт тус тусдаа байдаг. Дотоод болон Гадаад Нэвтрүүлгийн хоёулангийнх нь санхүүжилтийн гол эх үүсвэр олон нийтээс авдаг хураамж байдаг. Дүрмийн¹⁹ 16-р зvйлд заасны дагуу Дотоод Нэвтрүүлэг дангаараа хураамжын орлогыг авах эрхтэй байдаг ба 1999 оны байдлаар энэ сан нь 2,2 тэрбум фунт буюу Дотоод Нэвтрүүлгийн Группын нийт төсвийн 82 хувьтай тэнцэж байжээ. Үүн дээр нэмээд 17 хувь нь арилжааны вйл ажиллагаанаас олсон орлого, харин орлогын 1

¹⁹ Би Би Си-гийн олон нийтэд вйлчлэх үүргийг Дүрэм болон Гэрээний хэд хэдэн заалтаар тодорхойлсон байдаг.

хувь нь бусад эх сурвалжаас орж ирсэн байв. Гэрээний 10.1(б) зүйлийн дагуу Төрийн нарийн бичгийн даргаас урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд хураамжын орлогыг бусад эх сурвалжаас олсон санхүүжилттэй холилдуулхыг хоригложээ. Ингэснээр Би Би Си-г нэвтрүүлгийн үеэр зар сурталчилгаа явуулхыг хориглож байгаа юм. Гадаад Нэвтрүүлгийн 89 хувийг Парламентын сангаас гаргадаг.

Тус улсын хувьд хураамжын орлогын 62 гаруй хувийг телевизэд зарцуулдаг. Үүнд: 35 хувийг Би Би Си-1-д, 19 хувийг Би Би Си-2-д, 8 хувийг бус нутгийн телевизүүдэд зарцуулдаг. Үлдсэн хэсгээс 21 хувь нь төрөл бүрийн радио станцуудад хуваарилагддаг ба үлдэгдэл 17 хувийг хураамж бүрдүүлэх болон бусад зардалд зарцуулдаг.

Франц улс

Соёл, харилцаа холбооны яамны харьяа Хэвлэл мэдээллийн хөгжил хариуцсан Захиргаа татаас олгох ажлыг зохион байгуулдаг. Эргэлтийг сайжруулах (бус нутгийн болон орон нутгийн хэвлэл, олон нийтийн болон улс төрийн хэвлэл)-д нийт 21,696,067 евро зарцуулсан байдаг. Түүнчлэн мэргэжлийн дагуу цахим хэвлэлийн үйлчилгээ үзүүлж буй газарт шууд дэмжлэг үзүүлэн ажилладаг байна. Цаашлаад сэтгүүлчдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг. Ийнхүү Франц улсад олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад төрийн зүгээс шууд болон шууд бусаар дэмжлэг үзүүлдэг.

Эндээс үзвэл Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн телевизүүдэд төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн салбарын хөгжил нь өндөр улс орнууд ч тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлдэг байна.

БНХАУ-ын хувьд Орон нутгийн телевизүүдийн үүрэг өндөр байдаг. Үзэгчид орон нутгийн телевизүүдийн илүү үздэг бөгөөд Хятад улс орон нутгийн телевизүүдийг дэмжиж бүр төв CCTV-тэй өрсөлдөх хэмжээнд авч ирсэн байдаг²⁰.

²⁰ Максима медиа ХХК., Радио телевизийн салбарын зах зээлийн нөхцөл байдлын талаарх судалгааны нэгдсэн тайлан.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЬЁОЛОЛ ДӨРӨВ.

СУВГИЙН ДАРААЛЛЫГ ИРГЭД ӨӨРСДӨӨ ТОГТООХ БОЛОМЖ /MUST CURRY ЗАРЧМЫН ТАЛААРХ СУДАЛГАА/

3.4.1 Гадаадын зарим улс орнуудын туршлага буюу тохиолдол судлах.

1. АНУ-ын Must-Carry зарчмын талаар:

АНУ-ын Харилцаа Холбооны Комисс нь анх 1965 онд орон нутгийн станцуудыг зах зээлд эзлэх байр сууриа алдахаас хамгаалах зорилгоор Must-carry зарчмыг баталсан. 1980 аад оны сүүлээр кабелийн сүлжээ олширсонтой зэрэгцээд операторууд илүү алдартай, ашиг орлоготой болсон тул кабелийн сүлжээний компанийн хувьд Must-Carry зарчим нь шударга бус, мөн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдаж байна гэж үзсэн. Үүнтэй холбогдуулан шүүхэд гомдол гаргаж, ялалт олсон боловч тухайн үед зарчмыг шинэчлэх гэж нилээд хугацаа зарцуулсан бөгөөд 1992 онд Конгресс Кабелийн телевизийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (“Кабелийн тухай хууль”) баталж, телевизийн нэвтрүүлэгчдэд боломжийн нөхөн олговор олгох (“дахин дамжуулах зөвшөөрөл” Retransmission Consent²¹) буюу өөрөөр хэлбэл кабелийн системтэй харилцан тохиролцох, эсвэл кабелийн системд сүлжээгээ нөхөн төлбөргүйгээр дамжуулах систем (“Must-carry system”) гэсэн хоёр төрлөөс сонгож хэлэлцээр хийх боломж гаргаж ирсэн. Ингэснээр телевизүүд нь чанартай, шинэлэг контент бүтээх, чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх боломж олдож АНУ-ын өргөн нэвтрүүлгийн салбарт томоохон өөрчлөлт буюу “алтан үе”-ийг авчирсан байна.

Кабелийн компаниуд нь өргөн нэвтрүүлгийн телевизүүдээс хамаагүй уян хатан зохицуулалттай байдаг. Учир нь нийтийн эзэмшлийн сүлжээний нэг хэсгийг эзэлдэггүй тул Харилцаа Холбооны Комиссоос тусгай зөвшөөрөл авч, тэдний хяналтад байх шаардлагагүй байдаг. Харин кабелийн компаниуд үзэгчдээс сар бүр хураамж авч, өөрсдийн техник хэрэгсэл болон бусад зардлаа нөхдөг байна. Мөн засгийн газрын контентын хязгаарлалтаас үндсэндээ ангид байдаг нь бас нэг давуу тал юм.

Кабелийн компани нь Харилцаа холбооны комисстой нэг л зүйлээр холбоотой байдаг. Must-Carry системийн гэрээ аль эсвэл Дахин дамжуулах зөвшөөрлийн гэрээний аль нэгийг сонгож гурван жил тутамд шинэчлэх шаардлагатай байдаг.

Дахин дамжуулах зөвшөөрлийн гэрээ хэлэлцээр хийхэд цаг хугацаа шаардагддаг бөгөөд хэлэлцээрийн хугацаанд кабелийн оператор нь өргөн нэвтрүүлгийн сүлжээг дамжуулах боломжгүй байдаг. Өөрөөр хэлбэл зөвшилцөлд хүрсний дараа системдээ оруулж өгдөг байна. Аливаа гэрээ нь ердөө гурван жилийн хугацаатай бөгөөд үүний дараа өргөн нэвтрүүлгийн станц дахин дамжуулах зөвшөөрлийн системийг ашиглах уу, эсвэл Must-carry system-д шилжих үү гэдгээ дахин шийдэх боломжтой байдаг.

2. Pay tv

²¹ <https://www.fcc.gov/tags/must-carry-retransmission-consent>

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22.²² дахь хэсэгт заасны дагуу хэрэглэгч тухайн сувгийг сонгон, олон суваг дамжуулах үйлчилгээгээр дамжуулан төлбөр төлснөөр идэвхжих телевизийн үйлчилгээг хэлнэ.

Төлбөртэй телевизэд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- зар сурталчилгаа, теле худалдааны нэвтрүүлэг нэвтрүүлэхийг хориглосон. Гэвч зөвхөн тухайн нэвтрүүлгийн ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалт байж болно
- өөрийн редакцын бодлогын хүрээнд бэлтгэсэн тодорхой хэмжээний өөрийн бүтээл, нэвтрүүлэгтэй байх
- зөвхөн нэг чиглэлээр 100 хувь төрөлжсөн хөтөлбөр бэлтгэн дамжуулах үүрэгтэй

Төлбөртэй телевизээр дамжуулан хэрэглэгч өөрийн хүссэн төрлийн хөтөлбөрийн сувгийг сонгож төлбөр төлж идэвхжүүлэх гэсэн ойлголт юм. Үүнд ихэвчлэн спорт, хүүхдэд зориулсан, насанд хүрэгчдэд зориулсан гэх мэтээр төрөлжсөн хөтөлбөртэй телевиз олон байдаг байна. Бусад телевизүүд зар сурталчилгаа, дамжуулалтын орлогоос санхүүждэг бол төлбөрт телевиз нь сар бүрийн хэрэглэгчдийн төлж буй төлбөрөөс санхүүжилтээ олдгоороо ялгаатай юм.

АНУ-д төлбөртэй сувгийг ихэвчлэн нэмэлт төлбөргүйгээр үндсэн сувгийн хамт багцалдаг бөгөөд тусад нь худалдаж авах боломжгүй байдаг. Зарим үйлчилгээ үзүүлэгчид нэг компанийн эзэмшдэг үйлчилгээг нэг багцаар санал болгодог. Жишээлбэл, Америкийн хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгч DirecTV нь Starz multiplex (хоёулаа Lionsgate's Starz Inc. эзэмшдэг²³) болон The Movie Channel, Flix, SundanceTV зэрэгт Encore сувгуудыг санал болгодог гэх мэт. Мөн Showtime Unlimited²⁴ багцад Cinemax болон түүний мультиплекс сүлжээнүүд нь багтдаг бөгөөд HBO (хоёул Warner Bros. Discovery эзэмшдэг)-тэй үргэлж цуг багцлагдсан байдаг.

Өмнөд Солонгос улсад мөн адил телевизүүдийн багцаар ангилдаг бөгөөд багцын үнэ нь сувагны тоо болон ангилалаас хамаараад өөр өөр байдаг.

АНУ-ын хувьд 2023 оны 2-р сарын урьдчилсан судалгаагаар төлбөртэй ТВ ашигладаг өрхийн тоо оны эцэс гэхэд 60.5 сая орчимд хүрэх төлөвтэй байгаа боловч энэхүү тоо нь ойрын хэдэн жилд улам буурч, 2027 он гэхэд 50 сая²⁵ хүрэхгүй байх магадлалтай байгаа юм. Энэ нь интернэтэд суурилсан платформуудыг иргэд түлхүү сонгож ашиглаж эхэлж байгаатай холбоотой юм.

Манай улсад төлбөртэй телевизийг хөгжүүлж, багц гаргана үүнийг үзэгчдэд санал болгох бүрэн боломжтой. олон улсад төлбөрт телевиз гэхээс илүү Video-on-demand (VOD)-г ашигладаг болсон байна. Манай улсад бол Look tv, ORI, SkyGO, Voo service of mobinet, MO

²² Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22."төлбөртэй радио, телевиз" гэж хэрэглэгч тухайн сувгийг сонгон, олон суваг дамжуулах үйлчилгээгээр дамжуулан төлбөр төлснөөр идэвхжих радио, телевизийн үйлчилгээг.

²³ "DirecTV Official Site – Starz Super Pack Information"

²⁴ "DirecTV Official Site – Showtime Unlimited Package Information"

²⁵ <https://www.statista.com/statistics/251268/number-of-pay-tv-households-in-the-us/>

TV зэрэг нь VOD-д багтах юм. интернет сүлжээ хөгжсөн цагт хэрэглэгчид ихэвчлэн VOD ашиглан өөрийн хүссэн контентоо үзэх боломж нэмэгдэж байгаа тул үүнийг анхаарах шаардлагатай.

3.4.2 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

1. Өргөн нэвтрүүлгийн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх.

Өргөн нэвтрүүлгийн тухайн хуулийн 26 дугаар зүйлд Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид тавигдах шаардлагыг тодорхойлж өгсөн байна. 26 дугаар зүйлийн 26.7-т “*Үндэсний олон нийтийн телевиз болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгууд нь олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын эхэнд байна*” гэж заасан. Үндсэн багцад тавигдах шаардлагыг Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмын 2 дугаар зүйлээр тодорхойлж өгсөн. Журмын 2 дугаар зүйлийн 2.4-т “*Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцад телевизийн сувгууд дараах дарааллаар байрлана: 2.4.1.олон нийтийн телевизийн үндсэн суваг; 2.4.2.өргөн нэвтрүүлгийн телевиз болон олон нийтийн телевизийн бусад суваг; 2.4.3.арилжааны телевиз; 2.4.4.гадаадын телевизийн суваг;*” гэж заасан байдаг.

Энэхүү дарааллыг тогтоосноор зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй гэж зарим телевизийн холбоод үзэж байгаа юм. Учир нь дараалал тогтоосноор арилжааны телевиз болон бусад телевизийн хувьд сувгийн дараалал тогтоосноор шударга өрсөлдөөнд сөрөг нөлөөтэй, шударга өрсөлдөх нөхцөлийг алдагдуулж байна гэж үзэж байгаа юм. Тэгвэл Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэд хэдэн заалтаас дурдвал доорх заалтууд орж өгснөөр сувгийн дарааллын асуудлаас хамаарахгүй шударга өрсөлдөж, ашиг орлогоо олох боломжтой гэж үзэх юм. Үүнд:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.5.3.өргөн нэвтрүүлгийн радио, телевизүүд нь энэ хуулийн 6.1.2-т заасан үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах; 20.5.4.бусад арилжааны радио, телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан тохиролцох. 20.6.Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь энэ хуулийн 20.5.3-т заасан хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна” гэж тус тус зааж өгсөн. Хуулиараа бол телевиз нь үзэлт сайтай, чанартай контент бүтээж чадаж байгаа бол гишүүдэд 15 хувиас доошгүй хувийг хуваарилах, харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулах зэрэг боломжтой юм.

Шигтгээ:

Арилжааны телевизэд багтах Movie box суваг нь үзэгчид сайтай, сайн контент хүргэж чаддаг учир харилцан тохиролцож гэрээ байгуулаад ашиг хувийг авч болоод байдаг.

Монголын телевизүүдийн холбооны гүйцэтгэх захирал А.Баярбат

Өргөн нэвтрүүлгийн телевизүүд үндсэн багцын эхэнд байснаар бид нар зар сурталчилгааны орлогогүй болсон. Үүнээс үүдэн шударга өрсөлдөх боломж нөхцөлгүй болсон. Өргөн нэвтрүүлгийн 18 телевизүүд илүү их боломж олгосон.

Арилжааны телевизүүдийн холбоо

Сувгийн дарааллын асуудал, өргөн нэвтрүүлгийн асуудал нь шударга өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалттай байна. Энэ талаар манай байгууллагаас дүгнэлт гаргасан байгаа.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай хийсэн ярилцлагын судалгааны хэсгээс ...

Эндээс үзвэл тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэг нь шударга өрсөлдөөнд нөлөөлсөн байна гэж дүгнэж болохоор байна.

2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүүхэд, залуучуудын хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхгүй байх

Өргөн нэвтрүүлгийн тухайн хуулийн 26 дугаар зүйлд Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид тавигдах шаардлагыг тодорхойлж өгсөн байна. 26 дугаар зүйлийн 26.7-т “Үндэсний олон нийтийн телевиз болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгууд нь олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын эхэнд байна” гэж заасан. Энэхүү заалт нь хуулийн 5 дугаар зүйлийн зарчимтай нийцэж байх шаардлагатай. Мөн Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангах хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь чанартай нэвтрүүлэг, мөн үзэгчдийн үнэлгээнд баригдалгүйгээр нийгэмд зайлшгүй шаардлагатай боловсрол, халамжийн хөтөлбөрүүдийг хүргэхэд оршиж байгаа юм.

Олон суваг дамжуулах үйлчилгээ хэрэглэгчдийн тоо 2022 оны байдлаар 760,028 буюу нийт өрхийн 82 хувь нь идэвхтэй ашигладаг гэсэн судалгаа гарсан. Үүнээс харахад Монголын иргэдийн дийлэнх нь олон нийтийн суваг дамжуулах үйлчилгээг ашиглаж үүнээс мэдээлэл авч байгаа юм.

Өргөн нэвтрүүлэг нь Үндэсний бүтээл, нэвтрүүлэг, түүх соёл, уламжлалын нэвтрүүлэг, танин мэдэхгүйн нэвтрүүлэг, хүүхдийн хөтөлбөрүүд зэрэг хөтөлбөрт жилд

зарцуулах цагийг зааж өгсөн байдаг. Жишээлбэл Үндэсний түүх, соёл уламжлалын нэвтрүүлэг нь жилд дор хаяж 200 цагийг зайлшгүй зарцуулсан байх ёстой бөгөөд 2022 оны байдлаар Central tv, Монгол HD, Боловсрол судаг, ТВ8 зэрэг сувгууд нь шаардлагыг хангасан байна. Мөн Бага +6 болон өсвөр 12+ нэвтрүүлгийн цаг 130 цаг бөгөөд SBN, NTV, Боловсрол суваг, Сүлд, ТВ8 зэрэг сувгууд нь шаардлагад нийцсэн байна. Үүнээс үзэхэд өргөн нэвтрүүлгийн телевизүүд нь үндсэн багцын эхэнд орсноор нийгэмд хэрэгтэй мэдээллийг хүргэх үүргээ биелүүлж, хуулийн зорилтод нийцэж байна гэж дүгнэв.

Харин шударга өрсөлдөөнд нөлөөлж буй эсэх асуудлын тухайд сувгийн дараалал шударга өрсөлдөөнийг хааж буй зохицуулалт гэж үзэхээр байна.

Тухайлбал: Арилжааны болон өргөн нэвтрүүлгийн телевизүүдээс анкетын аргаар судалгаа авахад нэр бүхий 4 телевизээс судалгаа ирүүлсэн байх бөгөөд эдгээрээс 3 нь сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох ёстой, одоогийн зохицуулалт нь буруу гэдэг саналыг ирүүлсэн байна. Мөн Монголын телевизүүдийн холбоо уг зохицуулалт нь шударга өрсөлдөх нөхцлийг хааж байгаа талаар ярилцлагын судалгаандаа дурьдсан байна.

Шигтгээ:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д сувгийн дарааллыг хуульчилсан нь өргөн нэвтрүүлгийн гэх хувийн телевизүүдэд илт давуу байдал олгож буйг эргэн харах шаардлагатай.

NTN TB

Сувгийн дарааллын эрх зүйн зохицуулалтын талаарх сананалдаа:

Сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох боломжтой гэсэн байна.

UBS TB

3.4.3 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Тулгамдаж байгаа гол асуудал бол өргөн нэвтрүүлгийг телевизүүд бус Арилжааны телевиз, орон нутгийн телевизүүдэд тулгарч байгаа асуудлууд юм.

Манай телевиз 1995 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна гэтэл орон нутагтаа 40 орчим, Юнившн-д бол бүр 926-т гардаг. Одоо бүр зар сурталчилгаанаас ч орлого олох боломжгүй болсон. Тэгэхээр орон нутгийн телевизүүдийн сувгийн дараалалд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизийг үндсэн багц гэж дараалал дээр өөрчлөлт оруулсан. манай телевиз Юнившний буюу телвизийн 19 дүгээр суваг дээр явдаг байсан. гэтэл өргөн нэвтрүүлгийн хуулиар нэг дүгээрт Үндэсний тв, тэгээд үндсэн багцын сувгууд буюу Өргөн нэвтрүүлгийн телевизийн 18 суваг, тэрний араас үндэсний олон нийтийн тв-ийн сувгууд байршилна тэрний дараа арилжааны тв байршилна гээд заачиж байгаа юм. Ингээд дараалал алдагдаад манайх 29 дүгээр сувагт орчиж байгаа юм. Бидний орлогын эх үйсвэр бол зар сурталчилгаа байсан гэвч дараалал хууличилснаар бидэнд зар сурталчилгаа олдохгүй болсон. Үүнээс үүдэд дампуурлын эрмэг дээр тулж байна.

Арилжааны телевизүүдийн холбоо

Сувгийн дарааллын хувьд иргэд өөрсдөө тогтоох боломжтой боловч иргэд өөрсдөө тогтоож эхэлснээр өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд тусгай зөвшөөрлийг олгож буй утга учир алдагдана. Учир нь өргөн нэвтрүүлгийн телевизүүд тухайн улс орны үндэсний аюулгүй байдал, соёл, нийгмийн оюун санааны дархлааг хадгалахуйц мэдээ, мэдээлэл, контентыг гаргах үүрэгтэй. Харин арилжааны телевизүүдийн хөтөлбөрт тийм шаардлага байхгүй.

Монголын телевизүүдийн холбоо

Иргэд өөрсдөө сувгийн дарааллыг тогтоох боломжтой бол энэ нь зах зээлд шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх маш зөв шийдвэр болно. Үүнийг бол дэмжинэ.

Channel 11 ТВ

Олон суваг дамжуулагчийн дамжуулж буй сувгийн дугаарлалтыг хэрэглэгч нь системийн хувьд өөрчлөх боломжгүй бөгөөд харин зарим олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн технологийн онцлогоос хамаарч өөрийн дуртай сувгийн цэсийг үүсгэн үзэх боломжтой байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд дугаарлалтын дарааллыг МҮОНРТ, Өргөн нэвтрүүлгийн телевиз, Арилжааны телевиз, гадаад суваг гэж тусгайлан хуульчилж өгсөн нь Өрсөлдөөнд харш үйлдэл болсон болно.

*Монголын Олон суваг
дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбоо*

Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчид дараах байр суурьтай байна.

Шинэ Сансар ХХК	Скаймедиа ХХК	MNBC KATB
<p>Одоогийн манай техникийн шийдэл Хэрэглэгчид үздэггүй сувгуудаа сувгийн жагсаалтуудаас хасах боломжгүй.</p> <p>Одоогийн манай техникийн шийдэл Хэрэглэгчид нийт сувгийн дарааллыг өөрийн хүссэнээр өөрчлөх боломжгүй. Манайх DVB-C2 технологи дээр ажилладаг. Эдгээр нь тоон системийн технологи бөгөөд зурвасын өргөн тус бүр дээр сувгуудыг багцалсан байдаг тул ийм боломж байхгүй юм.</p>	<p>Одоогийн манай “Middleware”-д (дундын програм хангамж) ийм боломжгүй.</p> <p>Бидний үйлчилгээ багцан дээр суурилсан архитектортой учир багц болгон дээр тогтсон сувгийн дарааллууд байдаг учир өөрчлөх боломжгүй юм. Харин үзэх дуртай сувгаа “Favorite” гэсэн тэмдэг дарж болно. Энэ үед меню дээр дуртай сувгууд нь дээгүүр байрших боломжтой болдог.</p> <p>Орчин үед үйлчилгээний хэлбэр илүү динамик шийдэл рүү орж байна. Гадныханд энэ технологи дөнгөж одоо л гарч эхлэх гэж байна. Үүнийг “Personal channel”, “Fast channel” гэх маягаар нэрлэж байна.</p>	<p>Манай хэрэглэгчийн STB ийм боломжтой. Суваг хасах, дарааллыг өөрчлөх боломжтой.</p> <p>Жишээ нь хэрэглэгчийн меню хэсэгт “Хөтөлбөр засах” гэсэн команд бий. Үүн дотор сувгийг зөөх, алгасах, түгжих, устгах, дуртайгаа тэмдэглэх, нэр өгөх гэсэн командууд байгаа бөгөөд эдгээрийн тусламжтайгаар үйлдлүүдээ хийдэг.</p> <p>Гэхдээ ихэнх хэрэглэгчид энэ үйлдлийг хийдэггүй.</p>

Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн багцын сувгийн дараалалд хяналт шалгалт хийхэд 4 газар нь шаардлага хангахгүй байгааг Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар тогтоосон байна.

Өргөн нэвтрүүлгийн телевиз нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.21-т заасны дагуу олон талт хөтөлбөртэй байх шаардлагатай. Арилжааны телевиз нь хөтөлбөрөө төрөлжүүлж болох бөгөөд өмнөх зохицуулалтын хүрээнд тавьж байсан төрөлжсөн чиглэлийн шаардлага тавигдахгүй. Харин төлбөртэй телевизийн тухайд хөтөлбөрөө заавал төрөлжүүлэх шаардлагатай юм. Телевиз нь энэхүү хөтөлбөрт тавигдах шаардлагаар тодорхойлсон ӨНтХуулийн 23.5-д заасан бүтээл нэвтрүүлгийн хувь, хэмжээг хангаж ажиллах шаардлагатай гэсэн байдлаар зохицуулсан байна.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд практик хэрэгжилт хангалтгүй буюу нилээдгүй маргаантай байгаа нь ажиглагдаж байна.

Одоогоор өргөн нэвтрүүлгийн болон бусад телевизүүдийг хэрэглэгчдэд дамжуулж байгаа технологи нь интернэт протокол дээр суурилсан IPTV технологи, тоон кабелийн телевиз болох DVB Digital Video Broadcasting (DVB-C Cable, DVB-T Terrestrial, DVB-S Satellite) гэсэн технологи дээр суурилж байна.

IPTV үйлчилгээ эрхлэгчдэд хэрэглэгч өөрөө дуртай сувгаа эрэмбэлэн солих техникийн боломж бий боловч тэдний үйлчилгээний бүтэц нь сувгийн тоо, сувгийн төрлүүд зэргээс хамаарсан сувгуудын багцаас хамаарсан үйлчилгээ явуулж байгаа учир үүндээ захирагдан энэ боломжийг идэвхжүүлээгүй байна.

ОСДҮЭ нарын ялангуяа IPTV үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчийн төхөөрөмжүүд болох андройд, смарт боксүүдын үндсэн меню нь Телевиз, Видео сан, Кино багц, APP гэсэн гэсэн үндсэн менюүүдтэй эдгээрээс сонголтоо хийх үйлдлийн дараалалтай байна. Энэ нь хуучны телевизээ асаангуут шүүд телевизийн нэгдүгээр сувгаас (эсвэл промо сувгаас) үзэлт эхэлдэг шийдэл арилж байгааг харуулж байна.

Телевиз гэсэн сонголтыг хийсний дараа сувгуудыг төрлөөр нь бүлэглэсэн сонголт байхаас гадна тухайн хэрэглэгчийн хамгийн их үздэг дуртай сувгуудыг том айконоор харуулдаг болсон нь сувгийн дарааллын тухай ойлголт шинэ шатанд гарсныг харуулж байна. Зөвхөн “Бүгд” сувгууд гэсэн сонголтыг хийж орсны дараа 1-р сувгаас эхлэн үндсэн багцын дугаарлалтын дагуу телевизийн сувгууд гарч байна.

Сүүлийн үед хөгжиж байгаа OTT үйлчилгээний цэсийн сонголт мөн үүнтэй адил боловсронгуй болж багц, видео сан зэрэг үйлчилгээнүүд телевизийн сувгуудын үйлчилгээтэй зэрэгцэж ирж байна. Үзэх дуртай сувгуудыг сонгодог үйлдлүүд нь сувгийн дарааллын тухай ач холбогдлыг бууруулж байна гэсэн үг юм.

Харин тоон кабелийн телевизийн үйлчилгээ эрхэлдэг оператор компаниудийн сонгосон вендорын CAS (удирдлагын програм хангамж) систем, STB-ын сонголт зэргээс хамаарч сувгийн дарааллыг өөрчлөх боломж өөр өөр байна. Жишээ нь DVB-C2 технологитой Сансар операторт ийм боломж байхгүй, харин DVB-T2 технологитой MNBC операторт ийм боломж байна.

Мөн Арилжааны телевизүүдийн илүүтэй шударга өрсөлдөх нөхцлийг хаасан зохицуулалт гэж үзэж болох юм. Учир нь телевизүүдийн орлогын гол эх үүсвэр бол зар сурталчилгаа байдаг бөгөөд зар сурталчилгаа нийлүүлэгчид нь ихэвчлэн үзэлт сайн телевизүүдэд болон үндсэн багцын эхэнд байгаа телевизүүдэд зар сурталчилгаа өгөх хандлагатай байдаг. Гэтэл Өргөн нэвтрүүлгийн 18 телевизийг эхэнд оруулсан нь адилхан телевизүүдийн ашиг олох нөхцлийг хаасан гэж үзэж байна.

Энэ талаар судалгаа авч үзэхэд Өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, орон нутгийн 56 телевизүүдийг өөртөө нэгтгэсэн Монголын телевизүүдийн холбоо шударга өрсөлдөөнийг хаасан зохицуулалт гэдэг байр суурьтай байгаа бол Арилжааны телевизүүдийн холбоо, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбоо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар зэрэг байгууллагаас мөн адил байр суурьтай байна.

Үүнээс дүгнэхэд уг зохицуулалт шударга өрсөлдөөнийг нэгэнт хязгаарлаж байгаа тул Үндсэн багцад орох сувгийн тоог багасгах эсвэл өөрчлөх, тодорхой шалгуур үзүүлэлтээр үндсэн багцад орох сувгийг сонгон шалгаруулах хувилбар байж болно.

Мөн бидний хийсэн судалгааны хүрээнд иргэд өөрсдөө тогтоох боломжтой гэсэн үр дүн гарч байна.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЬЁОЛОЛ ТАВ. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 14 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 14.1.3 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

3.5.1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Монгол Улсын нэгдсэн орсон, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 27 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.”²⁶ гэж, мөн зүйлийн 2-т “Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтууд²⁷ иргэний туурвисан бүтээлийн оюуны өмчийн эрхийг хамгаалах үүргийг төрд хүлээлгэсэн байна.

Мөн Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийг өөрийн сувгаар гаргахыг үүрэг болгосон байх бөгөөд энэ нь зохиогчийн эрхийг хангах чухал зохицуулалт юм.

Үүнтэй холбогдуулан Зохиогчийн эрхийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д “Интернетийн үйлчилгээ түгээгч, агрегатор, цахим хуудас эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон сувгийн дамжуулагч нь өөрийн болон бусад сервер, сүлжээ, санд зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй”, 52.2.Энэ хуулийн 52.1-д заасан этгээд нь зохиогчийн эрх болон хамаарах зүйлийн 2-д “эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдсэн даруй тухайн зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглалтыг зогсоох, хаах үүрэг хүлээнэ” гэх байдлаар зохицуулсан байдаг.

Энэ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн үндсэн зорилт болох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн шударга өрсөлдөөнийг хангахтай холбоотой чухал зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл уг зохицуулалт нь нэг талаас оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх боловч нөгөө талаас Интернетийн үйлчилгээ түгээгч, агрегатор, цахим хуудас эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон сувгийн дамжуулагчид үндэслэлгүйгээр контентыг гаргахгүй байх, хаах, зогсоох байдлаар бусдын эрхийг зөрчиж болох юм. Гэхдээ эрх бүхий этгээд уг шийдвэрийг гаргахдаа үндэслэл бүхий мэдээ, мэдээллийг үндэслэж шийдвэр гаргах ёстой билээ.

Зохиогчийн эрх хэмээх ойлголт нь өөртөө эдийн болон ёс суртахууны эрхийг агуулдаг бөгөөд ёс суртахууны эрх гэдэгт зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрх, тэр дундаа зохиогч мөн болох эрхийн ойлголт юм. Харин эдийн засгийн эрх гэдэгт эд хөрөнгийн эрх буюу бүтээлээ ашиглах үнэлүүлэх зэрэг агуулгууд багтана. Үүнийг хамгаалах хууль зүйн механизмыг хуульчилсан нь өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн шударга өрсөлдөөнийг хангах хуулийн үндсэн зорилгод нийцэхүйц байна.

²⁶ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946 он, Монгол Улс 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон.

²⁷ Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа., УБ., 2018 он.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д “оюуны өмчийн эрхийг удаа дараа зөрчсөн нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тусгай зөвшөөрлийг 90 хоногоор түдгэлзүүлэх” эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд олгосон нь зохиогчийн эрхийг хамгаалах Өргөн нэвтрүүлгийн хуулийн тухай хуулийн зорилгод нийцсэн байна.

3.5.2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон Зохиогчийн эрхийн тухай хуульд заасан дээрх зохицуулалтын хувьд практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзье.

Энэ хүрээнд Монголын телевизүүдийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн төлөөлөл, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс судалгаа авсан.

Шигтгээ:

Орон нутгийн телевизүүдийн хувьд оюуны өмчийн зөрчлийн асуудал тэр бүр хөндөгддөггүй. <i>Хэнтий аймгийн ТВ</i>

Оюуны өмчийн зөрчлийн асуудал тэр бүр гараад байдаггүй. орон нутагт зарим тохиолдолд гардаг. <i>Орон нутгийн телевизүүдийн холбоо</i>
--

Шигтгээ:

Оюуны өмчийн зөрчлийн асуудал бага гардаг учраас энэ асуудал дээр саналгүй байна. <i>Арилжааны телевизүүдийн холбоо</i>
--

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд оюуны өмчийн зөрчил гайгүй байдаг. <i>Монголын телевизүүдийн холбоо</i>
--

Мэргэжлийн холбоодоос авсан ярилцлагын судалгааны дүнгээс үзвэл нийт 10 орчим оролцогчдоос дийлэнхи нь буюу 90 хувь нь оюуны өмчийн зөрчил гардаг боловч шийдвэрлэх зохицуулалт тодорхой учир асуудал үүсдэггүй гэсэн байна.

Оюуны өмчийн газраас 2020 онд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дах заалтад заасан Оюуны өмчийн эрхийг удаа дараа зөрчсөн нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон гэх үндэслэлээр нийт 10 телевизийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээр

оюуны өмчийн улсын байцаагчийн дүгнэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлсэн байна. /2023.09.11-ны өдрийн 5/547 дугаар албан тоот/.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд телевизүүд оюуны өмчийн зөрчилгүй контентийг нэвтрүүлэх үүрэгтэй байх бөгөөд Зохиогчийн эрхийн тухай хуулиар олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдэд оюуны өмчийн зөрчилтэй контент нэвтрүүлэхгүй байх эрхийг олгосон нь чухал механизм болсон байна.

Шигтгээ:

Оюуны өмчийн зөрчилтэй эсэх дээр тэр бүр хяналт тавиад байдаггүй. Учир нь контентыг шууд дамжуулж байгаа тул хяналт тавих боломжгүй байдаг. Харин өөрсдийн аппликейшн дээр явуулж байгаа кино контентийн хувьд гэрээ байгуулж худалдаж авдаг учраас оюуны өмчийн зөрчилгүй явагддаг.

Монголсат нетворк

Уг зохицуулалт хэрэгжилтийн хувьд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид оюуны өмчийн зөрчил дээр хяналт тавьдаггүй нь тодорхой байх тул уг заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЬЁОЛОЛ ЗУРГАА.

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 24 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 24.5 БОЛОН 24.2 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

3.6.1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Зар сурталчилгааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3-д “Радио, телевизээр түгээх зар сурталчилгаатай холбогдох харилцааг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулна” гэж заасан байдаг.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Зар сурталчилгааны талаар дараахь зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

1. Зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг үзэгч, сонсогчид ойлгомжтой байдлаар дуу, дүрсээр илэрхийлнэ.
2. Радио, телевизээр дамжуулах аливаа хэлбэрийн зар сурталчилгааны хязгаарлалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөрт, захиалгат, теле-худалдааны нэвтрүүлгийн талаарх зохицуулалт хийхтэй холбогдсон журмыг Зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд хяналт тавина.
3. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь дамжуулж байгаа суваг, хөтөлбөр дундуур зар сурталчилгааг нэвтрүүлж үл болно.
4. Онц байдал зарласан, эсхүл гамшгийн үеийн нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлж үл болно.
5. Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь Зар сурталчилгааны тухай хуулиар хязгаарласан сурталчилгаа бэлтгэж, нэвтрүүлэхийг хориглоно.
6. Төлбөртэй радио, телевиз болон теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн радио, телевизээр зар сурталчилгаа бэлтгэж, нэвтрүүлэхийг хориглоно.

Уг зохицуулалтаас үзвэл хуулиар Харилцаа холбооны зохицуулах хороонд “Радио, телевизээр дамжуулах аливаа хэлбэрийн зар сурталчилгааны хязгаарлалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөрт, захиалгат, теле-худалдааны нэвтрүүлгийн талаарх зохицуулалт хийхтэй холбогдсон журмыг Зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд хяналт тавих” бүрэн эрхийг олгосон гэж үзэж болох юм.

Үүний дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо 2020 онд 87 дугаар тогтоолоороо “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ыг баталж, журмын 6.1. “Зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, 24.3, 24.4, 24.6 болон энэхүү журмын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийж ажиллана”, 6.2. “Телевиз нь өөрийн редакцид баримтлах бодлого, зохицуулалтын хүрээнд энэхүү журмын 3.22-3.26, 4.6, 5.3, 5.4 дах заалтын хэрэгжилтэд дотооддоо хяналт, мониторинг хийж ажиллах бөгөөд журмын заалтыг мөрдөж ажиллаагүй нь илэрсэн, удаа дараа давтагдсан тохиолдолд холбогдох мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлж, холбогдох арга хэмжээг авна” гэж заасны дагуу хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Гэвч журам зөрчсөн албан тушаалтан, байгууллагад ямар хариуцлага хүлээлгэх талаарх эрх зүйн зохицуулалт журам болон Зөрчлийн тухай хуульд байхгүй тул уг журмын хэрэгжилт хангалгүй байна гэж үзэж болох юм.

Учир нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

14.15 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих

1.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэх, дамжуулах техник, тоног төхөөрөмжийн сүлжээний найдвартай ажиллагаа, стандартын шаардлагыг хангаагүй бол нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлд зааснаас бусад төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ, байршилд эрхэлсэн бол хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхийг хориглосон этгээд эрхэлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эндээс үзвэл “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”—ыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой хуульчлаагүй байна. Өөрөөр хэлбэл хууль зүйн хариуцлагын механизм хангалтгүй байна гэж дүгнэж болох юм.

3.6.2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль дахь зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжиж байгаа эсэх, уг асуудлыг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх талаар энэ бүлэгт авч үзье.

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭТРЭЛТИЙН ЗӨРЧИЛ ГАРГАСАН ЭСЭХ				
Нэг цаг тутамд нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа 15 (арван тав) минутаас илүүгүй байна.				
<i>2022 оны 10, 11, 12 дугаар сарын дүн - цаг:мин:сек</i>				

ТВ нэр	Зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчил /1 цагт 15 минут ихгүй/			
	10 сар	11 сар	12 сар	нийлбэр
TM	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
TenGer	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
ETB	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
Стар ТВ	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00
ТВ8	00:00:00	0:00:00	0:00:00	00:00:00

Сүлд	00:00:00	0:00:57	0:00:00	00:00:57
SBN	00:00:00	0:00:00	0:06:40	00:06:40
Ийгл ньюс	00:00:00	0:02:59	0:04:46	00:07:45
Монгол HD	00:00:00	0:00:00	0:09:12	00:09:12
Central ТВ	00:00:00	0:19:31	0:06:55	00:26:26
Малчин ТВ	00:25:21	0:01:12	0:00:00	00:26:33
С1	01:03:45	0:00:00	0:00:00	01:03:45
UBS	00:13:01	1:13:51	0:08:43	01:35:35
25-р суваг	00:06:00	0:13:31	1:35:00	01:54:31
Боловсрол суваг	00:34:32	0:57:45	1:49:55	03:22:12
ТВ5	00:39:49	1:03:09	2:26:08	04:09:06
ТВ9	00:48:26	2:01:29	2:57:33	05:47:28
NTV	01:56:21	4:21:19	4:55:50	11:13:30

· Зар сурталчилгааны нэг блокийн үргэлжлэх хугацаа 5 минутаас илүүгүй байна.

2022 оны 10, 11, 12 дугаар сарын нийлбэр – цаг:мин:сек

ТВ нэр	Зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчил цагаар /Блокын урт 5 мин/			
	10 сар	11 сар	12 сар	нийт
TenGer	00:00:00	0:00:00	0:00:02	0:00:02
Стар ТВ	00:01:07	0:00:00	0:00:00	0:01:07
ТМ	00:04:07	0:00:00	0:00:00	0:04:07
Монгол HD	00:00:28	0:01:01	0:04:05	0:05:34
ТВ8	00:00:56	0:05:51	0:00:00	0:06:47
Сүлд	00:09:34	0:01:35	0:00:00	0:11:09
SBN	00:00:13	0:01:59	0:09:07	0:11:19
ЕТВ	00:07:35	0:10:41	0:06:11	0:24:27
Ийгл ньюс	00:16:04	0:18:42	0:43:30	1:18:16
С1	02:37:31	0:06:05	0:06:27	2:50:03
25-р суваг	00:26:16	0:25:58	2:34:14	3:26:28
Боловсрол суваг	00:36:17	1:18:03	1:56:10	3:50:30
Малчин ТВ	04:13:02	0:20:21	0:05:56	4:39:19
ТВ5	00:56:58	0:31:08	4:18:55	5:47:01
ТВ9	00:38:31	1:46:36	3:35:23	6:00:30
Central ТВ	00:00:12	3:56:46	2:50:33	6:47:31
UBS	01:35:06	4:26:44	0:53:04	6:54:54
NTV	00:56:00	2:05:31	3:57:23	6:58:54

Эндээс үзвэл зар сурталчилгааны хэтрэлттэй байна.

Үүнд арга хэмжээ авсан эсэх талаарх мэдээллийг авч үзье.

Шигтгээ:

Зар сурталчилгааны зөрчлийн асуудлаар хэд хэдэн байгууллагад мэдэгдэл хүргүүлсэн. Мэдэгдэл хүргүүлэхээс өөрөөр арга хэмжээ авах боломжгүй байна. Зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчил дээр авч хэрэгжүүлэх хариуцлагын механизм тодорхой болгох шаардлагатай.

*Харилцаа холбооны зохицуулах
Хороотой хийсэн уулзалтын тэмдэглэлээс*

Эндээс үзвэл зар сурталчилгааны хэтрэлт болон зөрчлүүд гарч байгаа тул хууль зүйн хариуцлагыг тусгах зайлшгүй шаардлагатай байна.

3.6.3 Гадаадын зарим улс орнуудын туршлага буюу тохиолдол судлах.

Ихэнх улс орнууд тэр дундаа хөгжингүй улс орнуудын хувьд нийтлэг байдлаар зар сурталчилгаанд хориг буюу хязгаарлалт тавьдаг²⁸. Энэ нь зар сурталчилгаа явуулах хугацаа, агуулгын хүрээгээр тогтоогддог²⁹.

Англи улс

Англи улсад зар сурталчилгаатай холбоотой харилцааг зохицуулах эрх бүхий байгууллага болох зар сурталчилгааны хороо үйл ажиллагаа явуулдаг. Уг хороо нь салбарт бүрт тохирсон кодыг хэвлэн гаргадаг бөгөөд хэрэв түүнийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг.

Зар сурталчилгааны хэрэг эрхлэх газар нь гомдол хүлээн авч хянан шалгах үүрэг бүхий байгууллага бөгөөд эхний ээлжинд тус газар тухайн зөрчил бүхий зар сурталчилгааг стандартад нийцсэн байдлаар өөрчлөх, эсвэл зар сурталчилгаа явуулахаа зогсоохыг шаарддаг. Хэрвээ зар сурталчиггаа явуулсан этгээд тухайн шаардлагыг биелүүлэхгүй бол Хэрэг эрхлэх газар тэрхүү байгууллагын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авахаар шийдвэр гаргах эрхтэй. Тухайн зөрчил бүхий арга хэмжээ үргэлжилсээр байвал тухайн зар сурталчилгааг цацахгүй байлгах арга хэмжээг авч ажилладаг³⁰.

Оросын холбооны улс

Тус улсын хувьд зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчид болон бусад этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах, ёс зүйн дүрэм батлаж түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих зорилгоор ассоциаци, холбоо, нэгдэл зэргийг байгуулахаар зохицуулсан байдаг³¹.

Мөн хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлагын механизмыг Зар сурталчилгааны тухай хуульдаа тусгайлан зааж өгсөн байна. Жишээ нь: тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-д “Зар сурталчилгаа захиалагч нь энэ хуулийн 5.2.8 дахь хэсэг, 6-9 дүгээр зүйлд заасан шаардлагыг тус тус зөрчсөн гэж хариуцлага хүлээхгүй” гэж

²⁸ Television Advertising Standards Code / https://www.asa.org.uk/type/broadcast/code_section/10.html/

²⁹ Regulation of Television advertising, Simon P. Anderson, 2005.

³⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Зар сурталчилгаа ба гэм хор судалгааны тайлан.

³¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Зар сурталчилгаа ба гэм хор судалгааны тайлан.

хуульчилсан байх бөгөөд Зөрчлийн тухай хуульд зөрчил болон түүнд хүлээлгэх хариуцлагын төрлийг хуульчилсан³² байдаг.

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд найрамдах Солонгос улсын Зохиогчийн эрхийн тухай хуулиар³³ уг харилцааг зохицуулдаг. Зохиогчийн амины эрх зөрчигдсөн бол сэргээх, түүний улмаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх, олон байсан орлогыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авдаг.

Дараах Захиргааны хариуцлагыг хүлээлгэхээр хуульчилсан. Үүнд:

- Торгох
- Хурааж авч улсын орлого болгох (зохиогчийн эрх болон бусад
- эрхийн зөрчилтэй хуулбар, зөрчилд ашигласан багаж хэрэгсэл, хэвлэгч, түгээгч, тоглуулагч зэрэг)
- Хууль бус хуулбарыг хураан авах, устгах, арилгах
- Алдаагаа засахыг сануулах

Эрүүгийн хариуцлагын хувьд: Торгох, албадан хөдөлмөр эрхлүүлж, хорих хариуцлага хүлээлгэдэг.

Хохирол тооцох аргачлал: Зохиогчийн эд хөрөнгийн эрх болон бусад эрх (үүнд зохиогч болон уран бүтээлийн амины эрх хамаарахгүй) эзэмшигчийн энэхүү хуулиар хамгаалагдсан эрх санаатай болон болгоомжгүй байдлын улмаас зөрчигдсөн тохиолдолд учирсан хохирлоо барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй ба ингэхдээ хохирлын хэмжээг эрх эзэмшигчид учирсан бодит хохирол хэмжээ болон зөрчил гаргасан этгээдийн олсон орлогын хэмжээгээр тооцно. Мөн хохирлыг тухайн бүтээлийг бусдад ашиглуулснаар олох байсан орлогын хэмжээгээр тооцож болно, түүнчлэн хэрэв хохирлын хэмжээ нь олох байсан орлогын хэмжээнээс давсан тохиолдолд тэрхүү давсан хэмжээгээр нэмэгдүүлэн шаардаж болно. Шүүхээс хохирлын хэмжээг шууд тооцон тогтооход хүндрэлтэй тохиолдолд талуудын гаргаж буй үйл баримт, үндэслэл, нотлох баримтыг шинжлэн судлаж үндэслэлээ болгоно.

Оюуны өмчийн маргааныг шийдвэрлэх процесс

Солонгосын Зохиогчийн эрхийн комисс (СЗЭК): Солонгосын Зохиогчийн эрхийн комисс нь Иргэний хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх ба зохиогчийн эрх болон хамаарах эрхийн салбарт мэргэшсэн 20-оос цөөнгүй этгээдүүдийг ССАЖЯ-наас гишүүнээр томилох ба комисс нь зохиогчийн эрхийн маргааныг эвлэрүүлэн зуучлах, бүтээлийн хамгаалалт, шударга ашиглалт, эрх эзэмшигчдийн эрх, ашиг сонирхолыг дэмжих гэсэн үүрэгтэй.

СЗЭК нь аливаа этгээдийн гаргасан хүсэлтэд үндэслэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хийх ба талууд эвлэрсэн тохиолдолд тэмдэглэл үйлдэж, тухайн тэмдэглэл

³² <https://www.advesti.ru/>.

³³ <https://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=16953>

шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчинтэй. Эвлэрүүлэн зуучлах ажилагааны явцад талууд болон сонирхогч этгээдийн гаргасан мэдүүлэг, тайлбарыг шүүх болон арбитрын ажиллагаанд ашиглахгүй. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаан зардлыг талууд гэрээндээ тусгайлан заагаагүй тохиолдолд хүсэлт гаргагч тал хариуцна.

СЗЭК нь дараах тохиолдолд зохиогчийн эрхийн зөрчлийг тогтоох ажиллагааг хийх ба тогтоох аргачлал, дүрэм журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар харин тогтоох ажиллагааны зардлын хувь хэмжээг комисс өөөрөө тус тус батална. Үүнд.

- Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх болон мөрдөн байцаалтын явцад зохиогчийн эрх болон бусад эрхийн зөрчлийг тогтоолгох хүсэлтийг шүүх, мөрдөн байцаах газраас гаргасан;

- Маргааныг эвлэрүүлэн зуучлах явцад маргааны талууд программ, цахим мэдээллийг тогтоолгохоор хүсэлт гаргасан тохиолдлуудад тус тус. СЗЭК-ийн үйл санхүүжилтын төсвийг төрөөс баталж олгодог. Харин бүтээлийн шударга ашиглалтыг дэмжих, бүтээлийн ашиглалтыг төлөвшүүлэх төсөл; зохиогчийн эрхийн боловсрол, судалгаа, сурталчилгаа болон зохиогчийн эрхийн мэдээллийн менежментийн системийн үйл ажиллагаа болон бүтэц гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулж аливаа хувь хүн, хуулийн этгээдээс мөнгөн тусламж, дэмжлэгийг СЗЭК-д олгож болно.

СЗЭК дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

- Маргааныг зуучлах, эвлэрүүлэх;
- Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгчдийн ашиглалтын төлбөр, төлбөрийн хувь хэмжээний асуудлыг хянан хэлэлцэх болон ССАЖЯ-нд танилцуулах;
- Зохиогчийн эрхийн хамгаалалтын олон улсын хамтын ажиллагаа;
- Зохиогчийн эрхийн сурталчилгаа, судалгаа, боловсрол;
- Бүтээлийн шударга ашиглалтыг дэмжих, бүтээлийг ашиглалтыг төлөвшүүлэх төсөл
- Зохиогчийн эрхийн бодлогын томъёоллыг дэмжих;
- Технологийн хамгаалалтын арга хэрэгсэл болон эрхийн менежментийн мэдээллийн бодлогы томъёоллыг дэмжих;
- Зохиогчийн эрхийн мэдээллийн менежментийн системийн үйл ажиллагаа болон бүтэц;
- Зохиогчийн эрхийн зөрчлийг тогтоох;
- Комиссын дүрэмд даасан бусад чиг үүрэг;
- ССАЖЯ-наас олгосон бусад үүрэг.

Солонгосын зохиогчийн эрх хамгаалах агентлаг (СЗЭХА):

Засгийн газраас санхүүжилттэй, зохиогчийн эрх хамгаалах үйлчилгээ үзүүлэгч СЗЭХА нь Шүүхийн цагдаагийн албан хаагчдын үүрэг гүйцэтгэгч болон тэдгээрийн үүргийн хамрах хүрээний тухай хуульд зааснаар зохиогчийн эрхийн зөрчлийн журам, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Шүүх болон мөрдөн байцаах байгууллага:

Шүүх болон мөрдөн байцаах байгууллага нь дээр дурдсан буюу “Хариуцлагын нийтлэг зохицуулалт” гэсэн хэсгийн 1-4-д заасан зохиогчийн болон бусад эрхийн зөрчсөн тохиолдолд тухайн зөрчил маргааныг хянан шалгах болон шүүхээс холбогдох хариуцлагыг ногдуулдаг. Харин зохиогчийн эрх зөрчсөнөөс үүссэн хохирлыг шүүхийн журмаар үйл баримт, нотлох баримтад үндэслэн тогтоодог.

Зохиогчийн эрхийн маргааныг шийдвэрлэх процессийн хувьд шүүхийн өмнөх шатыг улс орон бүр хуульчилан зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл бие даасан Зохиогчийн эрхийн маргаан шийдвэрлэх комисс, Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх комисс зэрэг Кохиогчийн эрхийг маргааныг урьдчилан шийдвэрлэх байгууллагын эрх, үүрэг, бүтцийг тусгасан байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Аливаа эрх зүй талуудын эрх, үүрэг, түүнийг дагаж мөрдсөн болон зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг тодорхойлсон хэм хэмжээний тогтолцоо байдаг бөгөөд үр дагаврыг тодорхойлсон хэсгийг хууль зүйн хариуцлага гэж тодорхойлно. Хэрэв уг үр дагаврыг зохицуулахгүй орхигдуулбал хууль тогтоомж болон дүрэм журам хэрэгжихгүйд хүрэх юм.

Мөн аливаа эрх зүйн хэм хэмжээ гипотез, диспозици, санкци гэсэн логик бүтэцтэй байх бөгөөд санкци нь аливаа эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн үр дагаврыг зохицуулах, хэрэгжилтийн зорилгоо биелүүлэх гол хэрэгсэл болдог.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Харилцаа холбооны зохицуулах хороо Радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмыг батлах бүрэн эрхийг олгосон байдаг. Үүний дагуу уг журмыг баталсан боловч хийдэл гарч байгаа нь хариуцлагын асуудал орхигдсонтой шууд холбоотой юм.

Өөрөөр хэлбэл дээрх журмыг зөрчсөн телевиз, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь ямар хариуцлага хүлээх талаар зөрчлийн тухай хуулиар тодорхой санкцийг оруулж өгөөгүй нь зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалт хэрэгжихгүйд хүргэж байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Харилцаа холбооны зохицуулах хороо хариуцлагын асуудлыг журамдаа тусгах;

Хоёр. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмаар зохицуулж буй асуудлыг зохицуулах;

Гурав. Зөрчлийн тухай хуулийн 14.15-д зар сурталчилгаатай холбоотой Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд орсон заалтуудыг зөрчих зөрчил түүнд хүлээлгэх хариуцлагыг хуульчлах;

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОМЬЁОЛОЛ ДОЛОО.

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 20 ДУГААР ЗҮЙЛИЙН 20.1, 20.3 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

/Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн эрх зүйн зохицуулалт/

3.7.1 “Зорилгод хүрсэн түвшин” “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх эрх зүйн орчны талаар зохицуулсан байна. Тэр дундаа Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг ард иргэдэд алслагдсан, сүлжээ хүрээгүй газарт хүртээмжтэй хүргэх, үйлдвэрлэхэд өртөг өндөр үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн хүргэх, өргөн нэвтрүүлгийн радио телевизийн бүтээл үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх санг төрөөс санхүүжүүлж, бүтээлийн хувь хэмжээний шаардлага хангасан байдал болон олон нийтэд хүртээмжтэй байдлыг харгалзан үзэж уг сангийн хөрөнгийг зарцуулахаар зохицуулсан байна.

Үүнтэй холбогдуулан уг сангийн эрх зүйн байдал, болон түүний хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлтийн талаар нарийвчилсан журмын төслийг эрх бүхий байгууллагуудтай хамтран боловсруулж, Засгийн газраас батлахаар заасан байдаг.

Уг журам батлагдаагүй байгаа тул энэ зохицуулалтын хувьд зорилгодоо хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд зорилгодоо хүрээгүй гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг “Засгийн гзарын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах” зорилгоор баталсан бөгөөд Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

1. улсын болон орон нутгийн төсөв;
2. дотоодын аж ахуйн нэгжийн хандивын хөрөнгө;
3. бусад эх үүсвэр.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар “хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын бүх тусгай сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, удирдлага, зохион байгуулалт болон хяналт тавих харилцаанд энэ хууль үйлчилнэ” гэж заасан бол Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрөөр заасан байх тул Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баримтлахаар байна.

Гэтэл Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиуд нь зөрчилдөөнтэй байгаагаас буюу Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн эх үүсвэр тодорхойгүйгээр уг сан бүрдэхгүй нөхцөл байдал бий болсон байна.

Иймд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн зохицуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай уялдуулан өөрчлөх шаардлагатай байна. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх санг байгуулаагүй байх тул Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийх боломжгүй байна.

Өөрөөр хэлбэл Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.2-д заасан тохиолдол үүсээгүй учраас үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзэж болох юм.

3.7.2 Гадаадын зарим улс орнуудын туршлага буюу тохиолдол судлах.

Хэвлэл мэдээллийн салбарын нэг чухал асуудал бол төрийн дэмжлэг болон татаас юм. Эдийн засагчдын дунд чанартай, найдвартай мэдээллийг олон нийтэд түгээх, хариуцлагатай хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дэмжихэд чөлөөт зах зээлд тулгуурласан зохицуулалт дангаараа хангалтгүй тул ардчилсан нийгмийн төгөлдөржүүлэхэд төрийн тодорхой дэмжлэг зайлшгүй гэж үзэл байдаг³⁴ бөгөөд ихэнхи судлаачид төрийн дэмжлэг хууль ёсны үндэслэлтэй зүйл гэж үздэг байна.

Дийлэнхи тохиолдолд улс орнууд тусгай зөвшөөрлийн хураамжаас эсвэл шууд төсөв төсөвлөн санхүүжүүлдэг. Шууд татаасаас илүүтэй шууд бус татаасыг гол төлөв хэрэглэдэг нь хэвлэл мэдээллийн салбарын төрөөс хараат бус байдлыг хангахад илүү үр нөлөөтэй гэж үздэгээс үүдэлтэй юм.

Дараах төрлийн дэмжлэг, татаасын хэлбэрүүд байна. Үүнд:

- Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг шууд санхүүжүүлэх;
- Хувийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг шууд бусаар санхүүжүүлэх;
- Хувийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг шууд санхүүжүүлэх, дэмжих;
- Хувийн хэвлэл мэдээллийн салбарт шинээр үүсч буй цахим үйлчилгээнд төрөөс дэмжлэх үзүүлэх;

Эндээс үзвэл дэлхийн улс орнуудад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийг төрөөс шууд болон шууд бусаар дэмжлэг үзүүлдэг байна. Монгол Улсын хувьд Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлсэн нь олон улсын жишигт нийцсэн чухал зохицуулалт юм.

³⁴ Hamilton James (2004), All the news that's Fit to Sell? How the market Transforms information into News (Princeton university Press)

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

Үнэлэх үе шатны төгсгөлд томьёолсон шалгуур үзүүлэлтэд тулгуурлан дараах байдлаар дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулна. Үүнд:

- Үнэлгээг илэрхийлсэн дүгнэлт гаргах;
- Үнэлгээний үр дүнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох зөвлөмж гаргах;

4.1 Үнэлэлт, дүгнэлт

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн сонгон авсан зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт хэрэгжсэн байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

Үнэлгээний үр дүнг зүйл заалт бүрээр дүгнэхэд дараах байдалтай байна.

4.1.1 ӨНТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6. “Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь энэ хуулийн 20.5.3-т заасан хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна” гэсэн заалтын

Зорилгод хүрсэн түвшин:

ӨНТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтаар Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн санхүүжилтын байдлын талаар зохицуулсан байх бөгөөд уг зохицуулалт зохих түвшинд хэрэгжиж хуульд заасан үндэслэл журмын дагуу Монголын телевизүүдийн холбоо байгуулагдсан хэдий ч цаашид Монголын телевизүүдийн холбоонд төвлөрсөн орлогыг үзэлтийн судалгааг үндэслэн хувиарлах, үзэлтийн судалгааг шударгаар гаргах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Уг заалтын практик хэрэгжилтийн талаар мэргэжлийн холбоодоос судалгаа авахад телевиз үзэлтийн судалгааг гаргах боломжгүйн улмаас Монголын телевизүүдийн холбоонд төвлөрсөн үйлчилгээний орлого хувиарлагдах боломжгүй нөхцөл байдал үүссэн гэдэг нь тодорхой байна.

Үүнийг судалгааны албан ёсны үзэлтийн рейтингийг стандартын дагуу тодорхойлдог байгууллагуудыг сонгон шалгаруулалт зарлаж хийлгэх, олон талууд оролцсон судалгааны хараат бус төв байгуулж гарсан үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагуудаар хянуулж хийлгэх гэх мэт байдлаар шийдвэрлэх боломжтой байна.

- ОСДҮЭ-ийн үйлчилгээний үндсэн багцын ӨНТ-ийн үйлчилгээний орлогын дээд хязгаарыг тогтоох.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3 “... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр

өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” гэсэн заалтын “ ... 15 хувиас доошгүй ...” гэсэн хэсгийг өөрчлөн дээд хэмжээг тогтоож өгөх санал мөн гаргасан байна.

Эндээс дүгнэн үзэхэд хэдий үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр Монголын телевизүүдийн холбоо авах ч уг мөнгө нь олно суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс бус хэрэглэгчдээс гарч байгаа тул уг хувь хэмжээний дээд хязгаарыг тогтоож өгөх нь хэрэглэгчийн эрх ашгийн үүднээс чухал зохицуулалт болох юм.

- Монголын телевизүүдийн холбооны санхүүжилт, түүний хувиарлалтын ил тод байдал.

Уг заалт нь хэрэгжилтийн хувьд хангалтгүй байгаа тул түүнийг шийдвэрлэх, хууль зүйн хариуцлагын механизмыг тодорхой хуульчлах шаардлагатай байна.

- 20.8.Энэ хуулийн 20.5.3-т заасан хөлс нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлогоос хасагдана

Энэ зохицуулалтийн хэрэгжихгүй байгаа гол шалтгаан нь холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулаагүйтэй холбоотой байна. Тухайлбал: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль дахь татвараас чөлөөлөх орлогын эрх зүйн зохицуулалтад тусгах шаардлагатай.

4.1.2 20 дугаар зүйлийн 20.5.1 “техник холболтын зааглах цэг, нөхцөлийг тогтооход Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4-т заасан журмыг баримтлах” гэсэн заалтын

Зорилгод хүрсэн түвшин:

ӨНТХ-ын 20 дугаар зүйлийн 20.5.1 “техник холболтын зааглах цэг, нөхцөлийг тогтооход Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4-т заасан журмыг баримтлах” гэсэн заалтын тухайд:

Уг зохицуулалтын хүрээнд холбогдох журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо ӨНТХ-ын үндсэн зорилгод нийцүүлэн батлаж, үүний дагуу техник холболтын зааглах цэг нөхцлийг тогтоож байгаа нь зорилгодоо хүрсэн гэж үзэж болох юм.

Практик хэрэгжсэн байдал:

Техник холболтын зааглах цэг, нөхцлийг тогтоох журмын хэрэгжилтийн байдал буюу практик байдлыг авч үзвэл ярилцлагын судалгааны үр дүнд дараах нөхцөл тогтоогдож байна.

ОСДҮЭ-ид болон Телевизүүд хоорондоо холболт хийхдээ “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын дагуу хийгдэж байна. Журамд шаардлагатай мэдээллүүд орсон, мөрдөж ажиллавал заалтууд нь тодорхой заагдсан байна.

Харилцан холболтын журмыг хэрэгжүүлэхдээ зарим заалтуудыг дахин харж товч ойлгомжтой хэлбэрт оруулах нь зүйтэй. Тухайлбал Журмын хавсралт 1-ийн 4 дэх заалтыг товч энгийн байдлаар хийх шаардлагатай байна.

Техник холболтын журмын дээр дурьдсан заалтад холболтууд 4 хэлбэрээр хийгдэхээр заагдсан боловч практик дээр ихэнхдээ 2 хэлбэрээр нь хийгдэж байгааг анхаарах шаардлагатай байна.

Гэрээний загварын 2.2 дугаар зүйлийн 2.2.1 дэх дэх хэсэгт “Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна” гэсэн заалтыг Операторууд мөрдөх боломжгүй байна. Учир нь гуравдагч компаниар холболт хийгдсэн үед зааглах цэгийг дамжуулагч тал хариуцах боломжгүй байгаа нь харагдаж байна.

“ХХЗХ-ны вэбсайтад баталгаажсан гэрээнүүдийн харьцуулалтаас харахад шилэн кабелийн түрээсийн зардлыг түүний уртаар жишээ нь эхний км-ийн үнэ, дараагийн км бүрт тогтоосон үнийг баримталбал нийт гэрээ байгуулагчдад жигд үнийн төлбөр тогтоох боломжтой байна. Үүнээс гадна гуравдагч компаниар холболтыг хийлгэсэн тохиолдолд Телевиз үүнийгээ тусдаа гэрээгээр зохицуулж болох ба гэрээ хийх зөвлөмжид тусгаж өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна. Ихэвчлэн энэ төрлийн үйлчилгээг үзүүлдэг компани байх учир дээрх км-ээр тооцсон тарифаас хол зөрөхгүй юм” гэсэн саналыг оруулж байна.

Орон нутагт Телевизийн үйлчилгээ эрхлэгчийн санхүүгийн боломжийг харгалзан тухайн хот, аймаг, сумын төвд нэгдсэн нэг холболтын цэгт тулгуурлан холболтоо хийдэг байх нь зохимжтой байна. Шалтгаан нь тухайн орон нутагтаа Телевизүүд цөөхөн, мөн цөөн тооны олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчидтэй холбогддог, газар нутгийн хувьд зай бага учир холболтын зардал бага гарна. Мөн төрийн өмчийн мэдээлэл холбооны салбаруудыг түшиглэн энэ ажлыг зохион байгуулахад хүндрэл бага гарах юм. Ингэснээр орон нутгийн Телевизүүдэд оногдох холболтын зардлууд эрс буурах юм.

ХХЗХ-ны ажлын хэсгийн дүгнэлт зааглах цэгийн цэгийн зохистой байрлал, үнэ тарифын нэгдсэн бодлогод шийдвэрлэх хариуг гарах ба үүнийг судалгаандаа авч оруулах нь зүйтэй байна.

ӨНТХ-ын 20 дугаар зүйлийн 20.5.4 “бусад арилжааны радио, телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан тохиролцох” (төлбөр) гэсэн заалтын

Практик нийцэж буй байдал:

Төлбөрийн талаар гардаг маргаан нь ихэвчлэн дамжуулалтыг хариуцаж байгаа тусгай зөвшөөрөлтэй компаниудад тарифийн нэгдсэн нэг үнийг баримтлах зөвлөмжгүй байгаагаас шалтгаалж байна. Энэ нь операторуудын зөрүү ихтэй үнийн тарифаас харагдаж байна.

Мөн энэ талаар Монголын телевизүүдийн холбооноос дэвшүүлсэн саналаас үзэхэд уг зохицуулалт нь хэрэгжихэд асуудалгүй байгаа талаар хэлсэн бөгөөд тухайн арилжааны телевиз чанартай контент хийж байгаа тохиолдолд контентын төлбөрийг олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид төлж байна. Жишээ нь moviebox Asianbox зэрэг сувгууд байна.

4.1.3 Орон нутгийн телевизүүдийн төрийн бодлогоор дэмжих эсэх.

Орон нутгийн телевизүүдэд төрийн дэмжлэг тодорхой хэмжээнд зайлшгүй шаардлагатай байгаа нь хэвлэлийн эрх чөлөө тэр дундаа мэдээлэл авах эрхийг хангах үндсэн нөхцөл болох юм. Энэ нь ярилцлагын судалгааны үр дүн болон харьцуулсан судалгааны үр дүнгээс тодорхой харагдаж байна.

Манай улсын өнөөгийн нөхцөл байдлын хувьд Монголын телевизүүдийн холбоонд төвөрлөсөн орлогоос үзэлтийн судалгааг үндэслэн авах эрхтэй боловч үзэлтийн судалгаа гарч чадахгүй байгаагийн улмаас уг орлогоос авах боломжгүй нөхцөл байдалд байна. Харин орон нутгийн төрийн захиргааны байгууллага, хувийн байгууллагууд тодорхой хэмжээнд дэмжин ажиллаж байгаа бөгөөд энэ нь орон нутгийн телевизүүдийн үндсэн орлого болж байна. Орон нутгийн телевизүүд хараат бусаар үйл ажиллагаа явуулахын тулд санхүүгийн хувьд хараат бус байх нь чухал байх тул төрөөс шууд болон шууд бус дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

4.1.4 ӨНТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.7 “Үндэсний олон нийтийн телевиз болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгууд нь олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын эхэнд байна” гэсэн заалтын

Зорилгод хүрсэн түвшин:

Сувгийн дарааллын эрх зүйн зохицуулалт нь хуулийн Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүүхэд, залуучуудын хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхгүй байх, Өргөн нэвтрүүлгийн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгод нийцэхүйц байх ёстой бөгөөд арилжааны телевизүүдийн шударга өрсөлдөх нөхцлийг хаасан зохицуулалт болсон гэж дүгнэж болох юм.

Практикт хэрэгжсэн байдал:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь заалт нь хуулийн зорилгод тодорхой хэмжээнд хүрч байна. Гэвч сувгийн дараалал тогтоосноор Арилжааны телевиз эрхлэгчдэд болон Орон нутгийн телевиз эрхлэгчдэд багагүй хүндрэл учирсан гэж ойлгогдохоор байна. Сувгийн дарааллын гол зорилго бол ард иргэдэд зайлшгүй шаардлагатай боловсрол, халамжийн хөтөлбөрүүдийг хүргэх, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт нийцсэн шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай. Харин АНУ-ын “Дахин дамжуулах гэрээ”-ээс жишээ авч хэрэгжүүлэх, сувгийн дараалал хамаарахгүй өрсөлдөх боломж гарах бөгөөд Засгийн газар, төрийн хяналтгүйгээр гэрээний үндсэн зарчим дээр өөрсдийн үйл ажиллагааг явуулах боломжтой байдаг.

Мөн сувгийн дарааллын эрх зүйн зохицуулалт нь шударга өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалт гэдгийг мэргэжлийн оролцогчид хүлээн зөвшөөрч байна.

Иймд уг зохицуулалтыг хасах, эсвэл өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

4.1.5 ӨНТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 “оюуны өмчийн эрхийг удаа дараа зөрчсөн нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тусгай зөвшөөрлийг 90 хоногоор түдгэлзүүлнэ” гэсэн заалтын

Зорилгод хүрсэн түвшин:

Зохиогчийн эрхийг хамгаалах зорилгоод олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд оюуны өмчийн зөрчилтэй контентийг хаах, түр зогсоох эрхийг олгосон нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн үндсэн зорилт болох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн шударга өрсөлдөөнийг хангахтай холбоотой чухал зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл уг зохицуулалт нь өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн шударга өрсөлдөөнийг хангах хуулийн үндсэн зорилгод нийцэхүйц байна.

Практикт хэрэгжсэн байдал:

Зохиогчийн эрхийн тухай хуулиар олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдэд Оюуны өмчийн зөрчилтэй контентийг хаах эрхийг олгосон зохицуулалтын хувьд оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн чухал зохицуулалт болсон байна. Учир нь аливаа эрхийг зөрчигдсөний дараа бус зөрчигдөхөөс өмнө хамгаалах нь чухал юм. Гэвч уг зохицуулалт хэрэгжилтийн хувьд төдийлөн үр дүнгүй байна.

4.1.6 Зар сурталчилгааны хэтрэлт, түүний эрх зүйн зохицуулалт.

Зорилгод хүрсэн түвшин:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзвэл зар сурталчилгаа хэтрэлттэй байгааг гол шалтгаан нь хууль зүйн хариуцлагын асуудлыг нэг мөр тодорхой болгоогүйтэй холбоотой байна. Үүнээс үүдэн уг зохицуулалт зорилгодоо хүрээгүй гэж дүгнэж болох юм.

Практикт хэрэгжсэн байдал:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд зар сурталчилгааны хэтрэлтийн статистик мэдээ болон түүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар эрх бүхий байгууллагаас судалгаа авсан бөгөөд практик хэрэгжилт хангалтгүй байгаа гол шалтгаан нь хууль зүйн хариуцлагын механизм тодорхой бус байгаа явдал гэж дүгнэж болохоор байна.

4.1.7 Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн эрх зүйн зохицуулалт.

Зорилгод хүрсэн түвшин:

Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд судлан үзэхэд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд уг сангийн эх үүсвэрийг зөрүүтэй тусгасан нь тус санг байгуулах боломжгүй нөхцөл байдалд хүргэж байна гэж дүгнэж байна.

Иймд уг заалт зорилгодоо хүрээгүй гэж дүгнэсэн болно.

Практикт хэрэгжсэн байдал:

Нэгэнт уг заалтын дагуу уг санг байгуулаагүй учир практик хэрэгжилтийн байдлын судлах боломжгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Үнэлгээний үр дүнд буюу үнэлгээг илэрхийлсэн дүгнэлтэд хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах саналыг дэвшүүлж байна.

1. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын хүрээнд Телевиз үзэлтийн судалгааг шударгаар гаргах нөхцлийг бүрдүүлэх зайлшгүй шардлагатай байна. Ингэхдээ судалгааны албан ёсны үзэлтийн рейтингийг стандартын дагуу тодорхойлдог байгууллагуудыг сонгон шалгаруулалт зарлаж хийлгэх, олон талууд оролцсон судалгааны хараат бус төв байгуулж гарсан үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагуудаар хянуулж хийлгэх, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээр хийлгэх гэх мэт байдлаар шийдвэрлэх боломжтой байна.
Үзэлтийн судалгаа хийгдэх техникийн боломжийн хувьд ихэнх олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид хийж болох нь тодорхой байгаа учир энэ үзэлтийн судалгааг зөв байгууллага дээр, зөв аргачлалаар яаралтай хийж Телевизүүд болон нэвтрүүлгийн рейтингийг тогтоож явах нь салбарт тулгамдаж байгаа олон асуудлуудыг шийдвэрлэх гарц, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн чухал алхам болох юм. Арилжааны телевизүүд мөн энэ судалгаанд хамрагдаж салбарт үйлчилгээгээ үзүүлж байгаа нийт телевизүүдийн үзэлт ил болж зах зээлд шударга өрсөлдөх зарчмыг хангах суурь болж өгөх юм. Ингэснээр ӨН-ийн нөхцөл шаардлага, ачааллыг хангаж ажиллаж чадах арилжааны телевизүүд шалгарч үзэгчдийн төлбөр сайн контент, сайн нэвтрүүлэгт хуваарилагддаг шударга зарчим хэрэгжиж эхлэх юм.
2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3 “... үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах” гэсэн заалтын “ ... 15 хувиас доошгүй ...” гэсэн хэсгийг өөрчлөн дээд хэмжээг тогтоож өгөх.
3. Монголын телевизүүдийн холбоонд төвлөрсөн Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний үндсэн багцын орлогын хувиарлалтын ил тод байдлыг хангахын тулд түүнд хүлээлгэх хариуцлагын механизмыг тодорхой болгож хуульчлах.
4. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.8-д “Энэ хуулийн 20.5.3-т заасан хөлс нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн албан татвар ногдох орлогоос хасагдана” гэсэн зохицуулалтын хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль дахь татвараас чөлөөлөх орлогын эрх зүйн зохицуулалтад нэмж тусгах шаардлагатай.
5. Зарим Арилжааны телевизүүд одоогоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5 дугаар зүйлийн 20.5.3, 20.5.4 зэрэг заалтуудыг шударга бус гэж үзэж ОСДҮЭ-тэй ямар нэг харилцан холболтын гэрээ байгуулаагүй байна. Энэ нь эрх зүйн нарийвчилсан зохицуулалт, тогтолцоо шаардлагатайг харуулж байна.
Мөн ОСДҮЭ нар болон Телевизүүдийн ихэнх нь “Нэгдсэн Холболтын Төв” байгуулж ашиглах саналтай байна. Энэ нь хоёр талд гарах холболтын зардлууд буурч, шилэн кабелийн одоогийн холболтууд цэгцэрч, тасралтгүй найдвартай ажиллагаа сайжрах давуу талтай.

6. Орон нутгийн телевизүүдэд Монголын телевизүүдийн холбооноос олгох үйлчилгээний орлогоос гадна төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн журам батлагдсан тохиолдолд орон нутгийн телевизүүдийн санхүүжилт тодорхой хэмжээнд шийдвэрлэгдэх боломжтой байна.
7. Сувгийн дарааллын асуудал бол Үндэсний аюулгүй байдлын үүднээс иргэдэд зайлшгүй чухал мэдээлэл, хөтөлбөрийг хүргэх чухал зохицуулалт байна. Гэвч уг зохицуулалт нь өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн болон арилжааны телевизүүдийн хоорондын шударга өрсөлдөх нөхцлийг хааж байгаа төдийгүй технологийн хувьд цаашид хэрэгжих боломжгүй болох тул уг зохицуулалтыг өөрчлөх, уг асуудлаар бие даасан судалгаа хийх нь зөв юм.
8. Оюуны өмчийн зөрчил түүний шийдвэрлэлтийн хувьд хууль зүйн хариуцлагын механизмыг тусгасан нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн зорилтыг хангаж байна. Гэвч олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд оюуны өмчийн зөрчилтэй контентийг шууд хаах эрхийг олгосон зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай.
9. Зар сурталчилгааны хэтрэлтийн асуудлын тухайд: Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам" -ын хэрэгжилт хангалтгүй байгаа нь түүний хариуцлагын механизмыг суулгаж өгөөгүйтэй шууд холбоотой байх тул холбогдох хууль болох Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
10. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах эсвэл Засгийн тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар уг заалт хэрэгжих боломж нөхцөл бүрдэхээр байна.

Ашигласан материал:

Нэг. Хууль тогтоомж, Олон улсын гэрээ, бусад хууль эрх зүйн актууд

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль,
3. Харилцаа холбооны тухай хууль,
4. Олон нийтийн радио телевизийн тухай хууль,
5. Өрсөлдөөний тухай хууль,
6. Хүний эрхийн түгээмэл тунхаглал,
7. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт,
8. НҮБ-ын зөвлөмжүүд,
9. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал,
10. Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм,
11. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага,
12. ХХЗХ 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 73 тоот тогтоолын хавсралт
Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг
бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам,
13. ХХЗХ-ны 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолын
хавсралт Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн
нөхцөл шаардлага,
14. Өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударгаар өрсөлдөх, зах зээлийн хэт төвлөрөл
үүсэхээс сэргийлэх журам,
15. Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий
журам,
16. Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам,
17. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны 07 дугаар тогтоолын
хавсралт, Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий
нөхцөл шаардлага,
18. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан бусад дүрэм, журам,

Хоёр. Ном, судалгаа, тайлан, төсөл, илтгэл, эмхтгэл

1. Г.Совд., Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар.
2. Глоб интернешнл, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан., УБ., 2021 он.
3. Хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан., УБ., 2021 он.
4. НҮБ-ын хүний эрхийн зөвлөлийн 36 дахь удаагийн тайлан., УБ., 2020 он.
5. Иргэдийн оролцоо төсөл., судлаач Л.Галбаатар нар., Монгол улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь /судалгааны хураангуй тайлан./, УБ., 2021 он.
6. Харилцаа холбооны зохицуулах хороо, Өргөн нэвтрүүлгийн газар., Телевизийн салбарын мониторинг, УБ., 2021 он
7. Максима медиа ХХК., Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан., УБ., 2019, 2020 он.
8. Харилцаа холбооны зохицуулах хороо, Орон нутгийн телевизүүдийн 2022 оны 1 дүгээр улирлын нэгдсэн мониторингийн нэгдсэн дүн.

9. Харилцаа холбооны зохицуулах хороо, Улаанбаатар хотын телевизүүдийн 2022 оны 1 дүгээр улирлын нэгдсэн мониторингийн нэгдсэн дүн.
10. Хэвлэлийн хүрээлэн, Мэдээлэл судалгааны алба, Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа УБ., 2015 он.
11. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, 2018 он
12. Зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсгэхээс сэргийлэх журмын тайлбар.
13. Харилцаа холбооны зохицуулах хорооноос Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайлан., 2022 он.
14. Хууль зүйн үндэсний хүрээлэн., Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан.
15. Hamilton James (2004), All the news that's Fit to Sell? How the market Transforms information into News (Princeton university Press)
16. Press Subsidies in Europe (edited by Isabel Fernandez Alonso, Miquel de Moragas, Jose Joaquin Blasko Gil, Niria Almiran), pp. 68-69.

Судалгааны тайлангийн хавсралт

Арилжааны телевизүүдийн холбооноос тодруулах асуулт:

1. Арилжааны телевизүүдийн өмнө тулгамдаж буй ямар асуудал байна вэ? /өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Өргөний телевизүүд Монголын телевизүүдийн холбоонд төвлөрсөн орлогыг хувааж авах талаар санал/
2. Сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох боломжтой юу? Сувгийн дарааллыг хуульчлах нь хэр зөв хувилбар вэ?
3. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.4 дэх заалттай холбоотой ямар асуудал байна вэ?
4. Санхүүжилтийн хувьд бусад нөхцөл байдлын хувьд тулгамдаж буй асуудал юу вэ? /Өргөн нэвтрүүлгийн тухай хуультай холбоотой/.
5. Арилжааны аль нэг телевизтэй холбогдвол аль телевизийг судалгаанд хамруулж болох вэ? /Мэдээллийг нь авах/.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс тодруулах асуулт:

1. Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багц байх шаардлагатай эсэх, иргэд өөрсдөө багц бүрдүүлэх боломжтой эсэх тухай санал.
2. Сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоож болох уу.
3. Өргөн нэвтрүүлгийн телевизүүд олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын 15 хувиас доошгүй орлогыг авах нь зөв үү
4. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч байгууллагуудаас үзэлтийн судалгааг гаргах боломжтой эсэх.
5. Үндсэн багцын дээд доод үнийн хязгаарыг хэрхэн тогтоодог вэ?
6. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой бусад саналууд.

СУДАЛГААНЫ АСУУЛГА

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлын хүрээнд энэхүү судалгааг авч байгаа бөгөөд дараах асуултанд хариулж өгнө үү.

Телевизийн нэр: _____

Утасны дугаар: _____

Асуулт1. Танай телевиз Монголын телевизийн холбооноос олгох өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогоос авч чаддаг уу?

Гийм

Үгүй

Асуулт2. Танай телевиз санхүүжилтаа хэрхэн шийдвэрлэдэг вэ?

Асуулт 3. Монголын телевизүүдийн холбоонд төвлөрч буй орлогын хувиарлалтын талаар саналаа бичнэ үү. /хэрхэн зохицуулбал оновчтой байх вэ/.

Асуулт 4. Сувгийн дарааллийг зохицуулах талаар өөрийн саналаа бичнэ үү.

Асуулт 5. Иргэд өөрсдөө сувгийн дарааллыг тогтоох боломжтой болбол энэ нь зах зээлд шударга өрсөлдөх зөв шийдэл болж чадах уу?

Асуулт 6. Өргөн нэвтрүүлгийн 18 сувгийн тоо нь их үү. /хэд байвал зохимжтой вэ/.

- Тийм
- Үгүй
- _____

Асуулт 7. Зар сурталчилгааны хориглосон зохицуулалтыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд тусгах зайлшгүй шаардлагатай эсэх талаар саналаа бичнэ үү.

Асуулт 8. Өргөн нэвтрүүлгийн телевизүүд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс үндсэн багцын 15%-иас доошгүй орлогыг авахаар заасан боловч олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид үндсэн багцын үнэ дээр нэмж 2,500 төгрөг авч байгаа нь хэр зохимжтой үйлдэл вэ?

Асуулт 9. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдтэй холбоотой зохицуулалт нь өрсөлдөөний хувьд Арилжааны телевизүүдэд нөлөөлж буй эсэх

Асуулт 10. ОСДҮЭ-тэй хөтөлбөрийн гэрээ байгуулж, ОСДҮЭ талаас төлбөр авч, орлого хуваах (харилцан тохиролцох зарчмын хувьд), зохицуулалт нь хэр хэрэгжилтийн талаар саналаа бичнэ үү.



Судалгаа бөглөсөн: _____

Хүсэлт гаргах нь

Өмгөөллийн Заяа энд Золоо ХХК нь Цахим Хөгжил Харилцаа Холбооны яамнаас зарласан “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, санал зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд салбарын төрийн болон төрийн бус байгууллага, үйлчилгээ эрхлэгчид, хэрэглэгчийн оролцоог тэгш хангаж байгаа эсэх өнөөгийн нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар эрх бүхий байгууллагуудад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулан ажиллаж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “*Тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 14.12-т зааснаас гадна дараах үндэслэлээр 90 хүртэл хоногийн хугацаагаар түдгэлзүүлнэ*”, 14.1.3-т “*оюуны өмчийн эрхийг удаа дараа зөрчсөн нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон*” гэж заасан.

Уг хуулийн заалттай холбоотойгоор өргөний нэвтрүүлэгтэй холбоотойгоор оюуны өмчийн эрхийн зөрчил гарч байсан эсэх, гарч байсан бол хэрхэн арга хэмжээ авч байсан талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.МӨНХЗУЛ

МОНГОЛЫН ТЕЛЕВИЗҮҮДИЙН
ХОЛБООНД

Судалгаа авах тухай

Өмгөөллийн Заяа энд Золоо ХХК нь Цахим Хөгжил Харилцаа Холбооны яамны захиалгаар “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, санал зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээ”-г хийж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд салбарын төрийн болон төрийн бус байгууллага, үйлчилгээ эрхлэгчид, хэрэглэгчийн оролцоог тэгш хангаж буй эсэх болон өнөөгийн нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллагуудад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулан ажиллаж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн зорилгыг “...*өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино*” гэж тодорхойлсон байх бөгөөд Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн эрх зүйн зохицуулалт уг зорилготой нийцэж буй эсэх талаар болон практикт ӨН телевизүүдэд ямар хүндрэл байгаа талаар судалгаа авч байна.

Иймд Судалгааны асуулга/хавсралт/ -ыг бөглөж 2023 оны 09 сарын 04-ний дотор хүргүүлж бидний ажилд туслалцаа үзүүлнэ үү.

Энэхүү судалгааны үндсэн дээр бидний дүгнэлт гарч цаашид хуульд өөрчлөлт оруулах, хуулийн заалтыг хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг шийдэлд хүрэх тул та бүхэн идэвхтэй судалгаанд хамрагдана уу.

Судалгааны асуулгыг бөглөн Dorjsuren@zzlawfirm.mn хаяг руу явуулж өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.МӨНХЗУЛ

СУДАЛГААНЫ АСУУЛГА

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлын хүрээнд энэхүү судалгааг авч байгаа бөгөөд дараах асуултанд хариулж өгнө үү.

Телевизийн нэр:

Утасны дугаар:

Асуулт1. Танай телевиз Монголын телевизийн холбооноос олгох өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогоос авч чаддаг уу?

Гийм

Үгүй

Асуулт2. Танай телевиз санхүүжилтаа хэрхэн шийдвэрлэдэг вэ?

Асуулт 3. Монголын телевизүүдийн холбоонд төвлөрсөн орлогын хувиарлалтын талаар саналаа бичнэ үү. /хэрхэн зохицуулбал оновчтой байх вэ/.

Асуулт 4. Сувгийн дарааллийг зохицуулах талаар өөрийн саналаа бичнэ үү.

Асуулт 5. Иргэд өөрсдөө сувгийн дарааллыг тогтоох боломжтой болбол энэ нь зах зээлд шударга өрсөлдөх зөв шийдэл болж чадах уу?

Асуулт 6. Өргөн нэвтрүүлгийн 18 сувгийн тоо нь их үү. /хэд байвал зохимжтой вэ/.

- Тийм
- Үгүй

Асуулт 7. Монголын телевизүүдийн холбооны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар нээлттэй мэдээлэл авч чаддаг уу. Монголын телевизүүдийн холбоо мөнгө хувиарласан тайландаа аудит хийлгэх үүргээ биелүүлдэг үү.

Асуулт 8. ОСДҮЭ-д 2,500 төгрөг үндсэн багцын үнэ дээр нэмж авч байгаа асуудал дээр ямар саналтай байгаа вэ? /Үндсэн багцын үнийн дээд хэмжээг тогтоох шаардлагатай эсэх/

Асуулт 9. Зар сурталчилгааны хориглосон зохицуулалтыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд тусгах зайлшгүй шаардлагатай эсэх талаар саналаа бичнэ үү.

Асуулт 10. Өргөн нэвтрүүлгийн телевизүүд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс үндсэн багцын 15%-иас доошгүй орлогыг авахаар заасан боловч олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид үндсэн багцын үнэ дээр нэмж 2,500 төгрөг авч байгаа нь хэр зохимжтой үйлдэл вэ?

Бусад санал

УУЛЗАЛТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ОНЦЛОГ, ТЭДНИЙ САНАЛУУД

“ШИНЭ САНСАР ХХК”

2023 08 14

Гүйцэтгэх захирал Болдбаатар


Сүлжээ хариуцсан захирал Ганхуяг

Маркетинг хууль хариуцсан ажилтан Сайнцог нар байлцав.

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал. Телевизийн сувгийг дамжуулахад үүсэх техник холболтын гэрээний зааг ялгааг тодорхой болгох, мөн зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг эсэх талаар.

Бид Дундын холболтын цэгээ баримталдаг. Энэ асуудал дээр Телевизүүдтэй маргаан гардаг.

ОСДҮЭ-ид бид сүлжээний ашиглалт үйлчилгээ хариуцдаг субъект биш юм. Бид бол Б зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч. Бид А зөвшөөрөлтэй компаниар дамжуулж телевизүүдтэй үйлчилгээ үзүүлдэг.



Телевизүүд манай компанитай холбогдохдоо дунд нь А зөвшөөрөлтэй дамжуулалтын компани байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй байдаг. Танайх үүнийгээ хариуцах ёстой гэж шаардлага тавьдаг. Манайх бол Б зөвшөөрөлтэй учир Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх эрхгүй юм.

Харилцаа Холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага болон Харилцаа Холбооны сүлжээ байгуулах түүний ашиглалтын нөхцөл шаардлага гэсэн журмуудаар холболтыг зөвхөн А зөвшөөрөлтэй компани хийнэ гэж заасан байгаа гэв.

Дээрх асуудлын дагуу зөвлөх инженер миний бие энэ журмыг судалж үзэв. ХХЗХ-ны вэбсайт дээр Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2014 оны 2 сарын 21-ны өдрийн 6-р тогтоол, нэгдүгээр хавсралт нь ангиллыг заасан байна. Дээр хэлсэн журам хүчингүй болсон ба “Зөвшөөрлийн тухай хуулиар” зохицуулагддаг болсон байна. Шалгуур үзүүлэлтийн 3-д нарийвчлан үзүүлэв.

Харин хэрэглэгч тал руу татагдсан сүлжээг өөрсдөө хариуцан ашиглалт үйлчилгээг хариуцаж байгаа бөгөөд дахин А зөвшөөрөлтэй компаниар хийлгэнэ гэвэл зардлын хувьд өндөр болж хэрэглэгч тал дээрх төлбөр нэмэгдэх болно гэв.

Б. Сувгийн дараалал, үндсэн багцын шал болон таазын хязгаар, сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох боломж, шийдлийн талаар.

1. Хэрэглэгчид үздэггүй сувгуудаа сувгийн жагсаалтуудаас хасах боломжтой юу? Одоогийн манай техникийн шийдэл ийм боломж байхгүй.

2. Хэрэглэгчид нийт сувгийн дарааллыг өөрийн хүссэнээр өөрчилж тохиргоо хийж болох уу?

Одоогийн манай техникийн шийдэл ийм боломж байхгүй.

Манайх DVB-C DVB-T технологи дээр ажилладаг. Эдгээр нь тоон системд шилжсэн бөгөөд зурвасын өргөн тус бүр дээр сувгуудыг багцалсан байдаг тул ийм боломж байхгүй юм.

В. Үзэлтийг иргэд, эрх бүхий байгууллагуудад нээлттэй болгох боломж, шийдэл:

1. ОСДҮЭ дээр үзэлтийн судалгаа гаргах боломжтой эсэх, Толгой өрөөний програм хангамжуудад хэрэглэгчдийн үзэлтийн мэдээлэл сувгуудаар болон нэвтрүүлгүүдээр гарах боломжтой юу?

2. Энэ мэдээлэлд анализ хийдэг тусгай програм хангамжууд байдаг уу?

Одоогоор манай техникийн шийдэлд ийм боломж байхгүй.

Ер нь DVB-C, DVB-T технологиуд дээр ийм боломж бий. Нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай. Толгой өрөөнд нэмэлт серверүүд, програм хангамжууд суурилуулснаар энэ судалгааг хийдэг технологи байдаг.

Г. Техник холболтын хураамж гэж авдаг уу? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд авдаг эсэх.

ӨН-ийн болон Арилжааны ТВ-үүдийн сарын суурь хураамж адил байдаг уу?

Бид бүх төрлийн телевизүүдээс дамжуулалтын төлбөр гэж огт авдаггүй. Мөн жишээ нь хэрэглэгчдээс орлого хуваах зарчмаар төлбөр авдаг “PayTv” хэлбэрийн үйлчилгээ байдаггүй. Жишээ нь SPS шиг. Арилжааны телевизүүдээс мөн төлбөр авдаггүй. Нийтэд нь авахгүй гэсэн бодлого баримталдаг.

“СКАЙМЕДИА” ХХК

2023 08 14

Медиа, IP сүлжээний албаны захирал Түвшинбаяртай уулзав.

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийг дамжуулахад үүсэх техник холболтын гэрээний зааг ялгааг тодорхой болгох, мөн зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Бид телевизүүдтэй хоёр төрлөөр холболтын гэрээ хийж байгаа.

Нэг. Телевизүүд бидэнтэй өөр гуравдагч дамжуулалтын компаниар дамжуулж холбогдож байгаа. Жишээ нь МХС, Скайнетворк, Мобиком гэх мэт.

Хоёр. Манайтай шууд гэрээгээр ажиллавал бид ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллана гэсэн үг. Энэ үед Скайнетворк болон А зөвшөөрөлтэй Скайстрим гэдэг компаниудаар холболтоо хийдэг. Энэ үед Телевизүүдтэй хийдэг гэрээ нэг л байдаг.

Дундын холболтын цэгтэй болно гэж дээр үед ярьж байсан боловч хэн хийх нь тодорхойгүй байснаас орхигдсон байх.

Санал: Орчин үед интернэт холболтоор телевизүүдийн дохиог авах боломж бүрдэж байна. Энэ үед дундын холболтын цэг хаана байх, журманд юу гэж тусгахыг бодох хэрэгтэй байх. Хуучин шиг заавал “Dedicated” байна гэсэн заалт байх уу гэдгийг бодолцох хэрэгтэй байх.

Б. Сувгийн дараалал, үндсэн багцын шал болон таазын хязгаар, сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох боломж, шийдэл

1. Хэрэглэгчид үздэггүй сувгуудаа сувгийн жагсаалтуудаас хасах боломжтой юу?

Боломжгүй

2. Хэрэглэгчид нийт сувгийн дарааллыг өөрийн хүссэнээр өөрчилж тохиргоо хийж болох уу?

Боломжгүй

Бидний үйлчилгээ багцан дээр суурилсан учир багц болгон дээр тогтсон сувгийн дарааллууд байдаг учир өөрчлөх боломжгүй юм. Харин үзэх дуртай сувгаа “Favorite” гэсэн тэмдэг дарж болно. Энэ үед меню дээр дуртай сувгууд нь дээгүүр байрших боломжтой болдог.

3. Олон улсын туршлага?

Орчин үед үйлчилгээний хэлбэр илүү динамик шийдэл рүү орж байна. Гадныханд энэ технологи дөнгөж одоо л гарч эхлэх гэж байна. Үүнийг “Personal channel”, “Fast channel” гэх маягаар нэрлэж байна.

В. Үзэлтийг иргэд, эрх бүхий байгууллагуудад нээлттэй болгох боломж, шийдэл:

1. ОСДҮЭ дээр үзэлтийн судалгаа гаргах боломжтой эсэх, Толгой өрөөний програм хангамжуудад хэрэглэгчдийн үзэлтийн мэдээлэл сувгуудаар болон нэвтрүүлгүүдээр гарах боломжтой юу?

2. Энэ мэдээлэлд анализ хийдэг тусгай програм хангамжууд байдаг уу?

Нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай. Манай одоогийн “Middleware” дээр аналитик түүлүүд нэмж авч суулгана гэсэн үг. 1 STB дээрх мэдээлэл дээр анализ хийж болно гэсэн үг. Тодорхой тооны хэрэглэгчүүд дээр лиценз авч

1. сувгийн үзэлт

2. нэвтрүүлгийн үзэлтүүд дээр үзэлтийн судалгаа хийж болно

Тодорхой тооны STB-ууд дээр нийтлэг судалгаа хийж болно.

Энэ үед телевизүүд хөтөлбөрийн цагаа баримтлах хэрэгтэй болно.

Г. Техник холболтын хураамж гэж авдаг уу? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд авдаг эсэх.

ӨН-ийн Болон Арилжааны ТВ-үүдийн сарын суурь хураамж адил байдаг уу?

Телевизүүд анх холбогдоход шаардлагатай тоног төхөөрөмжүүд авдаг. Зааглах цэгээс шалтгаалан зардлууд өөр өөр гарна.

Сарын суурь хураамжийн хувьд ОНРТВ болон ӨН-ийн телевизүүдээс хураамж авдаггүй. Энд гарсан дамжуулалтын зардлыг сүлжээ хариуцсан компанид бид өөрсдөө төлдөг. Харин арилжааны телевизүүдээс 300-500 мянган төгрөгний сарын суурь хураамж авдаг.

Санал: Дундын холболтын цэг хийвэл зүгээр санагддаг. ОСДҮЭ болон телевизүүдэд зардал бага гарна. Мөн техникийн тасалдал гарахгүй сайн талтай. Мөн телевизүүдийн дохиог дураар тасалдаг байдал байхгүй болно.

MNBC КАБЕЛИЙН ТЕЛЕВИЗ

2023 08 17

Мэдээлэл Техник Технологийн Газрын захирал Д.Оюунгэрэл, Ахлах инженер

Г.Дорж нартай уулзав.

Улаанбаатар хот, Налайх дүүрэгт DVB-T2 технологиор агаарын кабелийн Телевизийн үйлчилгээ явуулдаг.

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийг дамжуулахад үүсэх техник холболтын гэрээний зааг ялгааг тодорхой болгох, мөн зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Одоогийн Телевиз манай хоорондын Зааглах цэгийн хувьд асуудал байхгүй байна.

Манай хувьд аль нэг Телевиз манайтай холбогдоход шилэн кабелиар дамжуулахдаа сүлжээний бизнес эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй компаниар хийлгүүлдэг ба зардлыг нь Телевиз хариуцна. Ашиглалтыг тэр компани хариуцна. Энэ тохиолдолд зааглах цэг манай оролт дээр байна гэсэн үг.

Мөн бид өөрийн бизнесийн хүрээнд шилэн кабель өөрсдөө татсан тохиолдлууд бий. Бид сүлжээ компаний сувагчлалыг ашиглаж тэдэнд түрээсээ төлөн ашиглалтаа бид хариуцан ажиллана. Жишээ нь Масс ТВ, SBN, TV5, TV9 гэх мэт.

Б. Сувгийн дараалал, үндсэн багцын шал болон таазын хязгаар, сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох боломж, шийдэл

1. Хэрэглэгчид үздэггүй сувгуудаа сувгийн жагсаалтуудаас хасах боломжтой юу?
2. Хэрэглэгчид нийт сувгийн дарааллыг өөрийн хүссэнээр өөрчилж тохиргоо хийж болох уу?

Манай хэрэглэгчийн STB ийм боломжтой суваг хасах, дарааллын өөрчлөх боломжтой.

Гэхдээ ихэнх хэрэглэгчид энэ үйлдлийг хийдэггүй.

В. Үзэлтийг иргэд, эрх бүхий байгууллагуудад нээлттэй болгох боломж, шийдэл:

1. ОСДҮЭ дээр үзэлтийн судалгаа гаргах боломжтой эсэх, Толгой өрөөний програм хангамжуудад хэрэглэгчдийн үзэлтийн мэдээлэл сувгуудаар болон нэвтрүүлгүүдээр гарах боломжтой юу?

2. Энэ мэдээлэлд анализ хийдэг тусгай програм хангамжууд байдаг уу?

Манай DVB-T2 үйлчилгээнд бол тийм боломж байхгүй. Харин манай интернэт, Телевиз хосолсон үйлчилгээ болох ОТТ технологийн “Homemedia” үйлчилгээнд ийм боломж байдаг.

Г. Техник холболтын хураамж гэж авдаг уу? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд авдаг эсэх.

ӨН-ийн Болон Арилжааны ТВ-үүдийн сарын суурь хураамж адил байдаг уу? Бид ӨН-ийн Телевизүүдээс холболтын төлбөр авдаггүй. Сүлжээнд гарсан зардлуудыг манах төлдөг гэсэн үг. Харин Арилжааны Телевизүүдээс тохиролцон төлбөр авдаг. Нэг жигд үнэ авах бодлого баримталдаг. Харин тэд өөрсдөө шилэн кабелиа даадаг бол арай өөр төлбөртэй байдаг.

“БЛУМБЕРГ ТВ МОНГОЛИА” ТЕЛЕВИЗ

Блумберг Телевизийн ерөнхий инженер Мөнхцэцэг,
Хуульч Э.Цэцэглэн нартай уулзав

2023 08 15

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийнхаа гаралтыг ОСДҮЭ нараар дамжуулахад үүсэх асуудлууд байдаг уу? Техник холболтын гэрээ, зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Б. Техник холболтын хураамж гэж авдаг уу? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд авдаг эсэх.

Манайх арилжааны телевизүүд дундаа хамгийн удаан жил ажилласандаа ордог. Холболтын гэрээ, зааглах цэгийг тодорхой болгох талаар ХХЗХ дээр олон удаагийн уулзалтууд хийж байгаа. Ийм боловч үр дүнд хүрэхгүй байна.

Оператор компаниуд Телевизээс оператор компани хүртэлх зардлаа өөрсдөө даа гэдэг.

Одоогоор ихэнх гэрээнүүдийн хугацаа дууссан байгаа. Иймд нөхөж гэрээ байгуулах гэж байгаа.

Шударга өрсөлдөөний газрын дүгнэлт гарсан байгаа. ӨН-ийн хууль нь өрсөлдөөнийг хязгаарласан хууль гэж тэднийхээс дүгнэлт гарсан. Иймд ХХЗХ-оос ТВ ОСДҮЭ нарт гэрээг үргэлжлүүлэн хийхийг түдгэлзүүлсэн байгаа. Иймд бүх арилжааны Телевизүүд гэрээ байгуулахгүй байгаа.

Бидний хувьд дараахь операторуудаар гарахгүй байгаа.

Сансар, Сансар дижитал, MNBC, Монсат,

Дараахь операторуудаар гарч байгаа

Юнивижн (Гэрээний хугацаа дууссан боловч олон жилийн хамтын ажиллагаатай байсан учир манайхыг таслахгүй явуулж байгаа), Скаймедиа, Ддиш, National (Гэрээний дагуу явж байгаа)

Монсат эхлээд төлбөр нэхэж байсан. Дараа нь танайхыг төлбөргүйгээр MOTV үйлчилгээндээ авъя гэж гуйсан байгаа.

Сансар операторын хувьд манайх танайтай STBS гэдэг дамжуулалтын компаниар дайруулж холбогдоно гэсэн. Энэ тохиолдолд сарын 200 мянга орчим төгрөгийн төлбөр гарна гэсэн. Мөн энэ үед бид танайхыг Сансар дижитал, Монсат зэрэг ОСДҮЭ нартай холбож өгч болно гэсэн. Энэ холболтын цэг нь төв шуудангийн 32-р салбарын худагт байрладаг нь манай Телевизийн байртай ойр байдаг юм.

Оператор болгон нэг зааглах цэг гаргаад түүндээ мөнгөө авъя гэдэг.

ХХЗХ-оос журамдаа зааглах цэг гаргачихаад тэр нь тодорхойгүй байдаг. Тодорхойлохдоо илүү операторуудад илүү боломж гаргаж өгдөг. Яагаад гэвэл зааглах цэгээ операторууд өөрсдөө тодорхойлдог учир тэд өөрсөддөө ашигтай нөхцөл гаргадаг.

Мөн Юнивижн Ддиш хоёр нэг зааглах цэгтэй мөртөө төлбөрийг давхардуулан авах гэдэг.

Зааглах цэг заавал хэрэгтэй байгаа бол нэг дундын болгох хэрэгтэй.

ӨН-ийн Телевизүүдээс төлбөр авахгүй байгаа нь арилжааны Телевизүүдээс илүү авах боломж бүрдэнэ гэсэн үг.

Сувгийн дараалал их чухал байна. Манайх Юнивижн дээр 7 дугаарт байсан бол 24 дээр аваачсан. Энэ нь бидний зар сурталчилгаанд нөлөөлж хохирол үзүүлсэн.

-Бид операторуудад мөнгө төлмөөргүй байна. ӨН-ийн Телевизүүд өгдөггүй бид өгдөг нь шударга бус байна.

- Операторууд биднээс төлбөр авна, давхар хэрэглэгчээс мөнгө авч байгаа нь шударга бус гэж үзэж байна.

- ӨН-ийнхэнтэй адил хэрэглэгчээс мөнгө авмаар байна.

- Сувгийн дарааллыг үзэгчийн судалгаагаар тогтоодог баймаар байна.

-Төрийн оролцоог хамгийн бага хэмжээнд байлгаж Телевиз Операторууд хоорондоо уян хатан гэрээ хийж баймаар байна.

- Төр хууль гаргаад нэмж журам, гэрээний нөхцлийг хүртэл зааж өгч байгаа нь илүү гэж үзэж байна.

“LIVE” ТЕЛЕВИЗ

LIVE Телевизийн гүйцэтгэх захирал Отгонжаргалтай уулзав

2023 08 15

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийнхаа гаралтыг ОСДҮЭ нараар дамжуулахад үүсэх асуудлууд байдаг уу? Техник холболтын гэрээ, зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Б. Техник холболтын хураамж гэж авдаг уу? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд авдаг эсэх.

ӨН-ийн хууль гарахаас өмнө техник холболтын гэрээгээ оператор компаниуд бидэнд тулгадаг байсан. Үүнээс хойш журам гараад зааглах цэгийг тодорхойлж өгсөн. Жишээ нь одоо бид Юнивижнтэй Суваг дамжуулах үйлчилгээ үзүүлэх 10 зүйлтэй гэрээтэй байна.

Манай контентыг үнэгүй авдаг мөн хэрэглэгчээс төлбөр авдаг ийм дэлхийд байхгүй жишиг тогтсон байна. Манайхаас Юнивижн сарын 1 сая 600 мянга, жилийн 20 сая төгрөг авдаг. Харин ӨН-ийн 18 Телевиз орлогынх нь 15 хувийг авдаг.

ӨН-ийн тухай хуульд телевиз нь ОСДҮЭ-дийн сүлжээнд холбогдох, хөтөлбөр дамжуулахад дараах зарчмыг баримтална гэсэн байгаа.

/20.5.Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох, хөтөлбөр дамжуулахад дараах зарчмыг баримталж, хоорондоо байгуулсан гэрээгээр зохицуулна:

20.5.1.техник холболтын зааглах цэг, нөхцөлийг тогтооход Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4-т заасан журмыг баримтлах;

20.5.3.өргөн нэвтрүүлгийн радио, телевизүүд нь энэ хуулийн 6.1.2-т заасан үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах;

20.5.4.бусад арилжааны радио, телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан тохиролцох./

Үүнээс харахад ӨН-ийн Телевизүүдээс төлбөр авахгүй харин Арилжааны Телевизүүдтэй харилцан тохиролцоно гээд орхисон байгаа нь өнгөрсөн 2-3 жилүүдийн маргаан үүсэх нөхцөл болж ирсэн.

Бид бас 15 хувиасаа авна гэж хүсэлтээ тавьсан. Операторуудтай хийх гэрээгээ контент түгээлтийн гэрээ гэж хийх ёстой гэсэн шаардлагыг тавьж байгаа. Операторууд бол тусад нь хийе гэдэг. ХХЗХ бол зааглах цэгээр заавал дамж гэдэг. Гэтэл бид Сансар, Юнивижнтэй (Ддиш) шууд холбогдсон байгаа.

Операторууд бидэнд зааглах цэг хүртэлх болон өөрсөд дээрээ ирэх дамжуулалтын үнээ хэт өндрөөр тооцдог. Маш их зардлыг бидэнд тохдог. Жишээ нь Монсат HD дохиогоор дамжуулахад 750 мянга, SD дохиогоор дамжуулахад 350 мянган төгрөг нэхсэн.

Зарим хувийн компаниуд энэ үйлчилгээг чинь авъя гээд зардлын тооцоо гаргахад (Медиапро, Сансар кабель) 150 мянга орчим төгрөгийн зардал гаргасан. Харин Юнивижн бүгдийг нь хариуцъя гэсэн боловч 350 мянга орчим үнэ өгсөн нь ашиг их нэмсэн үнэ болж таарч байна.

Юнивижний гэрээ сая 5 сард дууссан. Гэхдээ ХХЗХ Техник холболтын гэрээ тодорхой болсны дараа гэрээ хийж болно. Одоогоор түдгэлзүүл гэсний дагуу гэрээ хийхгүй байгаа. Ажлын хэсэг гарсан байгаа. Энэ ажлын хэсгийн дүгнэлтийн дараа хий гэсэн.

Монголсат 2 багцтай болсон. Эхний багцын 18 суваг үнэгүй болсон харин дараагийн багц хаалттай байгаа бөгөөд хэрэглэгчид төлбөр төлсний дараа үзүүлдэг болсон. Монсат ихэнх арилжааны Телевизүүд болон манайхыг тасалсан байгаа.

ХХЗХ юун түрүүн Техник холболтын гэрээнд анхаардаг. Суваг дамжуулах гэрээнд анхаардаггүй. Оператууд болохоор эхлээд Техник холболтын гэрээгээ хийчих гэдэг.

Зааглах цэг дээр тавьж байгаа үнэ ашиг шингэсэн үнэ байгаа гэж үзэж байна. Бид Юнивижнд жилийн 20 сая, Ддиш-д жилийн 33 сая төгрөгийн төлбөр төлдөг.

Сансар кабель бол гайгүй. Сарын 128 мянган төгрөг өгдөг.

- Хоёр гэрээгээ хамтад нь хийе.
- Зааглах цэгийн 150-180 мянган төгрөгийн ашиг шингээгүй төлбөрөө төлье.
- 20 сая төгрөгийн төлбөрөө төлөөд оронд нь контентоо өгье.
- Хэрвээ үгүй бол орлогын 15 хувиа авъя гэсэн саналтай байгаа.

“UBS” ТЕЛЕВИЗ

2023 08 16

(Глобал, Өлзий Телевиз)

Техник хариуцсан дэд захирал Нямдаваатай уулзав.

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийг дамжуулахад үүсэх техник холболтын гэрээний зааг ялгааг тодорхой болгох, мөн зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Б. Техник холболтын хураамж гэж төлдөг үү? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд өгдөг эсэх.

ӨН-ийн, Арилжааны ТВ-үүдийн, орон нутгийн телевизүүдийн сарын суурь хураамжийн зөрүүний тухай тодруулах

Анх оператор компаниуд өрсдөө бидэн дээр ирж холболтын бүх асуудлыг хариуцаж гарсан зардлуудыг өөрсдөө даадаг байсан. Хууль гарч ӨН-ийн Телевизүүд нь үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авдаг болсноос хойш Телевизүүдээс төлбөр янз бүрээр нэхэж авдаг болсон. Мөн энэ төлбөр нь Телевизээс оператор хүртэлх зардлыг хамардаг болсон.

Манай UBS, Глобал, Өлзий Телевизүүд бүгд дараахь операторуудад төлбөр өгч холболтоо хийж байгаа. Юнивижн, Ддиш, Скаймедиа, MNBC, Сансар, National, Монсат. ӨН-ийн UBS Телевиз манай арилжааны Өлзий, Глобал телевизүүд операторуудтай ойролцоо төлбөр төлж байгаа.

Энэ гэрээн дээр мөн сувгийн дарааллыг хөдөлгөхгүй гэсэн заалтыг бас оруулдаг.

Манай Телевизүүдийн холбооны тэргүүн Баярбат ОСДҮЭ-тэй яриад үнийг буулгах тохиролцоо хийж байгаа.

UBS телевиз РТҮСГ-ийн 16 телевизүүдийн цацалтад хамрагдахгүй байгаа. Анх төлбөрийн үнэ ихтэй байсан тул тэндээс гарсан одоог хүрч байна. РТҮСГ одоо ӨН-ийн

Телевизүүдийн тоо нэмэгдсэн учир ӨН-ийн агаарын цацалтын сувгийн тоогоо нэмэх ёстой. Манай Телевизүүдийн холбоо 2016 оны үед нэгдсэн нэг дундын холболтын цэг байгуулах санал гаргаж эдийн засгийн тооцоог хийж байсан. Энэ цэг нөөц буюу “backup” шийдэлтэй байхаар ярьж байсан. Хэрвээ ийм зангилаа цэг байгуулбал аль аль талдаа зардал хэмнэгдэх, холболтын зардал багасах ач холбогдолтой. Мөн томоохон дэлхий дахины болон улсын хэмжээний арга хэмжээнүүд жишээ нь наадам, олимп зэргийг хоорондоо хуваарилж ашиглах давуу талтай юм.

Яваандаа шилэн кабелийн түрээсийн үнэ өндөр энэ хэвээр байх юм бол дундын холболтын зангилаа цэгтэй болговол зүгээр гэсэн саналтай байна. ХХЗХ-ны журамд заасан зааглах цэг, дундын холболтын цэг дээр асуудалгүй бид операторуудтай харилцан тохиролцоод гэрээгээ хийгээд явдаг.

“SBN” ТЕЛЕВИЗ

2023 08 16

Гүйцэтгэх захирал Ц.Энхтуултай уулзаж ярилцав.

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийг дамжуулахад үүсэх техник холболтын гэрээний зааг ялгааг тодорхой болгох, мөн зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Б. Техник холболтын хураамж гэж төлдөг үү? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд өгдөг эсэх.

ӨН-ийн, Арилжааны ТВ-үүдийн, орон нутгийн телевизүүдийн сарын суурь хураамжийн зөрүүний тухай тодруулах

Юнивижн Ддиш гэсэн хоёр оператор компанид сар бүр 900 мянга орчим төлбөр тус бүр төлж байгаа. Үүнийгээ засвар үйлчилгээний зардал гэж хэлээд гэрээ байгуулж байгаа. Төлбөрийн задаргаагаа өгнө үү гэхэд тийм шаардлагагүй гэдэг.

Бусад операторууд болох Сансар, Монсат, National, MNBC нарт төлбөр өгөхгүй гаргаж байгаа. Эдгээр компаниуд зардлуудаа өөрсдөө дааж байгаа байх.

ХХЗХ хоорондоо зохиц гэсэн байдалтай байна.

Бид өөрсдөө Телевизүүдийн холбоон дээрээ өөрсдийн зааглах цэгтэй болох гэж ярьсан боловч бүтэхгүй байгаа.

Яг одоогийн техник холболт, зааглах цэгүүдийн хувьд ямар нэг асуудал байхгүй байна.

“МОНГОЛ” ТЕЛЕВИЗ

Гүйцэтгэх захирал Бат-Эрдэнэтэй уулзаж ярилцав.

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийг дамжуулахад үүсэх техник холболтын гэрээний зааг ялгааг тодорхой болгох, мөн зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Б. Техник холболтын хураамж гэж төлдөг үү? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд өгдөг эсэх.

ӨН-ийн, Арилжааны ТВ-үүдийн, орон нутгийн телевизүүдийн сарын суурь хураамжийн зөрүүний тухай тодруулах

Бат-Эрдэнэ:

Өөрийн ТВ-ээр жишээ авъя. Анх Э/З-ийн хувьд болж өгөөгүй. Мөн үзэгчид сошл медиа руу их орсон. Э/З-ийн хувьд муу болохоор чанаргүй бүтээл гарна. Үүнээс болж салбарын чадвар, хүний нөөц муудна. Ийм үед шантаажны сэтгүүл зүй бий болох нөхцөл бүрдэнэ. Соёлын дархлаа, соён гэгээрүүлэх ажил орхигдож энэ нь үндэсний дархлаа сулрахад хүргэнэ. Төр заавал зохицуулахгүй бол болохгүй.

ЗХ-ны Балгансүрэн дарга байхдаа судалгаа хийлгэсэн. Гадны жишгээр дэлхий нийтэд орлогын 70 хувийг зар сурталчилгаанаас, 30 хувийг эцсийн хэрглэгчээс авдаг гэсэн судалгааны дүн гарж байсан. Үүнийгээ Монголын ТВ-үүдийн Форум дээр танилцуулсан. Энэ үед ОСДҮЭ-тэй учраа ол эсвэл хуулиар зохицуулна гэсэн. ОСДҮЭ-ид гадны сувагт яагаад төлбөр төлдөг (НВО-д 1.5 сая доллар төлдөг) вэ. Үндэсний контентдоо өгөх ёстой юм. Хуулин дээрээ зөвшилцсөн 2500 төгрөг шууд авч өгье гэсэн.

Үүнээс хойш энэ орлогыг 2 жил тэгш хуваарилж ирсэн. Тэр үед жижиг ТВ-үүд гарааны тэгш боломж олгооч гэж байсан. Хамгийн гол нь рейтингээр хуваарилах ёстой. Рейтингийг хэн тогтоох вэ. ОСДҮЭ, ТВ Холбоо, ЗХ, Шударга өрсөлдөөний газар эдгээр байгууллагууд ороод хийвэл яах вэ гэж ярилцаж байсан. ТВ Холбоон дээрээ бол манайх хийе гэсэн. Ихэнх жижиг ТВ-үүд шийдэж өгөөгүй. Энэ ажил ингээд зогссон. 3-аас доошгүй газрын рейтингийн үнэлгээгээр хийе гэсэн. Скаймедиа, VOO хоёр мэдээллээ өгье гэсэн. Харин Юнивижн өгөхөө мэдэхгүй байна гэсэн. Жишээ нь тухайн сардаа 1-18 баллын үнэлгээгээр оноо өгч орлогоо дүйцүүлэн хуваарилах боломжтой.

Үүний дараа л зөв замдаа орно гэж бодож байгаа. Энэ 3 компаний хэнд нь итгэж болох вэ гэсэн асуудал гарсан. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн *Ernst & Young* гэдэг компаниар ретингийн дүнг хийлгүүлье гэсэн. Тэд ч хийж өгч болно гэсэн.

Рейтингээр орлогоо хуваарилж явах нь хамгийн зөв шийдэл. Энэ ажил хийгдвэл арилжааныханд мөн ӨН-ийн эрхийг нь өгөх хэрэгтэй. Мөн зэргэцүүлээд тэдэнд тавих нөхцөл шаардлагаа тавь. ӨН-ийн ТВ-үүд бол ачаалал ихтэй байдаг.

Бид арилжааны ТВ-үүдтэй. Эдгээр нь ОСДҮЭ-дэд төлбөр төлдөг. Үндсэн суваг бол төлдөггүй. Хуулинд ӨН-ийнхэн төлбөр төлөхгүй гэсэн заалт бий. ТВ өөрсдийн 18 сувгийн нэгдсэн цэг нээе, өөрсдийн нэг ёсны ОСДҮЭ үйлчилгээ хийе гэсэн. Ингээд ЗХ орж ирсэн.

Зааглах цэгийн хувьд бид бол контент үйлдвэрлэгчид, хүргэлтийг ОСДҮЭ хийх ёстой. Бүх гэрээнүүд дээр манай ТВ дээр зааглах цэгүүд байгаа гэж заагдсан.

Манай салбарт дотоодын контент үйлдвэрлэгч нараа дэмжих хэрэгтэй байна. Үзэгчдийн төлсөн мөнгө гадаад руу урсаж байна. Монгол контент сайжирч байх ёстой юм. Дотооддоо эргэлдэх мөнгө нь өсөж энэ нь энд ажиллаж байгаа хүмүүст сайн цалин болж очих ёстой юм.

ГАЛ ХӨГЖИЛ ХОЛБОО

Орон нутгийн ТВ-үүдийн Гал хөжил холбооны тэргүүн Ч. Баярсайхантай уулзав.

2023 09 20

А. ТВ болон ОСДҮЭ хоорондын гэрээ, техник холболтын асуудал.

Телевизийн сувгийнхаа гаралтыг ОСДҮЭ нараар дамжуулахад үүсэх асуудлууд байдаг уу?

Техник холболтын гэрээ, зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Б. Техник холболтын хураамж гэж авдаг уу? Суурь хураамж болон сар жилийн төлбөрүүд авдаг эсэх.

ӨН-ийн ТВ-үүд жишээ нь Юнивижн, Ддиш операторуудтай гэрээ хийхгүй удаж байна. Учир нь зааглах цэгийн асуудал байгаа юм. Орон нутгийн КАТВ-үүд, РТСГ, Юнивижн, Ддиш, Дархан, Эрдэнэт хотод бол Скаймедиа эдгээр бүх операторуудад тус тусдаа холбогдох зардал ихээр гардаг. Орон нутагт төвлөрсөн нэг зааглах цэгтэй болгож өгөөч гэсэн саналуудыг бид тавьж байгаа. Одоо Монголсат компани орж ирэх гэж байна. Биднийг РТСГ сигналаа өгчих гэж байгаа.

ӨН-ийн нийт 40 орчим ТВ байна. Үүнээс 4-хөн нь арилжааны, бусад нь ӨН-ийн эрхтэй ТВ-үүд байна.

Юнивижн, Ддиш гэхэд нэг компани мөртлөө тус тусдаа 1 сая төгрөг авна гэдэг. Голдуу Юнивижн, Ддиш операторууд дээр өндөр төлбөрийн гол асуудлууд байдаг. Мөн ОН-ийн ТВ-ээс тухайн аймаг сумын зааглах цэг хүртэл бид холболтын зардлаа хариуцаж төлдөг байтал үүнээс цааших зардлуудыг бас бидэнд үүрүүлэх гэдэг.

ОСДҮЭ болгон энэ төлбөрийг авах гэдэг. Үзэгчдээс мөнгө МТХ мөнгө авдаг болсны дараа ОСДҮЭ-ид гэрээнд заасан төлбөрийг огцом нэмсэн. Жишээ нь 400 мянга байсан төлбөр нэг сая болтлоо нэмэгдсэн. Гадны контент сувгуудийг бол мөнгө төлж худалдаж аваад дамжуулдаг. Биднийг болохоор өндөр төлбөр төлүүлж холбодог жишиг байна.

Тэд өөрсдийн үндсэн багцын төлбөрөөс авахгүй тусад нь хэрэглэгчээс 2500 төгрөг авч ӨН-ийн ТВ-үүдэд өгдөг.

Орон нутагт нэг том асуудлыг шийдэх хэрэгтэй байна. Орон нутагт зааглах цэг нэг газарт төвлөрсөн баймаар байна. Эдгээр бүх операторуудад сигналаа өгөх гэж ОН-ийн ТВ-үүд маш их зардал гаргадаг.

ОН-ийн ТВ-үүдийн тоног төхөөрөмж, дэд бүтэц, хүн хүчний хувьд маш сул байдаг. Жишээ нь Эфирээ VMix суулгасан компьютерээр явуулдаг. Гаралтыг нь шууд операторууд руу өгдөг. Олон операторууд руу сигналаа өгч байгаа тул технологийн хувьд хүндрэл их гардаг. Жишээ нь нэг оператор дуугаа нэм гэхэд нэмчихэд бусад операторуудын дуу нь ихэсч гажууддаг.

Юнивижн дээр шинээр солигдож байгаа хэрэглэгчийн төхөөрөмж дээр ОН-ийн ТВ-үүд гарахаа больчихдог. Тэгээд хэрэглэгчид дуудлага өгч байж оруулдаг, мөн нөхөж үзэх үйлчилгээгээ сэргээдэг төвөгтэй байдал ОН-ийн үзэгчдэд хүндрэлүүд үзүүлж байна. Хуулинд ӨН-ийн ТВ-үүд үндсэн багцын эхэнд байна гэж оруулсан нь мөн ОН-ийн ӨН-ийн ТВ-үүд орох ёстой юм. Гэтэл одоо хамгийн сүүлд 900 орчим руу тавигдсан байгаа.

Хямдыг нь бодоод SD форматыг сонгодог. Ингээд гаралт мэдээж муу болохоор бусад HD-ээр гарч байгаа ТВ-үүдэд цохигддог.

Мөн операторууд өөрсдийн төхөөрөмжүүдээ бидэнд шахдаг.

Одоогийн байдлаар РТСГ-ийн сувгуудад 2 ОН-ийн ТВ-д эрх олгох тендер зарласан. Одоо хэрэгжих гэж байгаа.

Алслагдсан орон нутагт ӨН-ийн үйлчилгээг хүргэхийн тулд ӨН-ийг дэмжих сангаас зарцуулдаг байх нь зүйтэй юм.

“ХХЗХ”-ТОЙ ХИЙСЭН УУЛЗАЛТУУД

2023 09 01

ӨНЗГ-ын хэрэгжилтийн хэлтсийн дарга Тогтохсүрэн, Зохицуулалт хариуцсан ажилтан Алтай, “Заяа энд Золоо” компаний судлаач А.Доржсүрэн, ЦХХХЯ-ны мэргэжилтэн Нармандах нар байлцав.

Доржсүрэн: Үзэлтийн судалгааны талаар санал асуув.

Тогтохсүрэн: IPTV үйлчилгээ эрхлэгчид бол манай шаардлагын дагуу нарийн судалгаанууд гаргаж өгч чадахгүй байдаг.

Болорхүү:

Судалгааны чиглэл хоёр янз байна. 1. ЗХ-ны мониторингийн судалгаанд зориулсан
2. Үзэлтийн судалгаа Энэ нь ТВ-үүдэд мөн ивээн тэтгэлэг өгдөг компаниудад зориулсан судалгаа юм.

Тогтохсүрэн: та бүхнийг Махима медиа компанитай уулзахыг зөвлөж байна гэв. Тэдний зардал өндөр байдаг тул төрийн оролцоо дэмжлэг хэрэгтэй байх гэж бодож байна.

Алтай : Махима зөвхөн Улаанбаатар хотод судалгаа явуулдаг мөн 100-хан хэрэглэгчдээс судалгаа авдаг гээд ТВ-үүд судалгааг мөнгө төлж авдаггүй байсан гэсэн. Үзэлт гэдэг сонин ойлголт юм. Авъясалаг монголчууд нэвтрүүлгийг зөвхөн гарч байхад нь үзээд бусад үед нь Монгол ТВ-г үзэхгүй байдаг гэж ярьдаг.

Тогтохсүрэн: Аймшгийн кино гаргаад үзэлт их гарсан бол төрөөс дэмжлэг үзүүлэх нь зохисгүй юм. Тиймээс үзэлтийн үзүүлэлтүүдийг харах нь чухал юм. Гадаадад “Sales House” гэсэн ойлголт байдаг. Үүнийгээ мөн тайлбарлав.

Доржсүрэн: хэрэглэгчээс 2500 төгрөг авах нь хэрэгжүүлэхэд хэр төвөгтэй байдаг вэ.

Тогтохсүрэн: Байнга маргаан болж гардаг асуудал. Энэ төлбөр мэдээж хэрэглэгчийн нуруун дээр ирнэ.

Алтай: Хуулийн заалт дахь 15 хувиас дээш төлбөр авна гээд заасан учир одоо авж байгаагаас нэмж авах боломж бүрдсэн байгаа гэсэн үг.

Доржсүрэн: Тв-үүдийн холбоо аудит хийж өгдөг үү тайлагнадаг уу.

Алтай: Нэг удаа ирж байсан. Аудитын талаар тодруулга хийх шаардлагатай байгаа.

Телевизийн сувгийг дамжуулахад үүсэх техник холболтын гэрээний зааг ялгааг тодорхой болгох, мөн зааглах цэгийн зохистой байрлалын талаар саналууд байдаг уу?

Сувгийн дараалал, үндсэн багцын шал болон таазын хязгаар, сувгийн дарааллыг иргэд өөрсдөө тогтоох боломж, шийдэл

Тогтохсүрэн: Мэдээ мэдээл өгдөг сувгууд эхэндээ байдаг. Монсатаар багцлаад РТСГ-г өгдөг. Үүнд 16 суваг байгаа.

2023 09 07

Зах Зээл үнэ тарифын зохицуулалтын газрын дарга Ариунболд, ахлах мэргэжилтэн Золбоо, ОСДҮЭ хариуцсан мэргэжилтэн Анужин нар байлцав.

11 ОСДҮЭ-ийн гэрээг бүртгэнэ. Үүнээс хоёрыг нь бүртгээгүй байгаа. Энэ гэрээнүүд дотор төлбөр нь бас харагдана. Эдгээр гэрээнүүдийг ерөнхий байдлаар үзэж болно. Ер нь дамжуулалтын гэрээг тусдаа хийвэл зүгээр гэж бодож байна. Гэхдээ энэ шийдэгдээгүй албан байдлаар эцэслээгүй байгаа.

РТҮСГ-ын үйлчилгээ төлбөргүй байгаа нь хэрэглэгчдэд төлбөргүй үзүүлдэг гэдэг утгаараа байгаа. Энд орох ТВ-үүдийг Яам журам гаргаж сонгон шалгаруулж 16 ТВ-ийг оруулна. ӨН-ийн ТВ-үүдийг заавал РТҮСГ-ийн дамжуулалтад үнэ төлбөргүй оруулна гэсэн заалтыг авсан байгаа.

Золбоо: Америк улсын жишиг байдаг. Хууль журмуудаа сайн задлаад хийдэг. Шат дараалсан ажлууд хийгдсэний дараа зарим заалтуудаа аваад явчихдаг туршлага байна.

Болорхүү: Зарим арилжааны ТВ-үүд “ХХЗХ Техник холболтын гэрээ тодорхой болсны дараа гэрээ хийж болно. Одоогоор түдгэлзүүл гэсний дагуу гэрээ хийхгүй байгаа. Ажлын хэсэг гарсан байгаа. Энэ ажлын хэсгийн дүгнэлтийн дараа хий гэсэн.” гэж байгаа. Ийм байгаа юу.

Ажлын хэсэг гарсан байгаа. ОСДҮЭ нартай ихэнх ТВ-үүд гэрээгээ хийгээд явж байгаа. Ийм зүйл байхгүй байгаа. Энэ ажлын хэсгийн ажлын хугацааг сунгасан байгаа.Өртөг тооцдог суурь дээр ажиллах хэрэгтэй болж байгаа.

2023 09 15

Зах Зээл үнэ тарифын зохицуулалтын газрын Харилцан холболт хариуцсан мэргэжилтэн Цэцэндаваатай уулзав. Утас: 99168952

Бид “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах” журмын 2.9 дэх заалтын дагуу /Харилцаа холбооны

үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, орлого хуваарилах зарчим, төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй./ шаардлагуудыг олон удаа тавьж ажилласанаар холболтын хураамжийг нэлээн бууруулж байгаа. Энэ гэрээнүүдээс Цахилгаан холбооны гэрээ их зүгээр байсан. Дундын холболт дээр зайлшгүй зардал гарна. Хол ойроос шалтгаалсан нэг үнэтэй байх нь шударга бус юм. Бид 4 асуудлаар ОСДҮЭ ТВ нартай санал солилцсон.

“Олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээнд холбогдох зааглах цэгийг 4 байршилд, ОСДҮЭ-ийнбуюу сүлжээ эрхлэгчийн талд тогтоох.

ОСДҮ-ний зааглах цэгээс 2 тийш тус тусын зардлыг хариуцах.

Зааглах цэг дэх болон зааглах цэгээс хэрэглэгч хүртэлх өртөг, зардлыг ОСДҮЭ хариуцах.

Техник холболтын гэрээнд шилэн кабелийн түрээсийн зардлыг оруулахгүйгээр, гэрээлэгч талууд тохиролцож тусдаа гэрээгээр зохицуулах.”

Сансар кабелийн хувьд бид ТВ-үүдээс төлбөр авахгүй гэдэг. Тэдэнтэй STBS гэдэг холболтын компаниар дамжуулж холболтоо хийдэг. Бид энэ компанийг хянах боломжгүй. “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах” журмын 7.1 дэх заалтыг баримталдаг.

РТҮСГ гэрээний ерөнхий нөхцлийг авч байгаа. Хуулийн 22.3-ыг баримтлан үнэ төлбөргүй дамжуулж байгаа. Юнивижн ӨН болон арилжааныхантай адил хэмжээний төлбөр авч байгаа. Орон нутгийн ТВ-үүдтэй арай өөр гэрээ байгуулж байгаа. Холболт хийх газрын ойр холоос шалтгаалдаг байх. Ддэш мөн адил зарчим баримталж байна.

Скаймедиа дамжуулалт нь вэбсайт дээрээс харахад А ба Б гэсэн хоёр төрөл байна.

Монсат компани олон хувилбартай гэрээтэй. SD, HD, IP, SDI гэх мэт формат болон холболтын төрлүүдээс хамаарсан тус бүр өөр төлбөртэй.

Цахилгаан холбоо компанийх бол зүгээр гэрээ санагдсан. Хол ойроос шалтгаалсан үнийн тарифтай. Арилжааных дээр төлбөртэй, ӨН-ийнх дээр төлбөргүй явж байгаа

Захирал Энхжаргал, гүйцэтгэх захирал Хишигсүрэн, “Заяа энд Золоо” компаний судлаач А.Доржсүрэн, судлаач А.Удвал нар байлцав.

Хараат бус хөндлөнгийн судалгаа байх ёстой. Дэлхий даяар америкийн Nielsen Media Research (NMR), английн Kantar media, германы GfK гэсэн хэдхэн компани албан ёсны зөвшөөрөлтэй үзэгчийн судалгааг хийдэг компаниуд байдаг. Эдгээр компаний судалгаа авах арга зүй нэг технологи дээр байдаг. Эдгээр компаниуд нэг холбоон дор нэгдэж ажилладаг. Эдний хэрэглэдэг үзэлтийн хэмжилтийн нэгж нь нэг адил бүтэцтэй байдаг. ӨН-ийн хууль хэрэгжиж эхлэнгүүт бид судалгаагаа хийхээ больсон.

Энэ судалгааг хийх компанийг сонгон шалгаруулалт хийвэл бид оролцье гэж бодож байгаа. Бид дээрх компаний албан ёсны төлөөлөгч учир бид монгол талаас оролцоно. Харин гадны компаниуд энд оролцох боломжтой.

Технолгийн хувьд бид тэдний пиплметрийг тавьдаг. 100 хангалттай гэдгийг олон улсын компаниуд тодорхойлсон. Улаанбаатар 1,3 сая хүнтэй. Үүнд таарна гэж тодорхойлсон. ӨН-ийн ТВ-үүд бүрхэг байдал үүсгэж байна. Реклам өгдөг том компаниуд бидэнд арай илүү дэмжлэг үзүүлсэн. Жишээ нь том компаниуд рекламны мөнгөө хуваарилахад муу үзэлттэй гарсан ТВ-үүд дургүйлхдэг.

IPTV-д гардаг судалгааны түүхий датанууд мэргэжлийн судалгааны компаний урсгал стандартад орж үр дүн нь гардаг. Иймээс IPTV-нүүд хэрэглэгчийн судалгааг гаргаж чадахгүй. Тэд зөвхөн өөрсдийн дотоод менежментэд зориулж энэ судалгаагаа ашиглах ёстой.

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
"сүлжээ хооронд харилцан холболт хийх,
сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл,
орлого хуваарилах журам" батлах тухай 3 дугаар тогтоол*

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам"-ыг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.2.Энэхүү журмаар харилцаа холбооны сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох, гэрээний нөхцөл тогтоох, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр, сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хооронд харилцан холболтын орлого хуваарилах, зааглах цэг тогтоохтой холбоотой дараах төрлийн харилцааг зохицуулна. Үүнд:

1.2.5. Олон суваг дамжуулах үйлчлэгчийн сүлжээнд холбогдох;

1.2.6. Радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгчийн сүлжээнд холбогдох.

ХОЁР. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

2.3.Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлийг (RIO[1]) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж, өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд сүлжээнд харилцан холболт хийх гэрээний нөхцөлд дараах мэдээллийг заавал тусгасан байна. Үүнд:

2.3.1.Тухайн сүлжээнд харилцан холболт хийх технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага;

2.3.2 Зааглах цэгийн байршил;

2.3.3 Сүлжээнд харилцан холболт хийх төлбөр тооцооны мэдээлэл;

2.3.4 Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл;

2.3.5 Гэрээний загвар.

2.4.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг хангасан харилцаа холбооны үйлчлэгчид өөрийн сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлнэ.

2.5.Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO[2]) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:

2.5.1.Тухайн сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага;

2.5.2. Зааглах цэгийн байршил;

2.5.3. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл;

2.5.4. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл;

2.5.5. Гэрээний загвар.

2.6.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх зарчмыг баримтална.

2.9.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, орлого хуваарилах зарчим, төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй.

ТАВ. ЗААГЛАХ ЦЭГ ТОГТООХ НӨХЦӨЛ

5.1.Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийг Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.7, 22.3 заалтын дагуу Зохицуулах хороо энэхүү журмыг баримтлан Хавсралт 1-д заасны дагуу тодорхойлно. /3.1.7."зааглах цэг" гэж үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг;/, /22.3.Харилцаа холбооны сүлжээ хоорондын харилцан холболт болон сүлжээнд холбогдох зааглах цэгийг Зохицуулах хороо тогтооно./

5.2.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг болон сүлжээнд нь холбогдох зааглах цэгийн байршлыг энэхүү журмын Хавсралт 1-д заасны дагуу тодорхойлж, өөрийн сүлжээний "Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөл" болон "Сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл"-д тусгах бөгөөд хүсэлт гаргагч талд техникийн нөхцөл, сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболт хийх гэрээний төсөлд зааглах цэгийг нарийвчлан тогтоосон байна.

5.3.Харилцаа холбооны үйлчлэгч нь 5.1-г заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон зааглах цэгт сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

5.4.Хэрэв сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох хүсэлт гаргагч нь энэхүү журмын Хавсралт 1-д зааснаас өөр байршилд сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг тогтоолгохоор хүсэлт гаргавал харилцаа холбооны үйлчлэгч нь хүсэлтийн дагуу техникийн нөхцөлийн боломж байгаа эсэхийг тодорхойлж, дүгнэлтийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

5.5.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгээр тусгаарлан холбогдох хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг бүрдүүлж, хангана.

ДОЛОО. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

7.1.Талууд сүлжээ хоорондын харилцан холболтын болон сүлжээнд холбогдох зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцна.

7.2.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох гэрээгээр үзүүлж буй үйлчилгээний чанарын шаардлагыг энэхүү журмын 7.1-д заасны дагуу зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний хувьд хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

7.3.Сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт, гэмтэл саатлын үед ажиллах горим, хугацааг талууд урьдчилж харилцан тохиролцон тогтоох ба үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.

НАЙМ. СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО ХУВААРИЛАХ, СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТӨЛБӨР

8.1.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох үйлчилгээний өртгийг тооцохдоо Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах хэсэгт заасан харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал, ОУЦХБ-аас гаргасан зөвлөмж, аргачлал загвар, нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэнэ.

8.2.Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох талуудад ногдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалтгаалан өртгөө нөхсөн байна.

8.3.Сүлжээ хооронд харилцан холболт хийх болон сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлд тусгагдах сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох төлбөр болон сүлжээ хооронд харилцан холболт хийх үйлчилгээний орлого хуваарилах зарчмыг дараах байдлаар тогтооно. Үүнд:

8.3.1.Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд оролцогч талууд нь сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний төсөлд тусгах сүлжээ хооронд харилцан холболт хийх төлбөр болон сүлжээ хоорондын харилцан холболтын орлого хуваарилах зарчмын тухай харилцан тохиролцсон эцсийн саналыг, тохиролцоонд хүрээгүй бол тус тусын саналыг, үндэслэлийн хамт гэрээг шинээр болон шинэчлэн байгуулахаас ажлын 21 хоногийн өмнө Зохицуулах хороонд ирүүлнэ.

ЕС. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ БОЛОН СҮЛЖЭЭ ХООРОНД ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ГЭРЭЭ

9.1.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээг энэхүү журмын Хавсралт 2-т заасан загварын дагуу зөвхөн бичгээр, Монгол хэлээр байгуулна.


"Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам"-ын Хавсралт 1

ДӨРӨВ. ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ БОЛОН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ГАЗРЫН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧЛЭГЧИЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ЗААГЛАХ ЦЭГ

4.1.Радио, телевизийн үйлчлэгч болон олон сувагийн дамжуулах үйлчлэгч хооронд эсхүл радио, телевизийн үйлчлэгч болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгч

хоорондын холболтын зааглах цэг нь холболтын төрлөөс хамааран дараах байршлуудын аль нэг дээр байна. Үүнд:

- 4.1.1. Телевизийн үйлчлэгчийн гаралтын дохиог дамжуулах төхөөрөмж;
- 4.1.2. Олон суваг дамжуулах болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгчийн хүлээн авах төхөөрөмж;
- 4.1.3. Олон суваг дамжуулах болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгчийн хүлээн авах талын хувиргах төхөөрөмж (encoder);
- 4.1.4. Дундын холболтын цэг (Гуравдагч этгээдийн сүлжээгээр дамжин холбогдох тохиолдолд);



Зураг 6. Радио, телевизийн үйлчлэгч болон олон сувагийн дамжуулах үйлчлэгч хооронд эсхүл радио, телевизийн үйлчлэгч болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчлэгч хоорондын холболтын зааглах цэгийн байршил

"Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам"-ын

Хавсралт 2

Гэрээнд дараах зүйлүүдийг заавал тусгана. Үүнд:

2. Техникийн нөхцөл шаардлагын талаар:

2.1. Ашиглах техник, технологийн тухай, техникийн үзүүлэлтүүд;

2.3. Холбогдсон интерфэйсийн үзүүлэлтүүд;

2.7. Сүлжээний зааглах цэг, түүний байршил, техникийн үзүүлэлтүүд;

2.8. Холболтын болон сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал;

4. Төлбөр тооцооны талаар:

ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ, ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗӨВЛӨМЖ, ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

Харилцан холболтын болон сүлжээнд холбогдох зохицуулалт нь Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчимд тулгуурладаг бөгөөд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх зохицуулалтын нэг гол хүчин зүйл гэж үздэг.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5, 20.5.1-д радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох, техник холболтын зааглах цэг, нөхцөлийг тогтооход Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4-д заасан буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 26 тоот тогтоолоор батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг (цаашид “Харилцан холболтын журам” гэх) баримтлана гэж заасан.

Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18³⁵, 3.1.19³⁶-д “харилцан холболт”, “сүлжээнд холбогдох” харилцааг тус тус тодорхойлсон бөгөөд радио, телевиз нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдож, хөтөлбөрөө дамжуулж буй харилцаа нь “сүлжээнд холбогдох” гэдэгт хамаарна.

Харилцан холболтын журмын хүрээнд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийг “харилцаа холбооны үйлчлэгч”, харин сүлжээнд холбогдож байгаа тал болох радио, телевизийг “харилцаа холбооны үйлчилгээгээр үйлчлэгч” гэж томъёолсон.

³⁵ 3.1.18. “харилцан холболт” гэж хоёр үйлчлэгчийн сүлжээ хоорондын холболтыг;

³⁶ 3.1.19. “сүлжээнд холбогдох” гэж үйлчлэгч нь өөрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх зорилгоор сүлжээ бүхий үйлчлэгчийн сүлжээнд холбогдохыг;

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь Харилцан холболтын журмыг хэрэгжүүлэх, Сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO³⁷) боловсруулахад энэхүү зөвлөмжийг баримтална.

Энэхүү зөвлөмжийн хүрээнд байгуулах гэрээнд Харилцан холболтын журмаар зохицуулах зааглах цэг, холболт, дамжууллын талаарх техникийн харилцааг тусгах бөгөөд телевизийн бүтээл, контент, оюуны өмчийн харилцааг тусад нь авч үзэж, тусдаа гэрээ эсхүл нэмэлт гэрээ, хавсралтын хүрээнд зохицуулахыг зөвлөж байна.

НЭГ. ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Радио, телевиз нь олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох гэрээ байгуулах процесс, түүнд хамаарах харилцан холболтын журмын заалтуудыг дараах хүснэгтээр харуулав.

№	Хамаарах тал	Журмын заалт
1	ОСДҮЭ	5.1.Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийг Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.7, /3.1.7."зааглах цэг" гэж үйлчлэгч, хэрэглэгчийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэгийг;/ 22.3 /22.3.Харилцаа холбооны сүлжээ хоорондын харилцан холболт болон сүлжээнд холбогдох зааглах цэгийг Зохицуулах хороо тогтооно./ заалтын дагуу Зохицуулах хороо энэхүү журмыг баримтлан Хавсралт 1-д / Цахилгаан холбооны сүлжээ хоорондын зааглах цэг, зурагтай файл / заасны дагуу тодорхойлно.
2	ОСДҮЭ	2.5.Харилцаа холбооны үйлчлэгч нь өөрийн сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлийг (RAO) боловсруулан Зохицуулах хороогоор хянуулан баталж өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд дараах мэдээллийг заавал тусгасан байна. Үүнд: 2.5.1.Тухайн сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага; 2.5.2.Зааглах цэгийн байршил; 2.5.3.Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл; 2.5.4.Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл; 2.5.5.Гэрээний загвар.
5	ОСДҮЭ, ТВ, Суваг	8.3.2.Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээний нөхцөлд тусгах сүлжээнд холбогдох төлбөрийн тухай харилцан тохиролцсон эцсийн саналыг, тохиолцоогүй бол тус тусын саналыг үндэслэлийн хамт гэрээг шинээр болон шинэчлэн байгуулахаас ажлын 21 хоногийн өмнө Зохицуулах хороонд ирүүлнэ.

³⁷ RAO - Reference Access Offer

8	ХХЗХ	8.3.5.Энэхүү журмын 8.3.4-т заасны дагуу саналаа ирүүлээгүй эсвэл ирүүлсэн санал нь уг журмын 8.3.3-т заасан хүрээнд хянан үзэхэд хүлээн авах боломжгүй тохиолдолд Зохицуулах хороо нь сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээнд тусгах сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр болон орлого хуваарилах зарчмыг шууд тогтоож, шийдвэрийг гэрээнд оролцогч харилцаа холбооны үйлчлэгч нарт хүргүүлнэ.
9	ОСДҮЭ, ТВ, Суваг	8.3.6.Энэхүү журмын 8.3.5-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээний төрөл болон онцлогоос үл хамааран гэрээнд тусган мөрдөх сүлжээнд холбогдох төлбөр, сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр болон орлого хуваарилах зарчмыг Зохицуулах хорооны шийдвэрийн дагуу гэрээнд тусгаж, сүлжээнд холбогдох болон сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээг байгуулах үүрэгтэй.

**ХОЁР. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ (РАО)
БОЛОВСРУУЛАХ**

..... КОМПАНИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /РАО/
[боловсруулах загвар, зөвлөмж]

2. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ

[Харилцаа холбооны тухай хуулийн “22.2. Үйлчлэгч нь техникийн боломжийг харгалзан өөрийн сүлжээнд бусад сүлжээг саадгүй холбох нөхцөлийг хангана.” гэж заасныг анхаарах]

2.1. Сүлжээнд холбогдох зааглах цэгийн боломжит байршлуудыг дараах хүснэгтэд харуулав.

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	Тайлбар, нэмэлт мэдээлэл
Байршил 1:	
Байршил 2:	

[Харилцан холболтын журмын 2.6-д заасны дагуу ОСДҮЭ нь зааглах цэг дээр ялгаваргүй, ижил тэгш нөхцөл бүрдүүлэх хүрээнд холболтын боломж, нөөцийн мэдээллийг ХХЗХ болон үйлчилгээ эрхлэгчдэд нээлттэй мэдээлнэ.

Харилцан холболтын журмын 5.2-д заасны дагуу зааглах цэгийн байршилг ОСДҮЭ тодорхойлж байгаа тохиолдолд уг цэгийг ОСДҮЭ-ийн сүлжээний нэг хэсэг гэж үзэх бөгөөд ашиглалт үйлчилгээг ОСДҮЭ бүрэн хариуцна.]

2.2 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студийс зааглах цэг хүртэлх сүлжээг (сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэрэг) хариуцна.

[Харилцан холболтын журмын 5.4-д заасны дагуу Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох холболтын зааглах цэгээр тусгаарлан холбогдох хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийн бүрдүүлж, хангана.]

Харилцан холболтын журмын 7.2-д заасны дагуу талууд сүлжээнд холбогдох зааглах цэгээс 2 тийш тус тусын сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцна.]

2.3. Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэгийг дээр зааснаас өөр цэгт тогтоох саналтай бол хүсэлтийг албан бичигтээ тодорхой дурдаж, техникийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ирүүлнэ. Хэрвээ тус зааглах цэг нь Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын Хавсралт 4-д зааснаас өөр газарт байрлах бол албан бичгийн хувийг Зохицуулах хороонд илгээж, шийдвэрлүүлнэ.

2.5 Холболтын схем, зураглал

[Телевиз талын дамжуулах төхөөрөмж, холболтын зааглах цэг, ОСДҮЭ-ийн хүлээн авах төхөөрөмж зэрэг шаардлагатай төхөөрөмжийг оролцуулж, холбогдох мэдээллийг тэмдэглэсэн схем зураг оруулах]

3. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл

[ОСДҮЭ нь Телевизийг холбож, дамжуулахад төлбөр авдаг бол төлбөрийн үндэслэл, задаргааг ойлгомжтой, тодорхой тайлбарласан байна. Мөн ямар тохиолдолд төлбөр авахгүй тухай тайлбарлана.]

[Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын 2.9-д заасны дагуу Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй, мөн журмын 8-р хэсгийг баримтална.]

	Төлбөрийн задаргаа	Үндэслэл, тайлбар	Төлбөрийн хэмжээ	Төлөх хугацаа, давтамж
1				
2				

4. Гэрээний загвар

[Гэрээнд тусгавал зохих зүйл, заалтуудыг багтааж, гэрээний загварыг боловсруулан доор зөвлөмж болгов.]

Энэхүү гэрээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

Дөрөв. Төлбөр тооцоо

Хавсралт 1. Холболт хийх техникийн үзүүлэлт

Хавсралт 2. Зааглах цэгийн байршил, зураглал

Хавсралт 4. Төлбөрийн мэдээлэл

Хоёр. Техникийн нөхцөл, зааглах цэг

2.1. Холболт хийх техникийн нөхцөл:

2.1.1. Холболт хийхэд шаардагдах техник төхөөрөмж, түүнд тавигдах шаардлага, стандарт үзүүлэлт зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байна. Хавсралт 1-д орсон өөрчлөлтийг тухай бүр тусгаж байна.

2.1.2. Телевизийн студиас ирэх дохио нь Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хангасан байна.

2.1.3. Талуудын сүлжээ хооронд холболт хийх дамжуулах шугам нь __ (өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ) __ байна.

2.2. Зааглах цэг:

2.2.1. Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.

2.2.2. Сүлжээний зааглах цэгийн байршил, холболтын зураглал нь Хавсралт 2-т заасны дагуу байна.

2.2.3. Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

Гурав. Ашиглалт үйлчилгээ

3.1. Зааглах цэгээс 2 тийш Талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ буюу бүрэн бүтэн байдал, тасалдалгүй найдвартай ажиллагаа, чанарын хяналт, гэмтэл засварыг хариуцна.

[Зааглах цэг хүртэл түрээсийн шугам ашиглаж байгаа бол тус шугам, сүлжээний ашиглалт үйлчилгээ, найдвартай ажиллагаа түүнтэй холбоотой бусад асуудлыг тусдаа гэрээгээр зохицуулах, ЭСВЭЛ телевизийн студээс Зааглах цэг хүртэлх сүлжээг Дамжуулагч тал хариуцах бол ашиглалт үйлчилгээ түүнтэй холбоотой төлбөр тооцоо зэргийг ойлгомжтой, тодорхой зааж өгөх]

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1. Телевиз нь энэхүү гэрээний хавсралт 4-д заасан төлбөрийг гэрээ байгуулснаас хойш ажлын хоногийн дотор Дамжуулагчийн банкны дансанд шилжүүлнэ. [Төлбөр авахгүй бол шаардлагагүй.]

4.2. Хавсралт 4-д заасан төлбөрийн хувийг Хавсралт ____-д заасан бартерын зарчмаар барагдуулна. [Төлбөрийг бартераар барагдуулах тохиолдолд энэ заалтыг ашиглаж болно.]

4.3. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь төлбөрийн тооцоог сар бүр нийлнэ. Холбогдох ажилтны мэдээллийг Хавсралт 3-д заасан. Ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй. [Төлбөр авахгүй бол шаардлагагүй.]

ын холболт, дамжууллын
20... оны . . . тоот
гэрээний хавсралт 1

ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Телевизийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт (PAL)	[SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.]
	[HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.]
Дууны оролт	[Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)]
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дэлгэцийн харьцаа	[4:3, 16:9]
SD нягтрал /пикселийн тоо/	[SD-SDI 625@50i гэх мэт]
HD нягтрал /пикселийн тоо/	[HD-SDI, 1080@50i, шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264) гэх мэт]
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	[Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, эгшин зуурын утга нь ± 1 байна.]
Дууны кодлол	[Сtereo, MPEG layer 1, 2, 3 , AAC, AES гэх мэт]

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

[Телевизийн студийн гаралтын дамжуулах төхөөрөмжөөс ОСДҮЭ дээр байрлах хүлээн авах төхөөрөмж хүртэлх болон холболтод ашиглагдах төхөөрөмжүүдийн мэдээллийг оруулна. Зааглах цэгээр тусгаарлан төхөөрөмжийг хамаарах талуудын дор бичнэ.]

Холболтын техник, төхөөрөмжийн нэр, зориулалт	Телевиз талд	Дамжуулагч талд (ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж (Encoder) түүний төрөл, марк, сериал дугаар		

Дамжуулах (Tx) / Хүлээн авах (Rx) төхөөрөмж түүний төрөл марк, сериал дугаар	Tx	Rx
Холбох шугамын төрөл, үзүүлэлт: 1 core fiber optic гэх мэт.		
Холболтын интерфэйс: HD-SDI, SD-SDI 75 Ом BNC, GbE-MPEGoIP гэх мэт өөрсдийн технологиос хамааруулан сонгож бичнэ.		
Бусад....		

_____ -ын холболт,
дамжууллын 20... оны . . .
тоот гэрээний хавсралт 2

ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ

	<i>Хаяг</i>
Зааглах цэгийн байршил	
Тоног төхөөрөмж	

ХОЛБОЛТЫН ЗУРАГ

[Телевизийн дамжуулах төхөөрөмжөөс ОСДҮЭ-ийн хүлээн авах төхөөрөмж хүртэл ашиглагдаж байгаа бүх төхөөрөмж, хөрвүүлэх төхөөрөмж, тэдгээрийн холбогдсон байдлыг схем зургаар харуулж, зааглах цэгийг тэмдэглэх]